



ТАЙЛАН

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв



МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ



ТАЙЛАН

(2025.01.01-2025.12.31)

2026 он



ТӨВИЙН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв (Цаашид Монгол-Японы төв гэх) нь Монголын зах зээлийн эдийн засагт хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг хөгжүүлэх Монгол, Япон хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (Цаашид ЖАЙКА гэх), Боловсрол, Шинжлэх ухааны яам болон МУИС-ийн хамтарсан төсөл хэлбэрээр 2002 оноос үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Одоо бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсрол, хамтын ажиллагаа гэсэн үндсэн үйл ажиллагаа явуулдаг. 2012 оноос япон хэлний боловсрол болоод хоёр орны хамтын ажиллагааны хувьд Япон сантай хамтран ажиллаж байна. Мөн өнөөг хүртэл бий болгосон харилцаа холбоогоо үр дүнтэйгээр ашиглан Япон, Монголын бизнесийн гүүр болон ажиллахыг зорьж байна.

| | |
|---------------------|--|
| 2002 он 01 сарын 22 | ЖАЙКА болон МУИС-ийн оролцоотойгоор Төслийн нэгдүгээр үе шатыг эхлүүлсэн. |
| 2002 он 03 сарын 14 | Япон улсын засгийн газрын буцалтгүй тусламжаар Монгол-Японы Төвийн барилга байгууламж тоног төхөөрөмжийг (нийт 4.43 сая ам доллар) хүлээлгэн өгсөн. (Барилгын талбайн хэмжээ нь 1,520 m ² , нийт талбайн хэмжээ нь 7,000 m ²) |
| 2002 он 06 сарын 21 | Албан ёсны нээлтийн үйл ажиллагаанд Японы эрхэм дээд ханхүү Акишинономия, Гүнж Кикогийн хамт оролцсон. |
| 2007 он 01 сарын 22 | Төслийн хоёрдугаар үе шат эхэлсэн. (2012 оны 1 сарын 21 хүртэл) |
| 2007 он 07 сарын 16 | Төвийн 5 жилийн ойн арга хэмжээнд Японы эрхэм дээд угсаа залгамжлах ханхүү Нарүхито морилон ирсэн. |
| 2009 он 07 сарын 03 | Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 1,000,000-д хүрсэн. |
| 2012 он 01 сарын 22 | ЖАЙКА-ын техникийн хамтын ажиллагаа бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх төслийг эхлүүлсэн |
| 2012 он 04 сарын 01 | Япон сангийн хэлний төвийн төслийг эхлүүлсэн. |
| 2012 он 04 сарын 13 | Монгол Улсын Их Сургуулийн бүрэлдэхүүн, санхүүгийн бие даасан нэгж болсон. |
| 2012 он 06 сарын 21 | Төвийн 10 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан. |
| 2015 он 04 сарын 22 | Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх төслийг эхлүүлсэн. |
| 2016 он 04 сарын 01 | Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 2,000,000-д хүрсэн. |
| 2017 он 06 сарын 14 | Канэко Харүкогийн вааран урлалын “Аз жаргалын цэнхэр хана” бүтээлийн нээлтийн ёслол. |
| 2017 он 06 сарын 21 | Төв байгуулагдсаны 15 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан. |
| 2020 он 04 сарын 22 | Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх, бизнесийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх төсөл |
| 2020 он 10 сарын 19 | Үйлчлүүлэгчдийн тоо давхардсан тоогоор 2,500,000-д хүрсэн. |
| 2022 он 06 сарын 21 | Төв байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулсан. |



АЛСЫН ХАРАА

- Монгол улсын ирээдүйн хөгжилд хувь нэмэр оруулахуйц хүний нөөцийг бэлтгэж, Монгол, Япон хоёр улсыг холбогч гүүр болон ажиллах болно.

ЭРХЭМ ЗОРИЛГО

- Үйлчлүүлэгчдийн эрэлтэд нийцсэн үйлчилгээ бий болгон хэрэгжүүлж, Монгол, Япон хоёр улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулна.

УРИА

- Монголын ирээдүйг энд хөгжүүлье!

ҮНЭТ ЗҮЙЛС

- ✓ Монгол дахь япон орчин
- ✓ Япон маягийн үйлчилгээ, японы талаарх мэдээллийг түгээх
- ✓ Японд хуримтлуулсан мэдлэг, мэдээллийг түгээх
- ✓ Чадварлаг Монгол, Япон ажилтнуудын баг
- ✓ МУИС болон бусад байгууллагуудын хамтын ажиллагаа
- ✓ ЖАЙКА, Япон сан ба японы бусад байгууллагуудын хүчтэй дэмжлэг



ГАРЧИГ

ӨМНӨХ ҮГ

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн захирал Ц.Даваадорж.....8

МЭНДЧИЛГЭЭ

| |
|--|
| Япон улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин сайд Игавахара Масарү.....9 |
| МУИС-ийн ректор, профессор Б.Очирхуяг.....10 |
| ЖАЙКА Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга Мияаги Кэнсүкэ.....11 |
| Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан Япон хэлний 1-р хэлтсийн дарга Ёцүя Томоаки.....13 |
| Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Ерөнхий зөвлөх, ЖАЙКА-ын мэргэжилтэн Сато Мүцүми15 |

I. БИЗНЕСИЙН СУРГАЛТЫН ТАСАГ

| |
|--|
| 1. 2025 онд зохион байгуулсан бизнесийн сургалт, семинарын тайлан.....17 |
| Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хэрэгжилт.....17 |
| 1) Танхимын сургалт “Бизнесийн сургалт”18 |
| 2) “Ажлын байран дээрх сургалт” болон “Загвар аж ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр”21 |
| 3) Япон дахь дадлага сургалт.....21 |
| 2. Онцлох мэдээ.....37 |
| 1) Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн багш Кавагүчи Шиничиро /Ph.D/ Монгол улсын төрийн дээд шагнал Алтангадас одонгоор шагнууллаа.....26 |
| 2) Хоккайдогийн Их сургууль багш профессоруудтай хамтарсан сургалт семинар.....26 |
| 3) Васэда Их сургуулийн багш профессоруудтай хамтарсан сургалт семинар.....28 |
| 4)Төгсөгчдийн сэтгэгдэл.....30 |

II. БИЗНЕСИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ

| |
|--|
| 1. 2025 онд зохион байгуулсан монгол японы бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагааны тайлан.....33 |
| 2. Онцлох мэдээ.....37 |



| | |
|--|----|
| 1) Монгол-Японы олон улсын бизнес инновацын форум-2025..... | 37 |
| 2) Монгол-Японы төвийн бизнесийн сургалтын үе үеийн төгсөгчдөд зориулсан үйл ажиллагаа..... | 39 |
| 3) Төв азийн орнуулын япон төвүүдээр зочилж туршлага судаллаа..... | 40 |
| 4) Монгол улсын “Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах” сэдэвт Япон дахь дадлага сургалтыг амжилттай зохион байгууллаа..... | 42 |

III. ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТАСАГ

| | |
|--|-----------|
| 1. 2025 онд зохион байгуулсан япон хэлний сургалт, семинарын тайлан..... | 45 |
| 1) Япон хэлний сургалтын талаар..... | 45 |
| 2) Хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны талаар..... | 46 |
| 2. Онцлох мэдээ..... | 70 |
| 1) Япон хэлний заах арга зүйн сургалтын хэрэгжилт /Япон хэлний заах арга зүйн сургалт, ЕБС-ийн багш нарт зориулсан япон хэлний заах аргын семинар, “Иродори” сурах бичгийн заах арга зүйн семинар..... | 61 |
| 2) Монгол-Япон хоёр орны найрамдалт харилцаа, эрхэм түншлэлийг билэгдэн зохион байгуулсан “Япон хэлээр бяцхан ном бүтээцгээе-2025 уралдаан..... | 63 |
| 3) Монгол-Японы төвд хэрэгжиж буй Япон улсад ажиллаж, сурахын өмнөх хэлний бэлтгэл сургалтын хэрэгжилт ба үр дүн..... | 65 |
| 4) Биечлэн танилцаж суралцах япон соёлын танилцуулах хичээл... .. | 68 |
| 5) “Тусгай ур чадварын тогтолцоо” гэрээт ажлын хүрээнд..... | 70 |
| 3. Гэрээт сургалт, үйл ажиллагааны хүрээнд..... | 70 |
| 1) Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (JFT-Basic)-тай хамаарах ажил..... | 70 |
| 2) Япон хэлний багш нарыг дэмжих үйл ажиллагаа..... | 70 |
| 3) Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт..... | 72 |
| 4) JICA-ийн дадлага хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалт..... | 72 |
| 4. Суралцагчдын дуу хоолой..... | 73 |

IV. НОМЫН САН, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ

| | |
|--|-----------|
| 1. 2025 оны үйл ажиллагааны ерөнхий тайлан..... | 78 |
|--|-----------|



| | |
|---|------------|
| 1) Номын сангийн үйл ажиллагаа..... | 78 |
| 2) Орчуулагч уншигчдын уулзалт..... | 79 |
| 3) Нээлттэй семинар..... | 79 |
| 4) 16 дахь удаагийн Японд суралцах тухай мэдээллийн яармаг-2025..... | 79 |
| 5) Гэрээгээр гүйцэтгэх ажил..... | 80 |
| 6) Арван хурууны бичээчийн сургалт..... | 81 |
| | |
| 2. Онцлох мэдээ..... | 96 |
| 1) “Японд суралцах тухай мэдээллийн яармаг -2025” үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдлаа..... | 85 |
| 2) Монголд анх удаа “Японы ахлах сургуулиудын мэдээллийн яармаг” зохион байгуулагдлаа..... | 87 |
| 3) Япон сангийн “Нихонго партнерс илгээх хөтөлбөр” хэрэгжиж эхэллээ..... | 89 |
| 4) Олон нийтэд зориулсан монгол, япон соёлын танилцуулга тусгай сургалт, нээлттэй семинар..... | 91 |
| | |
| V. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ТАСАГ | |
| 1. 2025 оны үйл ажиллагааны ерөнхий тайлан..... | 107 |
| 2. Онцлох мэдээ..... | 110 |
| 1) Ажлын хэсэг..... | 110 |
| 2) Монголтой холбогдсон 50 жил семинар зохион байгууллаа | 110 |
| | |
| VI. БАГУУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА | |
| 1. 2025 оны багуудын үйл ажиллагааны тайлан..... | 112 |
| 1) Маркетингийн баг..... | 112 |
| 2) 5S Кайзен баг..... | 113 |
| 3) Эрүүл мэнд, спортын баг..... | 115 |



ӨМНӨХ ҮГ



Жилийн ажлаа нэгтгэн тайлагнах бидний уламжлалт ажил хийгдэж, 2025 оныхоо ажлын тайлангаа Та бүхэнд танилцуулж байгаадаа баяртай байна.

2025 онд төвийн ажил төлөвлөсний дагуу амжилттай үргэлжилж, олон сайхан ажлуудыг шинээр хийлээ. Он оны ажлаа амжилттай гүйцэтгэж, улам өргөжин тэлж, хөгжин дэвшиж байдгаа тайлагнахад бид туйлын их баяр бахдалтай байдаг. 2025 онд ЖАЙКА-гийн төслийн шинэ үе шат эхэлж, Япон мэргэжилтнүүд ээлжлэн солигдсон юм.

2025 онд бид 289 ажил төлөвлөж, 296 ажил гүйцэтгэлээ. Төлөвлөсөн ажлуудаас 5 ажил хийгдээгүй ч, төлөвлөөгүй 12 ажлыг шинээр хийж, нийт дүнгээрээ ажлын гүйцэтгэл 102%-тай гарав. Өмнөх 2024 оныхоос

ахисан энэ үзүүлэлтийг тайлагнахад урамтай байна.

2025 онд, манай байгууллагад үндсэн ажилтан 31, япон мэргэжилтэн 4, хүлээн авахын цагийн ажилтан 12, мөн цагийн багш 5, үндэсний сургагч багш 8 хүн ажиллалаа. Энэ жилийн хувьд ажилтнуудын хөдөлгөөн өмнөх үеүдээс өндөр гарсан. Төвийн нийт ажиллагсдын дундаж цалин 2.4 сая төгрөгт хүрч, өмнөх жилээс 10%-иар өсжээ. Монгол улсын дундаж цалингийн түвшинд байгаа ч бодит орлого өмнөх түвшинд хадгалагдаж байгаа юм.

Япон улсаас 4 мэргэжилтэн урт хугацаагаар томилогдон ажиллаж байна. 1 мэргэжилтэн томилогдон ирэх байсан ч хугацаандаа ирж амжсангүй.

2025 оны хүлээгдэж буй дүнгээр төлөвлөгөөт орлогыг 2.1%-иар давуулж, зарлагаа 3.1%-иар хэмнэж чадлаа. Япон улсын ЖАЙКА байгууллага болон Япон сангийн дэмжлэг урьдын адил үргэлжилж байна. Жилийн нийт төсвийн 13 хувийг Япон талын дэмжлэгээр санхүүжүүлсэн.

2025 оны тайланг өмнө жилийн нэгэн адил цахим хэлбэрээр гаргасан бөгөөд тайлангийн дэлгэрэнгүйг энэ товхимлоос харах боломжтой.

Бидний үйл ажиллагааг ямагт дэмжиж, тусалж байдаг хамтран ажиллагч Японы болон Монголын бүх байгууллага, хувь хүмүүст халуун талархлаа дахин дахин илэрхийлье. Та бүхний дэмжлэг, туслалцаа, хамтын ажиллагаа байгаа учраас манай төвийн үйл ажиллагаа үргэлж урагш ахиж, амжилт дүүрэн байдаг.

Манай хамт олон ч цаашид ихээр хичээн, өөрсдийн чадвар, мэдлэгээ бүрэн дайчлан ажиллах болно. Та бүхний дэмжлэг, туслалцаа, хамтын ажиллагааг амжилттай болгон, төвийнхөө нэр хүндийг өндөрт өргөн явахаа амлаж байна.

Монголын ирээдүйг гэрэлтэй, гэгээлэг болгохын төлөө МЯТ-ийн хамт олон ажил үүргийнхээ хүрээнд бүхнийг хийх болно. Бүх хүмүүст сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Баярлалаа

*Монгол-Японы Хүний Нөөцийн хөгжлийн төвийн
Захирал Ц.Даваадорж*



МЭНДЧИЛГЭЭ



2025 оны хоёр улсын харилцааг эргэн харахад, юуны түрүүнд хоёр орны харилцааны түүхэнд алтан үсгээр тод тэмдэглэгдэх томоохон үйл явдал нь Япон Улсын Цог жавхлант Эзэн Хаан, Эрхэм дээд Хатан нарын Монгол Улсад хийсэн айлчлал санаанд бууж байна. Монголын ард түмэн халуун дотноор хүлээн авч, Хаан, Хатан нар ч Монгол дахь айлчлалдаа сэтгэл нэн хангалуун буцсан билээ. Энэхүү айлчлалыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх болон Монгол Улсын Засгийн газар, холбогдох байгууллагууд, хоёр орны харилцааг хөгжүүлэхийн төлөөх бүх хүмүүсийн хамтын ажиллагаа, дэмжлэг туслалцаа үлэмж байсныг цохон тэмдэглэхэд таатай байна. Уг айлчлалаар дамжуулан хоёр орны найрамдалт харилцаа улам бүр бэхэжсэн гэдэгт би хувьдаа бүрэн итгэлтэй байна. Айлчлалыг зохион

байгуулахад оролцсон бүх хүмүүст дахин гүн талархал илэрхийлье.

Хоёр улсын харилцааны тухайд, 2022 онд тунхагласан “Энх тайван, хөгжил цэцэглэлтийн төлөөх Тусгай стратегийн түншлэл”-ийн хүрээнд улс төр, эдийн засаг, нийгэм, соёл, эрүүл мэнд, спорт зэрэг олон салбарт хамтын ажиллагаа тогтвортой өргөжин гүнзгийрч байна. Улс хоорондын харилцааг хөгжүүлэхэд хамгийн чухал үндэс суурь нь “хүн” бөгөөд ялангуяа залуу боловсон хүчин нэн шаардлагатай байна. Цог жавхлант Эзэн Хаан, Эрхэм дээд Хатан нарын айлчлалыг хоёр улсын харилцааны оргил цэг гэж үзэлгүйгээр, цаашид илүү өндөр түвшинд гаргахын тулд салбар бүрт дараагийн үеийг залгамжлах боловсон хүчнийг бэлтгэх зайлшгүй шаардлагатай юм. Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь байгуулагдсан цагаасаа эхлэн бизнесийн сургалт болон япон хэлний боловсролоор дамжуулан олон боловсон хүчнийг бэлтгэж ирсэн бөгөөд тус төвийн гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэж, хоёр орны харилцааны голлох цэг болно гэдэгт ихээхэн итгэл хүлээлгэж байна.

Япон төв нь Японы буцалтгүй тусламжаар байгуулагдаад 20 гаруй жил өнгөрч байгаа бөгөөд санхүүгийн бие даасан нэгжийн хэлбэрт шилжсэнээс хойш ч олон жилийн турш хуримтлуулсан туршлага болон ажилтнуудынхаа шинэлэг санаачилгад тулгуурлан хоёр орны соёл, бизнесийн харилцааг дэмжих үйлсэд тууштай зүтгэж ирсэн билээ. Өнгөрсөн оны 5 дугаар сараас Япон төв дээр ЖАЙКА-гийн хамтын ажиллагааны шинэ төсөл хэрэгжиж эхэлсэн. Япон төв цаашид Японы мэдлэг туршлагыг нэвтрүүлж, хоёр орны бүхий л шатны харилцааг холбох суурь болж биеэ даахын тулд, улам бүр хөгжиж идэвхтэй үйл ажиллагаа явуулна гэдэгт найдаж байна. Түүнчлэн, Япон төвд суралцсан олон залуус ирээдүйд Монгол Улсын хөгжлийг түүчээлж, хоёр орны харилцааг улам бүр хөгжүүлэхэд хувь нэмэр оруулаасай хэмээн хүсэж байна.

*Япон Улсаас Монгол Улсад суугаа
Онц бөгөөд Бүрэн Эрхт Элчин Сайд Игавахара Масарү*



МЭНДЧИЛГЭЭ



МУИС-ийн Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Монгол, Япон хоёр улсын стратегийн түншлэлийг боловсрол, хүний нөөц, бизнес, инновацад суурилсан хамтын ажиллагаагаар бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсээр ирсэн билээ. Тус төв нь хүний нөөцийн чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх, хоёр орны эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжилд бодитой хувь нэмэр оруулах зорилтыг тууштай хэрэгжүүлж байна.

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн үйл ажиллагаа нь төр, их сургууль, хувийн хэвшил, олон улсын байгууллагын хамтын ажиллагаанд суурилсан үр дүнтэй загварыг бүрдүүлж, Монгол-Японы харилцааг урт хугацаанд тогтвортой хөгжүүлэх бодлогын чухал тулгуур болж байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй.

Төвийн үйл ажиллагааг тогтмол дэмжин ажиллаж ирсэн Монгол дахь Япон улсын элчин сайдын яам, ЖАЙКА, Япон сан, Монгол Улсын Боловсролын яам, Сангийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам болон бусад түнш байгууллагуудад гүн талархал илэрхийлье.

2025 оноос Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн төслийн шинэ үе шат эхэлсэнтэй холбогдуулан сургалт, судлагаа, бизнесийн хамтын ажиллагаа, бодитоор хэрэгжиж хоёр орны эдийн засгийн өрсөлдөх чадварыг дэмжих, ирээдүйн хөгжлийн тулгуур болсон хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн хамт олон, хамтран ажиллагч түншүүдийн хамтын хүчин чармайлт бэхжиж, хоёр орны хамтын ажиллагаа өргөжих болтугай.

МУИС-ийн ректор, профессор Б.Очирхуяг



МЭНДЧИЛГЭЭ



Монгол-Японы Хүний нөөцийн хөгжлийн төвд хэрэгжиж буй ЖАЙКА-гийн хамтын ажиллагаа нь 2025 оноос эхлэн "Монгол, Японы эдийн засгийн түншлэлийг бэхжүүлэхэд чиглэсэн бизнесийг дэмжих төсөл" хэмээх шинэ үе шатандаа шилжлээ.

Япон төв нь 2002 онд Японы засгийн газрын буцалтгүй тусламжаар байгуулагдсан бөгөөд түүнээс хойш ЖАЙКА нь хамтын ажиллагаагаараа дамжуулан тус төвийн үйл ажиллагааг тасралтгүй дэмжиж ирсэн билээ. Өмнөх шатны 5 жилийн хугацаанд цар тахал болон олон улсын хэмжээнд тодорхойгүй нөхцөл байдал үргэлжилж байсан хэдий ч бид Монголын хувийн хэвшлийн хөгжил, тогтвортой байдлыг бэхжүүлэхэд хувь нэмэр оруулсаар ирсэн юм. Япон төвийн үйл ажиллагааг өнөөдрийг хүртэл дэмжин ирсэн холбогдох бүх талуудын хичээл зүтгэлд чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Монгол Улс байгалийн баялгаас хамааралтай байдлаас гарч, аж үйлдвэрийг төрөлжүүлэх, тогтвортой өсөлтийг хангах зорилт тавьж, "Алсын хараа 2050" зэрэг үндэсний бодлогын хүрээнд тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Ялангуяа Япон улстай тогтоосон харилцааны хувьд, Монгол-Японы Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр (ЕРА) байгуулагдсаны 10 жилийн ой энэ жил тохиож байгаа бөгөөд хоёр орны бизнес хамтын ажиллагааг улам бүр идэвхжүүлэх хүний нөөцийг бэлтгэх болон аж ахуйн нэгжүүдийг хөгжүүлэх нь нэн чухал асуудал юм.

Эдгээр хэрэгцээ шаардлагад нийцүүлэн, ЖАЙКА-гийн хамтын ажиллагааны шинэ үе шатанд Японы өндөр түвшний мэдлэг туршлагад тулгуурласан бизнесийн шинэ сургалтуудыг нэвтрүүлж байна. Үүнд Японы их сургуулиуд болон хувийн хэвшилтэй хамтран "Бизнесийг төрөлжүүлэх", "Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан семинар", "Бизнесийн симуляци" зэрэг мэргэшсэн сургалтуудыг явуулж, Япон төвийн мөн удирдлага, чиглүүлгийн чадавхыг бэхжүүлэхийг зорьж байна.

Мөн бизнесийн харилцаа, хамтын ажиллагааг дэмжих ажлын хүрээнд Монгол-Японы Бизнес Инновацын Форумыг төлөвлөх, удирдан явуулах, гүйцэтгэх захирлуудад зориулсан бизнесийн сургалтыг төгсчдийг хамруулсан Япон Улсад зохион байгуулах сургалт, Ази тивийн хамгийн томоохон хүнс, шингэн хүнсний үзэсгэлэн болох FOOD EX JAPAN-д Монгол павильон амжилттай оролцох, Монголын аж ахуйн нэгжүүдийн оролцоог дэмжих зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлж, эдгээр бодит бизнесийн харилцаа, түншлэл, бизнесийн холболт (matching)-ыг дэмжих үйл ажиллагаа нь шинэ төсөлд мөн адил голлох ажлуудын нэг байх болно.

Үүнээс гадна, Монголын их, дээд сургууль болон техникийн КООСЭН-гийн оюутнуудыг Япон улсын компаниудад дадлагажуулах хөтөлбөрийн хүрээнд “Япон явахын өмнөх сургалт” (япон хэл, соёлын ойлголт, бизнесийн ёс зүй зэрэг)-ийг



хэрэгжүүлж, “Японы их дээд сургууль, ахлах сургуулийн мэдээллийн яармаг”-ийг жилд 2 удаа зохион байгуулж байна.

Шинэ төсөл хэрэгжих хүрээнд ЖАЙКА нь Япон төвийг цаашид Монгол, Япон хоёр улсын хамтын ажиллагааны гүүр болон, бизнесийн хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, хоёр улсын бизнесийн харилцаа, хамтын ажиллагааг улам бүр өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлсээр байх болно.

Цаашид ч та бүхний дэмжлэг, хамтын ажиллагааг хүлээн авч, гүн талархал илэрхийлье.

***ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын дарга
Мияаги Кэнсүкэ***



МЭНДЧИЛГЭЭ



Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь /цаашид Монгол-Японы төв гэх/ 2002 онд үүсгэн байгуулагдсанаас хойш Монгол улсын нийгэм эдийн засгийн хөгжил, Монгол-Япон хоёр орны харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах олон тооны хүний нөөцийг амжилттай бэлтгэж ирсэн билээ.

Япон сан нь тус төвийн үйл ажиллагааны үндсэн дөрвөн багана болох бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх, япон хэлний боловсролыг түгээн дэлгэрүүлэх, хоёр орны харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх, Монголын хүний нөөцийг хөгжүүлэх зорилго бүхий үйл ажиллагаануудаас япон хэлний боловсрол болон харилцаа хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллаж ирлээ.

2025 он бол Япон Улсын Цог Жавхлантай Эзэн Хаан, Эрхэм Дээд Хатны хамт Монгол улсад төрийн айлчлал хийж, хоёр орны харилцаанд онцлох түүхэн жил боллоо. Энэхүү түүхэн жилийг тохиолдуулан Япон сан нь Монгол-Японы төвтэй хамтран, хоёр орны найрамдалт харилцаа, эрхэм түншлэлийг билэгдэн “Япон хэлээр бяцхан ном бүтээцгээе-2025” уралдааныг амжилттай зохион байгууллаа. Мөн энэхүү түүхэн айлчлалыг тохиолдуулан цайны ёслолын дэг жаягийн талаар танилцуулах семинарыг зохион байгуулж, Монгол хүмүүст Япон улсын соёл, уламжлалаас танилцуулах зэргээр, тус төвийн үйл ажиллагаагаар дамжуулан соёлын харилцаа, хамтын ажиллагааг гүнзгийрүүлэн ажиллаж ирлээ.

Япон хэлний боловсролын салбарт Япон сан нь 2012 оноос хойш “Япон сангийн япон хэлний боловсролын стандарт”-д суурилсан япон хэлний сургалтыг Монгол-Японы төвтэй хамтран зохион байгуулж ирсэн билээ. Анхан шатнаас дунд шат хүртэлх цогц сургалтуудаас гадна, өсөн нэмэгдэж буй нийгмийн эрэлт хэрэгцээнд уялдуулан "Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт", "Бизнесийн япон хэлний сургалт"-уудыг зохион байгуулж байна. Түүнчлэн “Тусгай ур чадварын тогтолцоо” гэрээт ажил болон “ЖАЙКА-ын дадлага хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалт”, мөн “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалт”-уудыг зохион байгуулснаар төвийн багш мэргэжилтнүүдтэй хамтран Япон улсад ажиллаж амьдрах, суралцах зорилго бүхий өндөр ур чадвартай хүний нөөцийг бэлтгэх тал дээр хамтран ажиллаж байна.

Япон сан нь хоёр орны хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэхийг гол зорилго болгон ажиллаж буй номын сан, хамтын ажиллагааны тасгийн үйл ажиллагааг дэмжиж ирсэн билээ. 2025 онд бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо 30,000 давж, бүтэн жилийн хугацаанд 5,000 гаруй хүн Японы талаарх мэдээлэл авсан байна. Мөн Япон сан нь



Монгол-Японы төвтэй хамтран Японы уран зохиолын орчуулагчтай хийсэн уулзалт семинараар дамжуулан Монголчуудад Япон орныг илүү ойроос танин мэдэх боломжийг олголоо.

Бидний үйл ажиллагааны гол цөм нь хүмүүс хоорондын харилцаа холбоо байсаар ирсэн билээ. Япон хэлний сургалтын нэгэн суралцагч “Япон хэл сурснаар урагш тэмүүлэх хандлага аяндаа төлөвшсөн” хэмээн хэлсэнчлэн Монгол-Японы төвд суралцаж хуримтлуулсан мэдлэг тань та бүхний өөрийгөө хөгжүүлэх үйлд дэмжлэг болж байгаад бид туйлын баяртай байна.

2025 оны 10 дугаар сард хоёр орны харилцан ойлголцол, хамтын ажиллагааг улам бүр гүнзгийрүүлэх зорилго бүхий богино хугацааны “Нихонго партнерс” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүллээ. 2026 оны 10 дугаар сард урт хугацаагаар 5 хүнийг илгээхээр төлөвлөж байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагаа нь хоёр орны иргэд хоорондын харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх шинэ боломж, шинэ хөшүүрэг болно хэмээн найдаж байна.

Япон сан нь цаашид ч гэсэн Монгол-Японы төвийн үйл ажиллагаагаар дамжуулан Монгол хүмүүст япон хэлийг суралцах, япон соёлтой танилцах боломжийг олгохын төлөө хичээн ажиллах болно.

Эцэст нь хэлэхэд, Монгол-Японы төв нь Монгол дахь япон хэлний боловсрол, япон соёлыг түгээн дэлгэрүүлэх гол цөм байгууллага болон улам бүр хөгжин бэхжиж, хоёр орныг холбох гүүр болох хүний нөөцийг олноор төрүүлэн гаргахыг чин сэтгэлээс хүсэн ерөөж байна.

*Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан
Япон хэлний 1-р хэлтсийн дарга Ёцүя Томоаки*



МЭНДЧИЛГЭЭ



2025 оны 4-р сараас эхлэн 5 жилийн хугацаатай ЖАЙКА-ийн хамтын ажиллагааны шинэ төсөл хэрэгжиж эхэллээ. Энэхүү төслийн гол зорилго нь Монголын бизнесийн салбарын хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, Япон болон Монголын компаниудын хоорондын харилцаа, хамтын ажиллагааны боломжийг өргөжүүлэх, мөн Монголын хүний нөөцийн карьер хөгжлийг дэмжихэд оршиж байна. Бизнесийн харилцаа хариуцсан мэргэжилтэн томилогдон ирэх хугацаа бага зэрэг хойшлогдсон ч, уг асуудал шийдэгдэж үйл ажиллагаагаа бүрэн хүчин чадлаараа явуулах боломжтой боллоо.

2025 онд бид хэд хэдэн шинэ үйл ажиллагааг эхлүүлсэн. Үүнд:

- Хоккайдо их сургууль болон Васэда их сургуулийн багш нартай хамтарсан бизнесийн шинэ сургалтууд,
- Монголын бизнес эрхлэгчдэд зориулж Японы аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцах Монгол-Японы төвийн (MOJC) бие даасан туршлага судлах аялал,
- Япон компаниудад дадлага хийх монгол оюутнуудад зориулсан урьдчилсан сургалт явуулах зохион байгуулах гэрээт ажил,
- Японы ахлах сургуулиудад суралцах боломжийг танилцуулах боловсролын үзэсгэлэн зэрэг болно.

Эдгээр ажлууд бид бүгдийн хүлээлтээс илүү сайн үр дүнд хүрсэн бөгөөд зөвхөн Японы мэргэжилтнүүд төдийгүй Монгол-Японы төвийн ажилтнуудын хувьд ч шинэ зүйлийг сорьж үзэхийн ач холбогдлыг ойлгож, хийж буй ажилдаа сэтгэл хангалуун байна. Бид эдгээр ололт амжилтаа улам өргөжүүлэн хөгжүүлэхийн тулд 2026 онд ч олон төрлийн төсөл хөтөлбөрүүдийг тууштай хэрэгжүүлэх болно.

Төслийн 5 жилийн хугацаанд биднээс хамгийн их шаардагдах зүйл бол "Монгол-Японы төвийн бие даасан байдал" юм. Нийт ажилтнуудын чадавхыг дээшлүүлэхээс гадна санхүүгийн болон хүний нөөцийн холбоог оролцуулах "байгууллагын цогц чадавхыг бэхжүүлэх" нь чухал болоод байна. Энэ амархан зүйл биш боловч хамт олныхоо хүчээр даван туулах болно.

2025 оны 4-р сард томилогдон ирснээсээ хойш миний хамгийн маш сайн ойлгож буй зүйл бол бизнесийн сургалтын япон багш нар болон манай үйл ажиллагаанд оролцож буй япон хүмүүс Монголын хүний нөөцийг маш өндрөөр үнэлж байгаа явдал юм. Тэдний дунд "Японд ажилласнаас Монгол-Японы төвд ажиллах нь илүү сонирхолтой байна" гэх хүмүүс ч бий. Бид эдгээр хүмүүстэй тогтоосон харилцаагаа эрхэмлэн, төслийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулна.

Монгол Улсын Их Сургууль, Япон улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар болон Монголын холбогдох яам, төрийн байгууллагуудын зүгээс манай төслийг үргэлжлүүлэн дэмжиж, хамтран ажиллахыг хүсье.

*Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Ерөнхий зөвлөх
ЖАЙКА-ийн мэргэжилтэн Сато Мүцүмү*



I. БИЗНЕСИЙН СУРГАЛТЫН ТАСАГ





I. 2025 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН БИЗНЕСИЙН СУРГАЛТ, СЕМИНАРЫН ТАЙЛАН

Бизнесийн сургалтын тасаг нь бизнесийн төрөл бүрийн сургалт, семинар, зөвлөгөөг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын дэмжлэгтэйгээр Монголын бизнес эрхлэгчдийг хөгжүүлэх зорилгоор зохион байгуулж байна.

Бизнесийн үндсэн сургалтыг Удирдлагын ангид 7 сэдвээр, Менежерийн ангид 6 сэдвээр тус тус 2 удаа явуулж нийт 27 удаа, бизнесийн суурь мэдлэгийн сургалтыг 9 сэдвээр тус тус 1 удаа Хүний нөөцийн менежмент сэдвээр 2 удаа, ахисан түвшний сургалтыг 11 сэдвээр тус бүр 1 удаа, ажлын байран дээрх сургалтыг 20 компани дээр 32 удаа амжилттай зохион байгууллаа. Түүнчлэн Хоккайдогийн Их Сургууль болон Васэда Их сургуулийн профессоруудыг урьж Менежментийн семиуляци, Бизнесийн сургалтыг үр дүнтэй заах аргын сургалт, Төрөлжүүлэх стратеги, Эмэгтэйчүүдийн өнцгөөс харсан бизнесийн шинэ хэв маяг сэдэвт сургалтуудыг амжилттай зохион байгуулсан нь онцлог байлаа.

2025 оны нийт сургалтад 3204 хүн хамрагдсан байна. Монгол-Японы төвийн бизнесийн сургалтуудыг арвин туршлагатай япон, монгол багш нар удирдан явуулж, бизнест бодитоор тус нэмэр болохуйц мэдлэг олгодгоороо давуу талтай. Суралцагчдын 95-ээс дээш хувь нь сургалтыг өндрөөр үнэлэн, сургалтаас сурсан, мэдсэнээ ажлын байран дээрээ хэрэгжүүлж байна.

~ *Бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэх сургалтын хэрэгжилт* ~

1) Танхимын сургалт

1. Бизнесийн сургалтын тасгийн **үндсэн сургалт** болох “Жижиг, дунд аж ахуйн нэгжийн менежментийг сайжруулах оношилгоо зааварчилгаа, шинжилгээ” сэдэвт бизнесийн практик сургалтыг суралцагчдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн жилд хоёр удаа (намар, өвлийн элсэлт) зохион байгуулдаг. Тус сургалтын зорилго нь зах зээлийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр болохуйц хүний нөөцийг хөгжүүлж, Монголын аж ахуйн нэгжийг хөгжүүлэх, цаашлаад Монгол улсын эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулахад оршино.

Бизнесийн үндсэн сургалтын хүрээнд суралцагчдыг **удирдлагын** болон **менежерийн** гэсэн хоёр ангид элсүүлж, менежментийн үндсэн дөрвөн сэдвээр сургалтыг зохион байгуулдаг. Үүнд:



- Стратегийн менежмент
- Маркетинг
- Санхүүгийн удирдлага
- Хүний нөөцийн менежмент

Сургалтын удиртгал хичээл болгон дараах сэдвүүдийг нэмэлтээр хамруулна. Үүнд:

- “Япон маягийн менежмент”
- “5S Кайзен хөдөлгөөн”

Мөн удирдлагын ангид нэмэлтээр “Комплаенс” буюу аж ахуйн нэгж, байгууллагын бодлого, төлөвлөгөө, стандарт, аргачлал болон холбогдох хууль, дүрэм журмын хэрэгжилтийг хангах хяналтын тогтолцооны талаар цогц сургалтыг явуулдаг.



Зураг 1. Бизнесийн үндсэн сургалтын Удирдлагын анги
Стратегийн менежмент сургалтын явцаас

Зураг 2. Бизнесийн үндсэн сургалтын Менежерийн
ангийн хамт олон

Энэ жил бизнесийн үндсэн сургалтыг хавар, намар 2 удаа танхимаар амжилттай зохион байгуулж, 4 ангид нийт 141 компани, аж ахуйн нэгжийн нийт 146 удирдах ажилтан, менежер суралцаж төгссөн байна.

Өмнөх жилүүдийн адил онол, практик хосолсон хэлбэрээр явагдсан ба суралцагчид тус тусын компанийн жишээ болон тулгамдаж буй асуудлаар санал бодлоо чөлөөтэй солилцож, зөвхөн мэргэжилтэн багшаас суралцах төдийгүй харилцан суралцах нөхцөл бүрдсэн сургалт болж өндөрлөлөө.

Мөн энэ хичээлийн жилийн 2 дугаар элсэлт буюу менежерийн ангийн 27-р элсэлтийн хичээлийг үндэсний сургагч багш нар удирдан явуулсан нь шинэлэг байлаа. Үндэсний сургагч багш буюу Монгол багш нар сургалтыг удирдаж орохын давуу тал нь сургалт орчуулгагүй байдгаараа ажлын талбарт байнга сорилттой тулгарч байдаг менежерүүдэд зориулан олон талын агуулгыг багтаах боломжтой болж байгаа юм. Түүнчлэн Менежерийн ангид нэг компаниас 3-4 хүн хамрагдах тохиолдол нэмэгдсэн бөгөөд



удирдлага, дунд шатны албан тушаалтнууд нэг ойлголттой болсноор тухайн компанийн өсөлт хөгжилд илүү хувь нэмэр оруулдаг давуу талтай билээ.

Монгол-Японы төв нь үндсэн сургалтаас гадна суралцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн танхимаар 3-5 хоногийн практик сургалт болон суурь мэдлэгийн сургалтыг зохион байгуулдаг. Түүнээс гадна ажлын байран дээрх сургалт болон Загвар Аж Ахуйн Нэгжийг Хөгжүүлэх Хөтөлбөрийн дагуу төрөл бүрийн сургалт зөвлөгөөгний хөтөлбрүүдийг хэрэгжүүлдэг.

2. Практик сургалтыг “Бизнес төлөвлөгөө”-2 удаа, “Японы үйлчилгээний соёлоос суралцах нь”, “Менежментийн симуляци”, “Дэлгүүрийн менежмент”, “Эксэлээр



Зураг 3. Дэлгүүрийн менежмент Практик сургалтын явцаас



Зураг 4. “Бизнес төлөвлөгөө” Практик сургалтын явц

бизнесийн шинжилгээ хийх нь”, “Global Value Chain”, “Үйлдвэрлэлийн удирдлага”, “Маркетинг” сэдэв болон шинээр Хоккайдогийн Их Сургууль болон Васэда Их Сургуулийн професруудыг урин “Менежментийн симуляци”, “Бизнесийн сургалтыг хэрхэн үр дүнтэй заах вэ?”, “Эмэгтэйчүүдийн өнцгөөс харсан бизнесийн шинэ санаа”, “Төрөлжүүлэх стратеги” сэдэвт сургалтыг танхимаар зохион байгуулж, нийт 355 хүн хамрагдсан байна.

3. Бизнесийн суурь мэдлэгийн сургалтыг 2016 оноос эхлэн зохион байгуулж байна. 2017 оноос эхлэн бямба гарагт зохион байгуулдаг болсноор илүү олон компанийн ажилтнууд амралтын нэг өдрөө менежментэд суралцан үр өгөөжтэй өнгөрөөх боломжийг бүрдүүлж өгсөн юм.

Энэ жилийн хувьд суурь мэдлэгийн сургалтуудын ойлголт, үр дүнг нэмэгдүүлэхийг зорьж доорх сэдвүүдээр бүрэн танхимаар зохион байгуулсан юм. Үүнд “Хүний нөөцийн менежмент” сэдвээр 2 удаа, “Дэлгүүрийн менежмент”, “5S хөдөлгөөн”, “Маркетинг”, “Үйлдвэрлэлийн удирдлага”, “Санхүүгийн удирдлага”, “Төслийн менежмент”,



“Стратегийн менежмент”, “Удирдлагын тогтолцоо ба засаглал” сэдэвт сургалтыг зохион байгууллаа.



Зураг 5. “Хүний нөөцийн удирдлага” сэдэвт бизнесийн суурь мэдлэгийн сургалт



Зураг 6. “Санхүүгийн менежмент” сэдэвт бизнесийн суурь мэдлэгийн сургалт

4. “Байгууллагад зориулсан сургалт”

Монголын компаниудад бизнесийн орчны өөрчлөлт, өрсөлдөөн нэмэгдэж байгаатай уялдан зөвхөн удирдах албан тушаалтнаа хөгжүүлээд зогсохгүй байгууллагын стратегид үндэслэн компанийг бүх талаар нь бэхжүүлэх, нийт ажилтнуудын мэдлэг, ур чадварыг ахиулахыг чухалчилж байна. Иймээс байгууллагын удирдах албан тушаалтныг сонгон, гаднын сургалтад хамруулахын зэрэгцээ компани дотроо нэг ойлголттой болохыг зорилго болгон олон төрлийн сургалтыг идэвхтэй зохион байгуулдаг болжээ.



Зураг 7. Жүр Үр ХХК “Хүний нөөцийн менежмент” сэдэвт сургалтын үеэр

Энэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тус төв нь аж ахуйн нэгжүүдийн менежментийн үр дүн, бүтээмжийг сайжруулах, хүний нөөцийн менежмент болон сургалт хөгжлийн



Зураг 8. “Карбон Композитс ХХК” сургалтын үеэр


системийг бий болгох зорилгоор ажлын байран дээрх сургалт, Загвар Аж Ахуйн Нэгжийг Хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж монгол компаниудын оновчтой удирдлага, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд түлхүү анхааран ажиллаж байна. Тус төв нь ЖАЙКА-ийн мэргэжилтэн болон үндэсний сургагч багш нар байгууллагын хүсэлтийн дагуу, компанид



тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх зорилготойгоор ажлын байран дээрх сургалтыг зохион байгуулж ирсэн билээ. 2025 онд давхардсан тоогоор 16 компанид 26 удаа сургалт орж, нийт 814 хүн хамрагдаж, нийт 130 гаруй цагийн сургалтыг зохион байгуулсан байна. 2025 оны хувьд Жүр Үр ХХК-ийн удирдлагын багийнхны чадавхийг сайжруулах, нэгдсэн ойлголттой болгох зорилготойгоор менежментийн 4 сэдвээр нийт 64 цагийн сургалтыг тус төвийн үндэсний сургагч багш Н.Батдэлгэр (Стратегийн менежмент), Д.Дашмаа (Хүний нөөцийн менежмент), Б.Угтахжаргал (Маркетинг), Б.Мөнхцог(Санхүүгийн менежмент) өгсөн юм.

5.Загвар Аж Ахуйн Нэгжийг хөгжүүлэх хөтөлбөр

Уг хөтөлбөрийн хүрнээд Орхон аймаг Эрдэнэт хотод үйл ажиллагаагаа явуулж буй Анд-Энерги ХК, Намнан Индастри ХХК, МЯК ХХК гэсэн нийт 3 компанид тус тусын хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалт, зөвлөгөөг Япон мэргэжилтэн болон Монгол багш нар хамтран шат дараатайгаар, тухайн компанид тохирсон агуулгаар зохион байгуулж амжилттай өндөрллөө.



Зураг 9. Анд-Энерги ХК дахь
“Хүний нөөцийн менежмент” сургалтын
явц

Тус хөтөлбөрт хамрагдаж буй компаниудад нийт компанийн түвшний стратеги тодорхойлох, түүнтэй уялдсан нэгжийн стратеги болон хүний нөөц хөгжүүлэлт, ялангуяа компанийн гол цөм болох дунд түвшний удирдах ажилтны сургалт, хөгжүүлэлт хэмээх агуулгаар голчлон сургалт, зөвлөгөө зохион байгууллаа.

ЯПОН ДАХЬ ДАДЛАГА СУРГАЛТ

2025 оны 10 сард Япон улсын нийслэл Токио хот орчмоор болон ойролцоох томоохон мужууд болох Сайтама, Канагава, Гүнмад дадлага сургалтыг зохион байгуулж, бизнесийн үндсэн сургалтын 15 төгсөгч, загвар аж ахуйн нэгжийн менежментийг сайжруулах хөтөлбөрийн төгсөгч 2 компанийн төлөөлөл, үндэсний сургагч 3 багш, Монгол-Японы төвийн 2 мэргэжилтэн нийт 22 хүн хамрагдлаа.

Энэхүү дадлага сургалтад бизнесийн үндсэн сургалтаар суралцсан агуулгыг япон компаниуд хэрхэн хэрэгжүүлж байгаа бодит байдалтай танилцах, япон маягийн менежментийн үндэс болох кайзэн хэрэгжүүлснээр ямар үр дүнд хүрч болохыг таниулах зорилгоор 2003 оноос өдийг хүртэл зохион байгуулж ирсэн.



Зураг 10. “Мэйжи Нарүходо” үйлдвэрийн гадна

нөлөөлж, улмаар энэ нь бизнес сургалтын үр дүн жинхэнэ утгаар хэрэгжиж, Монголын жижиг дунд бизнес цэцэглэн хөгжихөд дорвитой хувь нэмэр болно гэж үзэж байгаа юм.

Энэ удаагийн дадлага сургалтын удирдагч багшаар Кансай их сургуулийн Гото Кэнта профессор ажилласан бөгөөд онолын түвшинд тайлбарлан, зааж өгч байсан нь, ыкомпанид зочлон нүдээр үзэж танилцсан зүйлсээ онолын түвшинд ойлгосон маш ашиг тустай сургалт болсон юм. Мөн JETRO Азийн эдийн засгийн судалгааны газрын Ямада Мива багшаас “Бизнес ба хүний эрх” сэдвээр сонирхолтой лекц сонсож, Маркетингийн багш Хиракава Масаказүгийн тайлбар чиглүүлгийн доор Токиогийн хотын Гинза дүүрэгт байршилтай томоохон дэлгүүрүүдийн концепцтэй биечлэн танилцаж, 10 гаруй компанийн удирдлага, холбогдох хүмүүстэй уулзлаа.



Зураг 11. “Орихиро” компанийн үйлдвэртэй танилцаж буй байдал



Зураг 12. Гинза дүүрэг дэх “Донки” дэлгүүрийн Концепцтэй танилцаж буй байдал

солилцсон үр дүнтэй сургалт болж өндөрлөлөө.

Бизнес эрхлэгчдэд Япон компаниудын бодит байдалтай биечлэн танилцаж, бид ямар түвшнийг зорих ёстой вэ? гэдэг загвар жишгийг нүдээр харж мэдрэн, туршлагаас нь суралцсанаар компаниудын үр ашигтай зохион байгуулалт шийдвэр гаргалтад

Мөн тус сургалтад Монгол-Японы төвийн үндэсний сургагч багш нарыг чадавхжуулах болон туршлага солилцох зорилготойгоор 3 багш хамрагдсан бөгөөд багш нарын зүгээс компаниудын айлчлалын дараа дүгнэлт хийж, багш суралцагчид хоорондоо туршлага



QR 1. Япон дахь дадлага сургалтын тайлан



QR 2. Япон дахь дадлага сургалтын бичлэг



БИЗНЕСИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОО ҮЗҮҮЛЭЛТ





График 1. 2002-2025 оны бизнесийн сургалт, үйл ажиллагааны нийт оролцогчдын тоо

Бизнесийн сургалтын чанарын үзүүлэлт



Тайлбар: 2021 оноос хичээлийн агуулга хэр ойлгомжтой байсан болон сургалт хариуцсан ажиллаж буй мэргэжилтнүүдийн хандлагын талаарх сэтгэл ханамжийг нэмж оруулсан.

График 2. 2018-2025 оны бизнесийн сургалтын чанарын үзүүлэлт



ХАМРАГДСАН АЖ АХУЙН НЭГЖ БОЛОН ОРОЛЦОГЧДЫН СТАТИСТИК

3,204

Нийт оролцогчид

1,609

Аж ахуйн нэгжүүд



797

Үүсгэн байгуулагч,
захирлууд



113

Орон нутгийн оролцогчид



991.3

Нийт сургалтын цаг

График 3. Үндсэн үзүүлэлт

ХИЧЭЭЛИЙН АГУУЛГА БА ЗААХ АРГА ЗҮЙ



График 3. Агуулга болон заах арга зүйн чанарын үзүүлэлтүүд

95%

Дундаж сэтгэл ханамж

Бүх үзүүлэлтүүд зорилтот түвшнээс давсан бөгөөд ажилтнуудын харилцаа, хандлага хамгийн өндөр буюу 98%-тай байна.





Хүснэгт-1: Байгууллагад зориулсан сургалт


| № | Компанийн нэр | Сургалтын нэр | Хугацаа | Багшийн нэр | Оролцогчдын тоо |
|----|----------------------------|--------------------------------------|---------------------|-------------------|-----------------|
| 1 | Гэрэгэ Турист Пасспорт ХХК | Стратегийн менежмент | 2025.1.31 | Кавагүчи Шиничиро | 3 |
| 2 | МАК ХХК | BS хөдөлгөөн | 2025.2.13 | Д.Долгормаа | 3 |
| 3 | Милая ХХК | Стратегийн хэрэгцээ шаардлага | 2025.2.17 | Н.Батдэлгэр | 3 |
| 4 | Милая ХХК | Байгууллагын онол | 2025.3.18 | Н.Батдэлгэр | 3 |
| 5 | Carbon composites ХХК | Стратегийн менежмент | 2025.3.19 | Н.Батдэлгэр | 3 |
| 6 | Carbon composites ХХК | Хүний нөөцийн менежмент | 2025.3.20 | Д.Дашмаа | 3 |
| 7 | Carbon composites ХХК | Соёлын өөр байдлыг ойлгох нь | 2025.3.21 | Накамура Ко | 3 |
| 8 | Жүр Үр ХХК | Стратегийн менежмент | 2025.3.31-4.3 | Н.Батдэлгэр | 16 |
| 9 | Жүр Үр ХХК | Хүний нөөцийн менежмент | 2025.4.7-11 | Д.Дашмаа | 16 |
| 10 | Пи Си Молл ХХК | Дэлгүүрийн менежмент | 2025.4.16 | Ж.Гансүх | 4 |
| 11 | Пи Эс Эс Ти ХХК | Төслийн менежмент | 2025.6.5 | Б.Мөнхцог | 4,5 |
| 12 | Эрдэнэс Таван Толгой ХХК | BS хөдөлгөөн | 2025.6.6 | Д.Долгормаа | 3,5 |
| 13 | Миний Дэлгүүр | BS хөдөлгөөн | 2025.4.29 | Д.Долгормаа | 6 |
| 14 | Пи Эс Эс Ти ХХК | Стратегийн менежмент | 2025.6.7 | Н.Батдэлгэр | 5 |
| 15 | Жүр Үр ХХК | Маркетинг | 2025.8.11-15 | Б.Угтахжаргал | 16 |
| 16 | Ланд Бридж ХХК | Экселээр бизнесийн шинжилгээ хийх нь | 2025.8.18 | Н.Батдэлгэр | 5 |
| 17 | GN Beverages ХХК | Япон маягийн менежмент, Коучинг | 2025.9.4 | Дэгүчи Саторү | 3 |
| 18 | Жүр Үр ХХК | Санхүүгийн удирдлага | 2025.11.12,14,18,24 | Б.Мөнхцог | 16 |
| 19 | Go To Market | Дэлгүүрийн менежмент | 2025.11.19 | Ж.Гансүх | 4 |
| 20 | Нарүми ХХК | Хөрөнгө оруулалтын зөвлөгөө | 2025.12.17 | Хиракава Масаказү | 2 |
| 21 | Ucab Eats ХХК | Маркетинг | 2025.12.20 | Хиракава Масаказү | 2 |
| 22 | НҮБИА ХХК | Байгууллагын соёл, Япон менежмент | 2025.12.2 | Ж.Хишигжаргал | 2 |
| 23 | НҮБИА ХХК | Байгууллагын соёл, Япон менежмент | 2025.12.5 | Ж.Хишигжаргал | 2 |
| 24 | НҮБИА ХХК | Байгууллагын соёл, Япон менежмент | 2025.12.8 | Ж.Хишигжаргал | 2 |
| 25 | НҮБИА ХХК | Байгууллагын соёл, Япон менежмент | 2025.12.9 | Ж.Хишигжаргал | 2 |
| 26 | НҮБИА ХХК | Байгууллагын соёл, Япон менежмент | 2025.12.12 | Ж.Хишигжаргал | 2 |



II. ОНЦЛОХ МЭДЭЭ

1) Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн багш Кавагүчи Шиничиро /Ph.D./ Монгол улсын төрийн дээд шагнал Алтангадас одонгоор шагнууллаа.

Кавагүчи багш нь Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв үүсгэн



Зураг 13. Төрийн дээд шагнал Алтангадас одон гардуулах ёслолын үеэр

байгуулагдсан 2002 оноос эхлэн өнөөг хүртэл 23 жилийн турш тасралтгүй бизнес эрхлэгчдийг сургаж, хөгжүүлэх замаар Монгол улсын бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэхэд хүчин зүтгэж иржээ. Энэ хугацаанд компанийг удирдах үндэс суурь болох алсын хараа, эрхэм зорилгын ач холбогдлыг ойлгуулах, байгууллагын алтангадас болох стратеги төлөвлөгөө

боловсруулах арга техникийг Монгол компанийн удирдлага хийгээд удирдах түвшний ажилтнуудад зааж сурган, олон олон чадварлаг захирлуудыг сурган хүмүүжүүлсэн байна.

Шагнал гардуулах ёслолын үеэр Монголын бизнес эрхлэгчдэд менежментийн зөвлөгөө өгөх, бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, хоёр улсын бизнесийн хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж буйд талархан тус шагналыг гардуулж буйгаа МУ-н Ерөнхийлөгч тусгайлан дамжуулж мэндчилгээ илгээсэн юм.

2) Хоккайдогийн Их сургууль багш профессоруудтай хамтарсан сургалт семинар

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв (МЯТ) нь энэ хичээлийн жилээс эхлэн Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран Японы их сургуулиудын профессорыг урьж, бизнесийн шинэ сургалтыг хэрэгжүүлж эхэллээ.



Зураг 14. Төрөлжүүлэх стратеги сургалтын хэсгээс



Энэ ажлын хүрээнд, Хоккайдогийн их сургууль, Хоккай Гакуэн их сургуультай хамтран анх удаа зохион байгуулсан “Менежментийн шинэ хэв маяг ба бизнесийг төрөлжүүлэх стратеги” ахисан түвшний бизнесийн сургалтыг зохион байгуулав. Сургалтыг Хоккай Гакуэн их сургуулийн профессор Сато Дайсүкэ, Хоккайдогийн их сургуулийн дэд профессор Шиина Нозоми багш нар удирдан явууллаа.

Энэхүү сургалтад нийт 42 удирдах албан тушаалтан, менежерүүд, шинэ бизнесийн санааг эрэлхийлсэн бизнес эрхлэгчид оролцож, лекц болон багийн ажил, хэлэлцүүлгийн замаар бизнесийн үндэс, маркетинг, шинэ бизнесийн стратеги, бизнесийн загварын самбар зэрэг өргөн цар хүрээтэй сэдвүүдийг судаллаа. Дэлхий нийтийн нөхцөл байдал болон хэрэглэгчийн хандлага байнгын өөрчлөгдөж буйгаас шалтгаалан нэг л төрлийн бизнест найдах нь эрсдэлтэй өнөө цагт ихээхэн үр өгөөжтэй сургалт болж өндөрлөлөө.



Зураг 15. Эмэгтэйчүүдийн өнцгөөс харсан бизнесийн шинэ хэв маяг сургалтын хэсгээс

Мөн Эмэгтэй бизнес эрхлэгчдийн менежментийн мэдлэг чадварыг хөгжүүлэх, бизнес эрхлэлтийг дэмжих зорилтой “Эмэгтэйчүүдийн өнцгөөс харсан бизнесийн шинэ хэв маяг сэдэвт сургалтуудыг амжилттай зохион байгууллаа. Энэхүү семинарт Монголын бизнесийн салбарт ажиллаж буй 30 эмэгтэй оролцсон бөгөөд

“Бизнес гэж юу вэ?” гэх суурь асуултаас эхлэн, дэлхийд амжилт гаргасан эмэгтэй бизнес эрхлэгчид хэрхэн шинэ санаа, шийдэл бий болгосон талаар бодит жишээн дээр суурилсан воркшоп явагдаж, шинэлэг бөгөөд үр өгөөжтэй сургалт болж чадлаа.

Мөн өдөр тутмын тулгамдсан асуудал, сайжруулах шаардлагатай зүйлсийг нийгмийн зорилготой уялдуулан шинэ бизнесийн санаа болгон хөгжүүлэх үйл явцыг багийн ажил болон нээлттэй хэлэлцүүлгийн явцад хамтран тунгаах боломжийг оролцогчдод олгосон юм.

3) Васэда Их сургуулийн багш профессоруудтай хамтарсан сургалт семинар

Монгол–Японы Хүний нөөцийн хөгжлийн төв (МЯХНХТ) нь энэ оноос эхлэн Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-тай хамтран Япон улсаас шинээр багш, профессоруудыг урьж бизнесийн ахисан түвшний сургалтыг зохион байгуулж байна.



Зураг 16. Менежментийн симуляци сургалтын хэсгээс

дараах сургуулийн Бизнесийн удирдлагын тэнхимийн профессор Сато Кацүхиро нар удирдан явуулсан юм. Технологи ашиглан бодит үр дүнг дүрсэлж үзэх, Тухайн үр дүнг бодит байдал дээр менежментийн талаас тайлбарласан нь маш үр дүнтэй стратегийн сургалт болж чадсан билээ.

Скоре ХК-ийн боловсруулсан “Business Management Game (BMG)” нь оролцогчид цахим орчинд компанийн захирлын түвшинд судалгаа хөгжүүлэлт, зах зээлийн судалгаа, санхүүгийн удирдлагатай холбоо бүхий шийдвэр гаргах, үр дүнг нь симуляци хийн туршиж үзэх боломж олгодог бизнесийн хүний нөөцийг хөгжүүлэхэд дэмжлэг болох сургалтын хэрэгсэл юм. Энэ удаагийн сургалтад



Зураг 17. Менежментийн симуляци сургалтын хэсгээс

оролцогчид анх удаа монгол хэл дээр боловсруулсан хувилбарыг ашиглаж, багийн хамт 1 тэрбум иений борлуулалтад хүрэх зорилго бүхий удирдлагын шийдвэр гаргахад оролцов. Сургалтын сүүлийн гурван өдөр Сато профессор менежментийн стратегийн лекц уншиж, оролцогчид багийн түвшинд менежментийн стратегийн хүрээг судлан, “Хямд, загварлаг хувцас үйлдвэрлэгч Японы компани Монголын зах зээлд нэвтрэх стратеги” сэдвээр менежментийн дадлага хийв. Сургалтын сүүлийн өдөр явагдсан багийн илтгэлийн үеэр Монголын зах зээлийн онцлогийг агуулсан, өвөрмөц стратегийг танилцуулж, оролцогчид харилцан бие биеэсээ идэвхтэй суралцах уур амьсгалыг бүрдүүлж байв.

Оролцогчдын зүгээс “Одоогийн нөхцөл байдалд нийцсэн агуулгатай байсан нь их таалагдлаа”, “Шууд хэрэгжүүлж болохуйц симуляцийн арга барилыг эзэмшлээ” зэрэг олон сэтгэгдэл ирсэн юм.



Зураг 18. Бизнесийн сургалтыг хэрхэг үр дүнтэй
заах вэ? сургалтын үеэр

Васэда Их сургуулийн Төгсөлтийн дараах сургуулийн Бизнесийн удирдлагын тэнхимийн профессор Сато Кацүхиро нар байгууллагын ажилтан болон бизнесийн туршлага бүхий хүмүүст хичээл заадаг багш нарт зориулсан “Бизнес эрхлэгч болон компанийн ажилтанд зориулсан бизнесийн заах арга зүй” сэдэвт лекцийг зохион

байгуулав.

Сургалтад Монгол Улсын Их сургууль болон орон нутгийн их, дээд сургуулиудын нийт 60 багш (25-ны өдөр 28 хүн, 26-ны өдөр 32 хүн) хамрагдав.

Профессор Сатогийн хичээл заадаг бизнесийн сургуулийн оюутнуудын дундаж нас нь 37 орчим байдаг агаад, тэр бээр лекцийн үеэр, “Академик боловсрол ба мэргэжлийн боловсролын ялгаа” гэсэн сэдвийг эхэлж хөндөн ярьж, бизнесийн туршлагатай ажилтнуудтай хамт суралцах, хичээлээ хэрхэн явуулах, багшийн хандлага болон хэлэлцүүлгийг идэвхжүүлэх зэрэг аргуудын талаар ярив.

Хичээлийн явцад оролцогчдоос “Хичээл дээр хиймэл оюун ухааныг ашиглах талаар ямар байр суурьтай байдаг вэ?”, “Өөр чиглэлийн оюутнаас тодорхой асуулт ирвэл хэрхэн хариулах вэ?” гэх мэт өдөр тутмын сургалтын үйл ажиллагаанд учирдаг хүндрэл бэрхшээлтэй холбоо бүхий асуултыг асууж байсан. Үүний хариуд профессор Сато “Оролцогсад угаасаа хиймэл оюун ухааныг ашиглах болно гэж урьдчилан тооцож, дээрх хүмүүс өөрсдийн тархи толгойг ашиглан бодож чадахуйц хичээлийн дүрмийг боловсруулах”, “Ижил төстэй туршлага олж авсан суралцагсад угаасаа байдаг тул багш нь тэдгээрийн харилцан суралцах орчныг хөтлөн чиглүүлэх ёстой” гэх мэт мэдлэг, туршлагаа хуваалцсан нь мэдээлэл солилцох, харилцан суралцах таатай орчныг бүрдүүлж байв.



Төгсөгчийн сэтгэгдэл



Зураг 19. М.Энхмандах Инно Хими Лаб ХХК-ийн гүйцэтгэх захирал

Миний бие компанийн санаачилгаар 2024 онд Монгол-Японы төвийн Удирдлагын ангийн сургалтад хамрагдаж, уг сургалтаас нээгдсэн боломжийг ашиглан мөн онд МУИС-ийн Бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрт элсэн суралцаж, бизнесийн удирдлагын магистр зэрэг хамгаалсан.

Монгол-Японы төвийн сургалт нь зөвхөн онолын мэдлэг олгохоос гадна бодит бизнесийн орчинд хэрэгжүүлэхүйц, Япон менежментийн философид суурилсан практик хандлагаараа онцлог байсан. Үүний үргэлжлэл болгон Япон улсад дадлага, туршлага судлах тэтгэлэгт хөтөлбөрт тэнцэж, 2025 оны хавар хүнсний салбарын олон улсын томоохон арга хэмжээ болох FOODEX Japan 2025-тай уялдсан сургалт, хөтөлбөрт хамрагдсан нь салбарын чиг хандлага, чанар, экспорт, борлуулалтын талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх бодит боломж болсон. Дадлага сургалтын тухай онцолбол дэлхийн хэмжээний компаниуд, чанар, стандарт, бүтээгдэхүүн гэж юу байдаг, түүнийг хэрхэн технологийн дэвшилтэй холбогдуулан ухаалгаар хэрэгжүүлэх, бүтээж болдгийг нүдээрээ харж, мэргэжилтнүүдээр нь менежментийг заалгаж байсан нь гэж хэлнэ.

Эдгээр сургалт, хөтөлбөрүүдээс олж авсан мэдлэг, туршлага нь шинэхэн байгуулагдсан манай компанийн хувьд бодит өгөөж өндөртэй байж, стратеги төлөвлөлт, менежмент, хүний нөөцийн бодлогодоо Япон маягийн нягт, тасралтгүй сайжруулалтын сэтгэлгээг нэвтрүүлэх суурь болсон. Үүний үр дүнд бид Монгол-Япон төвийн Загвар Аж Ахуйн нэгжийг хөгжүүлэх хөтөлбөрт шалгарч, 2025–2026 онд компанийн түвшинд хамт олноороо дунд хугацааны стратеги, хүний нөөцийн бодлогоо тодорхойлон, системтэйгээр хэрэгжүүлэн ажиллаж байна.

Монгол Япон төвийн сургалтаас миний олж авсан хамгийн үнэ цэнтэй зүйлсийн нэг нь Япон менежментийн мэдлэг мөн, түүнтэй дүйцэхүйц гэж хэлж болох үнэ цэн бол зорилго, ижил түвшний хүсэл тэмүүлэлтэй хамт олон, анги, найзуудтай болсон явдал юм. Бие биеээсээ суралцаж, дэмждэг ийм орчинд суралцсан нь мэргэжлийн болон хувь хүний хөгжилд минь бодитой нөлөө үзүүлсэнд чин сэтгэлээсээ талархаж явдаг.

*М. Энхмандах
Инно Хими Лаб ХХК – ийн гүйцэтгэх захирал
•Монгол Япон төвийн Удирдлагын ангийн төгсөгч
•МУИС – ын Бизнесийн удирдлагын магистр*



Зураг 20. С.Эвшинхорлоо “Bozzolo бэлэн хувцасны их дэлгүүр”-ийн захирал

Миний бие Монгол-Японы төвийн 2019 оны "Менежерийн анги"-д элсэн орсноор анхны холбоосоо тогтоож байлаа. Тухайн үед олж авсан мэдлэг, туршлага болон Япон улсын бизнесийн салбарын цаг үеийн мэдээллүүд нь миний хувьд ажил дээрээ бодит өөрчлөлт хийх, үр өгөөжтэй ажиллах том хөшүүрэг болж чадсан юм. Энэхүү үнэ цэнтэй туршлагадаа үндэслэн би өдгөө "Удирдлагын анги"-д шат ахиулан суралцаж, мэдлэг мэдээллийнхээ цар хүрээг улам бүр тэлсээр байна.

Энэ удаагийн сургалтаар хүний нөөцийн менежментийн хүрээнд "Ажилтны зэрэглэл тогтоох" хэмээх туйлын чухал сэдвийг хөндсөн бөгөөд компани дээрээ нэн даруй хэрэгжүүлж эхлээд байна. Жишээлбэл, борлуулалтын албаны ажилтнуудаа чадавхаар нь 3-аас 5 зэрэглэлд хувааж, шинэ ажилтныг дасан зохицох хөтөлбөртэй нь уялдуулах, ажилтан дараагийн шатанд дэвшихэд ямар чадвар эзэмшсэн байхыг нь тодорхой болгох зэрэг ажлуудыг эхлүүллээ. Мартагдсан байсан энэхүү чухал зарчмыг эргэн сануулж, өгөөжөө өгөх бодит аргачлалыг зааж өгсөн нь энэ сургалтын нэг гайхамшиг байлаа.

Монгол-Японы төвийн "Үндсэн сургалт" нь бодитой, практик дээр хэрэгжихүйц, зарчимч бөгөөд маш тодорхой заагддаг тул миний карьерын өсөлтөд болон асуудлыг шийдвэрлэх, цаг хугацааг хэмнэхэд үнэлж баршгүй дэмжлэг болсон. Тус сургалтын гол давуу тал нь Японы бизнесийн практикт гарсан асуудлыг шийдвэрлэсэн туршлага дээр үндэслэн заадагт оршдог. Түүнчлэн 30-аас 45 жилийн асар их туршлагатай япон багш нар өөрсдийн биеэр хичээл зааж, удирдлагуудын заавал мэдэх ёстой мэдлэгийг салбар тус бүрээр нарийн гүнзгий олгодог нь хамгийн том давуу тал юм. Тийм ч учраас би энэхүү сургалтыг дараа дараагийн суралцагчдад гарцаагүй санал болгох болно.

С.Эвшинхорлоо
Bozzolo бэлэн хувцасны их дэлгүүр-захирал
•Монгол Япон төвийн Удирдлагын ангийн төгсөгч



II. БИЗНЕСИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ





I. 2025 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН МОНГОЛ-ЯПОНЫ БИЗНЕСИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Бизнесийн хамтын ажиллагааны тасаг 2025 онд хоёр орны бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа өргөжүүлэн илүү олон төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг дэмжиж ажиллаа.

Монгол-Япон төвийн бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагаа нь 9 дэх жилдээ тасралтгүй үргэлжилж буй бөгөөд албан ёсоор “Бизнесийн хамтын ажиллагааны тасаг” болж өргөжин үйл ажиллагаагаа тогтворжууллаа. Мөн түүнчлэн Монгол Японы хоорондын бизнесийн хамтын ажиллагаа эрчимжиж, нийт 27 төрлийн үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэлээ. Хоёр улсын хооронд бизнес болон хүмүүс хоорондын харилцаа эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд цаашид ч илүү их өргөжихийн хэрээр бусад Япон төвүүдтэй хамтын ажиллагаагаа тэлж, Япон төдийгүй бусад орнуудтай хамтран ажиллах боломжууд нэмэгдэх хандлагатай байна.

Энэ жилийн хувьд нэгэн онцлог нь Япон талаас Монгол орны бизнес, соёлыг сонирхох компаниудын төлөөлөлүүд өмнөх онуудтай харьцуулахад харьцангуй нэмэгдэж байгаа нь тус төвийн бизнесийн хамтын ажиллагааны тасгийн үйл ажиллагааны цар хүрээгээр харагдаж байна. Үүний нэг жишээ нь, ЖАЙКА-ийн Монгол дахь төлөөлөгчийн газар болон Нийслэлийн бизнес инновацийн газар зэрэг байгууллагатай хамтран Монгол-Японы бизнес форумыг зохион байгуулан ажиллах зэргээр үйл ажиллагаагаа тэллээ. Түүнчлэн, Монгол-Японы төвийн бизнесийн үндсэн сургалт төгсөгчдөдөө чиглэсэн ажлын эхлэл болгож, Японы улсын Токио хотод үзэсгэлэн яармаг үзэж сонирхох бизнес аяллыг зохион байгууллаа.

Зөвхөн Монгол, Япон хоёр орны харилцаагаар хязгаарлалгүй, ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг гуравдагч орны буюу тодруулж хэлбэл Киргыз, Казакстан, Узбек төвүүдийн үйл ажиллагаатай танилцах, төгсөгч компанитай хамтын ажиллагаа хийх эхлэл тавигдлаа.

Эдгээр ажлуудын үр дүнд хоёр орны бизнес эрхлэгчдэд эдийн засаг, бизнесийн орчны мэдээллийг харилцан солилцох боломж бүрдэж, Японы бүтээгдэхүүн, үйлчилгээг Монголын зах зээлд оруулах, Монголын бизнесийн орчин хийгээд боломжуудын талаар гадаад зах зээлд алхам алхмаар таниулснаар боломжууд нэмэгдэж, хамтын ажиллагааны эрчимжиж эхлэх юм.



| № | Үйл ажиллагааны нэр | | Хугацаа | Давтамж |
|----|--|---|------------|-------------|
| 1 | Жайка-тай холбоотой ажил | Монгол-Японы олон улсын бизнес инновацын форум 2025 | 2025.08 | 1 удаа |
| 2 | Жайка-тай холбоотой ажил (төлбөргүй) | “Foodex 2025 үзэсгэлэн яармаг”-т оролцох Монгол компанийг дэмжин ажиллах (7 компани) | 2025.03 | 1 удаа |
| 3 | | “Foodex 2025 үзэсгэлэн яармаг”-т оролцох, танилцах МЯТ төгсөгчдөд зориулсан 3 өдрийн тусгай сургалт | 2025.03 | 1 удаа |
| 4 | Гадаад хамтын ажиллагаа | Хамтын ажиллагааны санамж бичиг, Харилцан туршлага судлах, Бизнесийн үндсэн сургалт төгсөгчдийн хамтын ажиллагааг бэхжүүлэх | 2025.02 | 1 удаа |
| 5 | Төв Азийн 3 Япон төвтэй хамтын ажиллагаа (төлбөргүй) | Кыргыз-Япон төвийн төгсөгч компани Монгол улсад зочлох ажлын зохион байгуулалт | 2025.04 | 1 удаа |
| 6 | Хувийн хэвшил хамтын ажиллагаа ажил | Шизуока муж “Озава тэнт” компани (Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн хадгалах майхан хэлбэрийн зоорийн туршилт судалгаа) | 2025.04-10 | 5 удаа |
| 7 | Бизнес хамтын ажиллагааг дэмжих семинар | МЯТ Бизнесийн үндсэн сургалт төгсөгчдөд зориулсан тусгай эвент | 2025.02.07 | 1 удаа |
| 8 | | “Японы хүнсний бүтээгдэхүүний логистикийн тухай” нээлттэй семинар | 2025.04.05 | 1 удаа (40) |
| 9 | | “Үйлдвэрлэлийн салбарын хүний нөөцийн менежмент” нээлттэй семинар | 2025.08.22 | 1 удаа (37) |
| 10 | | “Бизнес ба хүний эрх” нээлттэй семинар | 2025.08.28 | 1 удаа (21) |
| 11 | | “Монгол улсын 2026 орны төсвийн төсөлд өгөх дүгнэлт” нээлттэй семинар (төлбөргүй) | 2025.10.31 | 1 удаа (16) |



| | | | | |
|----|--|--|--------------------------------|---------|
| 12 | Бие даасан Япон дахь дадлага сургалт, аялал | “Fashion World Tokyo” дадлага сургалт | 2025.09.30-10.05 | 1 удаа |
| 13 | | Нийгата муж /Технологийн хамтын ажиллагааны холбоо/-тай хамтарсан дадлага сургалт | 2025.11.04-10 | 1 удаа |
| 14 | Matching | Broadmedia Corporation | 2025.07 | 1 удаа |
| 15 | | Lifetronic LLC | 2025.07 | 1 удаа |
| 16 | Хоёр талын хамтын ажиллагааны үйлчилгээ гүйцэтгэл тоо(Гэрээт ажил) | Монгол дахь Японы худалдаа аж үйлдвэр эрхлэгчдийн холбоо гэрээт ажил | 2025.01-12 | 10 удаа |
| 17 | | Япон дахь дадлага сургалттай холбоотой бичгийн орчуулгын ажил гүйцэтгэл | 2025.02, 09 | 2 удаа |
| 18 | | Япон улсын элчин сайдын яам, Ока&Вауаг хуулийн ферм (Хуулийн семинар) | 2025.03-11 | 5 удаа |
| 19 | | Шинагава дүүргийн өдөрлөг | 2025.05 | 1 удаа |
| 20 | | КМС ХК-ийн Монгол дахь судалгааны ажил (Сэйдэн когёо компани) | 2025.06 | 1 удаа |
| 21 | | Японы STV телевизийн Монгол дахь сурвалжлага | 2025.09 | 1 удаа |
| 22 | | Нийгата мужийн Технологийн хамтын ажиллагааны холбооны төлөөлөгчдийн Монгол дахь айлчлал | 2025.08 | 1 удаа |
| 23 | | Тооёо Их Сургуулийн дадлагын оюутан хүлээж авах | 2025.08 | 1 удаа |
| 24 | | Хитачи бүс нутгийн /аж үйлдвэрийг дэмжих төв/ үйл ажиллагаа | 2025.06.16-18 | 1 удаа |
| 25 | | Канагава мужийн ажил эрхлэлтийн бодлого, зохицуулалтын хэлтсийн үйл ажиллагаа | 2025.06.02-04 2025.11.05-07 | 2 удаа |
| 26 | | JFM 2025 | 2025.08.16-17 | 1 удаа |
| 27 | Хоккайдо муж Накашибэцү хотын танилцуулга өдөрлөг | 2025.10.07 | 1 удаа | |



Тус төвийн төлбөртэй үзүүлдэг бизнесийн хамтын ажиллагааны үйлчилгээний орлого жил ирэх тусам тогтворжиж буй нь бизнесийн хамтын ажиллагааг дэмжих үйл ажиллагааг тогтвортой хийж, таниулан сурталчлах үйл ажиллагаа болон үйлчилгээний чанарын сайжруулалт дээр анхаарсаны үр дүн юм.

Бизнесийн хамтын ажиллагааг дэмжих ажил цаашид Монгол-Японы бизнесийн хамтын ажиллагаа үүсгэх орчинг тогтмол бий болгох, төрийн төслүүдээс гадна хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх, үйл ажиллагаагаа тогтворжуулах зорилготой билээ. Мөн бусад Япон төвүүдтэй хамтарсан үйл ажиллагаа явуулах гэсэн төлөвлөгөөтэй байна.



II. ОНЦЛОХ МЭДЭЭ

1) Монгол-Японы олон улсын бизнес инновацын форум-2025

1. Форумын ерөнхий агуулга

2025 оны 8 дугаар сарын 18-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимд “Япон–Монгол Бизнес Инновацын Форум 2025” амжилттай зохион байгуулагдлаа. Тус форум нь “Хамтдаа бүтээх ирээдүй” уриан дор хоёр улсын төр, хувийн хэвшлийн төлөөлөл, аж ахуйн нэгжүүд, стартапууд болон дэмжих байгууллагуудыг нэг дор цуглуулж, бодит бизнесийн хамтын ажиллагаа болон шинэ үнэ цэнийг бий болгох зорилготой хэрэгжсэн юм.

Форумд Монголын талаас ойролцоогоор 380, Японы талаас 100 орчим, нийт 480 гаруй хүн оролцож, хамгийн өргөн цар хүрээтэй арга хэмжээ болов. JICA Монгол дахь Төлөөлөгчийн газрын захиалгаар Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Бизнесийн хамтын ажиллагааны тасаг хариуцан зохион байгууллаа. Бэлтгэл ажлыг 2025 оны 6 дугаар сараас эхлүүлж, хамтран зохион байгуулагчаар доор байгууллагууд оролцсон.

- Нийслэлийн Бизнес Инновацын газар
- Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим
- Японд төгсөгчдийн ЖУГАМО холбоо
- Монгол дахь Японы худалдааны танхим (JCC)
- Монголын КАЙЗЭН холбоо

2. Хөтөлбөр ба гол агуулга

Форумын хүрээнд хөрөнгө оруулалтын орчин, ICT, стартап ба инновац, санхүү



Зураг 21 Танхимын ерөнхий байдал (Ойролцоогоор 480 оролцогчтой форум)

болон ОТС зах зээл, Монголын бизнесийн хүний нөөцийн хөгжил, Японы орон нутгийн засаг захиргааны туршлага, хүнс болон хөдөө аж ахуйн гэсэн 7 салбарын хүрээнд, нийт 22 илтгэгч илтгэл тавив. Мөн “Япон–Монголын компаниудын хамтын ажиллагаагаар гуравдагч зах зээлд нэвтрэх боломж”,



“ОТС зах зээлийн ирээдүйн төлөв”, “Хүний нөөцийн удирдлага ба олон талт байдал” сэдвүүдээр панел хэлэлцүүлэг өрнөж, хоёр улсын оролцогчдын зүгээс бодит, хэрэгжихүйц санал, туршлагаудыг солилцсон.

Хүндэт зочноор Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд болон улс төр, эдийн засгийн салбарын өндөр түвшний төлөөлөгчид оролцсон нь форумын ач холбогдол, хүлээлт өндөр байсныг илтгэв.



Зураг 22 Илтгэл, панел хэлэлцүүлгийн танилцуулга


3. Бизнес уулзалт ба бодит үр дүн

Энэ жилийн форумын онцлогийн нэг нь Япон, Монголын компаниудын практик хамтын ажиллагааг дэмжсэн бизнес уулзалт (постер танилцуулга) байв. Японы 6, Монголын 19 компани, нийт 25 компани оролцож, бүтээгдэхүүн, үйлчилгээний танилцуулга хийж, идэвхтэй санал солилцлоо.

Форумын дараах санал асуулгын дүнгээс харахад Японы компани Монголын аж ахуйн нэгжүүдтэй шинэ харилцаа холбоо тогтоосон гэсэн бодит үр дүнгийнхээ тухай хариулсан байсан бөгөөд цаашдын хамтын ажиллагааны эхлэлийг тавьсан нь тус форумын чухал үр дүнгийн нэг боллоо.

Мөн илтгэлийн үеэр 1990 оноос хойш Япон Улсаас Монгол Улсад хийсэн хуримтлагдсан хөрөнгө оруулалтын хэмжээ ойролцоогоор 1.7 тэрбум ам.долларт хүрсэн бөгөөд үүний 60 орчим хувь нь 2016 онд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш хийгдсэн талаар танилцуулсан.

Түүнчлэн Монголын стартап AND Global компанийн үнэлгээ 100 сая ам.долларыг давсан тухай мэдэгдлийг тус форумын үеэр зарласан нь онцгой ач холбогдолтой үйл явдал болов.



Зураг 23 Постер танилцуулгын хэсэг

4. Олон нийтэд мэдээлэх үйл ажиллагаа ба цаашидын төлөв

Форумыг угтан социал медиа, танилцуулга материал, хэвлэлийн мэдээ, телевизийн сурвалжилга зэрэг олон төрлийн сувгаар мэдээлэл түгээж, Япон–Монголын бизнесийн хамтын ажиллагааг дотоод, гадаадын олон нийтэд өргөн хүрээнд сурталчилсан.

Тус форум нь зөвхөн мэдээлэл солилцох төдийгүй бодит хамтын ажиллагааны суурийг тавих, харилцан итгэлцэл, түншлэлийг гүнзгийрүүлэх “практик яриа хэлэлцээ, уулзалтын талбар” болж чадсан. Цаашид нетворкингийн боломжийг улам өргөжүүлж, хөтөлбөрийн агуулгыг илүү боловсронгуй болгох замаар хоёр улсын тогтвортой эдийн засгийн хамтын ажиллагааг дэмжих чухал платформ болон хөгжих хүлээлттэй байна.

2) Монгол-Японы төвийн бизнесийн сургалтын үе үеийн төгсөгчдөд зориулсан үйл ажиллагаа

Монгол Улсад сүүлийн 20 гаруй жил олон улсын болон хувийн хэвшлийн байгууллагад ажилласан туршлагатай Монгол Японы Хүний Нөөцийн Хөгжлийн Төвд



Зураг 24 Монгол-Япон төвийн захирлын зүгээс төгсөгчдөд зориулан төвийн цаашидын стратегийн тухай тайлбарлав

томилогдон ажилласан ЖАЙКА-н бизнес хамтын ажиллагааны мэргэжилтэн Накамура Ко МОНГОЛ-ЯПОНЫ ТӨВИЙН БИЗНЕСИЙН ҮНДСЭН СУРГАЛТЫН ҮЕ ҮЕИЙН ТӨГСӨГЧДӨД зориулан өөрийн туршлага, Монгол-Япон бизнесүүд хамтын ажиллагааны боломж, асуудал, шийдлүүдийн талаар туршлагаасаа хуваалцлаа.



Тус семинарын ерөнхий агуулга нь, хоёр орны хувьд харилцан бизнес хийх бүрэн боломж байгаа ч, өөр өөр үндэстэн тул соёлын ялгаатай байдлаа ойлголцож, үүнийг ухамсарласан байх болон ухамсарлаагүй байхын ялгаатай байдлыг өөрийнхөө туулж ирсэн туршлагад тулгуурлан төгсөгчдөдөө хүргэхийг зорьсон юм. Уг соёлын ялгаатай байдлыг Geert Hofstede-ийн “The 6-D MODEL of NATIONAL CULTURE”-ийн үүднээс тайлбарласан нь бидэнд илүү сонирхолтой бөгөөд мэдүүштэй байлаа.

Семинарын гол мессэж нь “Бизнес гэдэг бол “Харилцаа · Хүндэтгэл · Хүн”-тулгуурлан өрнөдөг зүйл учраас цааш цаашдаа бид харилцан бие биеэ хүндэтгэж явцгаая” байсан нь Монгол-Японы төвийн бизнесийн сургалт төгсөгчдийн эрхэмлэж явах үнэт зүйл болов уу гэж бид бодож байна.



Зураг 25 Накамура Ко мэргэжилтэнгийн илтгэл

Энэхүү семинар нь бизнесийн сургалтын үе үеийн төгсөгчдийн холбоо харилцааг сайжруулах үйл ажиллагааны эхлэл болсон ба цаашид ийм төрлийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулахаар төлөвлөж байна.

3) Төв азийн орнуудын япон төвүүдээр зочилж туршлага судаллаа

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн захирал Ц.Даваадорж болон тус төвийн холбогдох нэгж тасгуудын төлөөлөл энэ сарын 16-ны өдрөөс 23-ны өдрүүдэд 7 хоногийн хугацаатай Төв Азийн 3 улс дахь Япон төвүүдээр зочилж туршлага судлаад ирлээ. 2 сарын 16-18-ны өдрүүдэд Казакстан улсын Алматы хотод байрлах Казах-Японы төв, 18-20-ний өдрүүдэд Кыргызийн Бишкек хот дахь Кыргыз-Японы төв, 20-22-ны өдрүүдэд Узбекистаны Ташкент дахь Узбек-Японы төвөөр тус тус зочилж, холбогдох албаны удирдлагуудтай уулзаж, санал солилцлоо. Казах-Японы төв нь Монгол-Японы төвтэй адил 2002 оноос, Кыргыз-Японы төв нь 1995 оноос, Узбек-Японы төв нь 2000 оноос эхлэн үйл ажиллагаа явуулж байна.

Тус томилолтын гол зорилго нь Япон төвүүд хоорондоо туршлага солилцох, цаашид хамтран ажиллах боломжуудын талаар судлах, санал тавих зорилготой байсан юм. Уулзалтын үеэр хамтарсан сургалт, семинар зохион байгуулах, төвийн багш нар болон ажилтнуудыг харилцан солилцож, туршлага судлуулах, улмаар тус төвүүдийн бизнесийн сургалтын төгсөгч компаниудыг хооронд нь холбох, төгсөгчдийн холбоо



байгуулах, туршлага солилцох бизнес аялал зохион байгуулах зэрэг ажлуудын талаар санал солилцов.



Зураг 26 Казах-Япон төвийн хамт олонтой

Зураг 27 Казах-Япон төвтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа

Энэ ажлын хүрээнд Казах-Японы төвийн бизнесийн сургалтын төгсөгч компани болох “Галанз ботлерс” шингэн хүнсний компанийн үйлдвэрээр зочилж, Кайзэн болон 5S-ийг хэрхэн хэрэгжүүлж байгаатай танилцлаа.



Зураг 28 Кыргыз-Япон төвийн захирлын хамт

Мөн Казакстан улсад үйл ажиллагаа явуулж буй Японы хөрөнгө оруулалттай “Азума Үню” компанийн төлөөлөлтэй уулзаж, Казакстан дахь бизнесийн орчны талаар санал солилцов. Мөн Казах-Японы төвтэй “Хамтын ажиллагааны санамж бичиг” үзэглэлээ.

Кыргыз-Японы төвтэй хийсэн уулзалтын дараа томилолтын багийнхан тус төвийн төгсөгч компани болох дүнсэн тамхи үйлдвэрлэгч компанийн захирал болон Төв Азийн Бизнес Ассоциацийн ТУЗ-ийн даргатай уулзаж, Кыргыз компаниуд манай улсын ямар салбартай хамтрах хүсэлтэй байгаа талаар нь санал солилцов.

Бидний зочилсон 3 дахь улс болох Узбекстан улсад мөн адил Узбек-Японы төвийн үйл ажиллагаатай танилцаж, удирдлагуудтай уулзан, санал солилцсоны дараа бизнесийн сургалт төгсөгч хоёр компаниар зочилсон юм. Бидний очсон эхний компани бол “Сафия” нарийн боов, бялуу, амтганы үйлдвэр байсан бөгөөд 24 цагийн тасралтгүй үйл ажиллагаатай массын үйлдвэрлэлийг явуулахад Кайзэн болон 5S-ийг хэрхэн амжилттай хэрэгжүүлж байгаагаа танилцуулсан юм. Дараагийн зочилсон компани бол Төв Азийн



зах зээлд ариун цэврийн төрөл бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлэгч “Sunlight Group” байв. Бүрэн автоматжуулсан 24 цагийн үйл ажиллагаатай үйлдвэрлэлийг явуулахад юун дээр анхаардаг, мөн ТХЗ-уудыг компани дээрээ хэрхэн хэрэгжүүлж байгаатай үзэж танилцсанаар бидний энэ удаагийн томилолт өндөрлөсөн юм.



Зураг 29 Узбек-Япон төвийн хамт олонтой

Цаашид Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв үйл ажиллагаагаа Япон төвүүд хоорондын хамтын ажиллагаагаар улам өргөжүүлж, үйлчлүүлэгчдийнхээ эрэлт хэрэгцээнд нийцсэн, цаг үетэйгээ хөл нийлүүлсэн сургалт, үйл ажиллагааг хүргэхийн төлөө хичээн ажиллах болно.

Олон нийтлэл дээрх төгсөгч компаниудын цахим хуудсаар зочлоорой.

Казах-Японы төв <https://kjc.kz/ja/about/>

Кыргыз-Японы төв <https://krjc.kg/>

Узбек-Японы төв <https://ujc.uz/>

4) Монгол улсын “Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах” сэдэвт Япон дахь дадлага сургалтыг амжилттай зохион байгууллаа.

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв нь Япон Улсын Нийгата мужийн “Олон улсын техник технологи хамтын ажиллагааны холбоо”-той хамтран Монгол улсын “Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах” сэдэвт Япон дахь дадлага сургалтыг хамтран зохион байгуулах 3 жилийн гэрээ байгууллаа. Энэ гэрээний дагуу тус дадлага сургалтад хүнсний салбарт үйлдвэрлэл эрхлэгч Монгол-Японы төвийн Бизнесийн үндсэн сургалт төгсөгч хоёр компанийн төлөөлөл болон тус төвийн Бизнесийн хамтын ажиллагааны тасгийн мэргэжилтэн гурван хүний бүрэлдэхүүнтэй баг 2025 оны 11-р сарын 4-нөөс 10-ны өдрүүдэд Нийгата мужийн аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцаж, туршлага солилцлоо.



Хүснэгт-2: "Үйлдвэрлэлийн технологийг сайжруулах" сэдэвт Япон дахь дадлага сургалтын оролцогчид

| № | Нэр | Албан тушаал | Байгууллагын нэр |
|---|-------------|--|------------------|
| 1 | Г.Уянга | Бизнесийн хамтын ажиллагааны тасгийн мэргэжилтэн | Монгол-Япон төв |
| 2 | Г.Оюун | Үйлдвэр хариуцсан дарга | Жүр-Үр ХХК |
| 3 | Б.Өлзийбаяр | Гүйцэтгэх захирал | Nice Bakery ХХК |

Тус сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажлаас эхлээд хөтөлбөр боловсруулалт дээр Монгол-Японы төв болон Нийгата мужийн “Олон улсын техник технологи хамтын ажиллагааны холбоо” хамтран ажиллаж, сургалтад оролцогч компаниудын эрэлт хэрэгцээг урьдчилан судалж, түүнд тааруулан зочлох компани болон зөвлөгөө авах мэргэжилтэн, судалгааны байгуулга зэргийн агуулгыг тогтсон нь тус сургалтын үр дүн өндөр байх шалтгаануудын нэг байсан бөгөөд тус сургалтын үеэр оролцогчид Япон компанийн үйл ажиллагаатай танилцаад зогсохгүй Японы соёл, Япон маягийн менежментийн арга барилтай бодитоор танилцах, өөрсдийн компанидаа хэрэгжүүлэх олон олон санааг олж авсан үр дүнтэй хөтөлбөр болж өндөрлөлөө.



Зураг 30 New Masuya бэйкэри, дэлгүүртэй танилцах үеэр



Зураг 31 New Masuya бэйкэри, дэлгүүртэй танилцах үеэр

Энэхүү дадлага сургалт нь гэрээний хугацаанд 2026 онд мөн зохион байгуулагдахаар төлөвлөгдөж буй бөгөөд цааш цаашдын сургалтын хөтөлбөр, агуулгыг тогтмол сайжруулан, бодит үр дүнд хүрэхүйц дадлага сургалт болгохоор төлөвлөн ажиллаж байна.



Ш. ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ТАСАГ





I. 2025 ОНД ЗОХИОН БАЙГУУЛСАН ЯПОН ХЭЛНИЙ СУРГАЛТ, СЕМИНАРЫН ТАЙЛАН

Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв /цаашид Монгол-Японы төв гэх/-ийн Япон хэлний сургалтын тасаг нь 2012 оны 04 сараас Япон сангийн япон хэлний боловсролын стандартад /цаашид JF стандарт гэх/ нийцүүлсэн япон хэлний сургалтыг хавар, зун, намрын улиралд зохион байгуулж байна. Түүнчлэн “Монгол японы төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт”, “Япон оюутнуудад зориулсан Монгол орны талаарх тайлбар лекц”, “Монгол, япон соёлтой танилцацгаая тусгай сургалт” зэрэг олон төрлийн сургалтуудыг төлөвлөн хэрэгжүүллээ.

Мөн түүнчлэн 2025 оны 7 сард Япон Улсын Цог Жавхлант Эзэн Хаан, Эрхэм Дээд Хатны хамт Монгол Улсад төрийн айлчлал хийх болсонтой холбогдуулан “Монгол–Япон хоёр орны найрамдалт харилцаа, эрхэм түншлэлийг билэгдэн “Япон хэлээр бяцхан ном бүтээцгээе-2025” уралдааныг анх удаа зохион байгууллаа.

Дээр дурдсан сургалтаас гадна бусад байгууллагуудын хүсэлтийн дагуу гэрээт ажлуудыг гүйцэтгэлээ. Тухайлбал, 2025 онд “Тусгай ур чадварын тогтолцоо”-той холбоотой үйл ажиллагаа, “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”, “ЖАЙКА-ийн дадлагажигч хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалт”-ыг үргэлжлүүлэн амжилттай зохион байгууллаа.

1. Япон хэлний сургалтын талаар

Япон хэлний сургалт нь дээр дурдсан JF стандартын дагуу явагдаж байгаа болно. Энэхүү тайлан мэдээ нь 2025 оны 02 сараас 05 сарын хооронд явагдсан хаврын сургалт болон 05 сараас 07 сарын хооронд явагдсан зуны сургалтын эхний хагас, 07 сараас 08 сарын хооронд явагдсан зуны сургалтын сүүлийн хагас, 09 сараас 12 сарын хооронд явагдсан намрын сургалт /дуусах хугацаа 2025 оны 01 сар/-уудын тайлан болно.

Хавар, намар явагддаг сургалтуудад суралцагчдын түвшинд тохирсон “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт”-ууд болон “11-13 насны хүүхдэд зориулсан марүгото япон хэлний анхан шатны сургалт”, япон хэлний багш нарт зориулсан “Япон хэлний заах аргын сургалт”-ыг явуулж байна. Дээрх сургалтуудын агуулга болон үр дүнгийн дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтээс харна уу. Хавар болон намрын сургалт нь дөрвөн сар орчим үргэлжилдэг ба “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1” /анхан шат/-



ээс “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-6” /дунд шат/ хүртэл явагддаг. 2025 оны “Япон хэлний заах аргын сургалт” нь хавар болон намар “Япон сангийн япон хэлний боловсролын стандартыг ашиглан явуулах анхан шатны сургалтын заах арга зүй” сэдвээр явагдсан. Зуны сургалтын эхний болон сүүлийн хагаст “Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт”-ыг нийт 4 удаа, “8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний анхан шатны сургалт”-ыг 1 удаа тус тус зохион байгууллаа.

Үүнээс гадна 2023 оноос эхлэн шинээр зохион байгуулж буй “Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт” /нийт 15 удаагийн 38 цаг/, зуны улиралд “РРТ-д суурилсан япон хэлний сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах арга зүй” сэдэвт дадлага ажилд суурилсан сургалтыг энэ онд мөн явуулсан төдийгүй намрын улиралд дундаас дээш түвшний мэдлэгтэй суралцагчдад зориулан “Бизнесийн япон хэлний сургалт”-ыг тус тус амжилттай зохион байгуулсан.

2.Хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны талаар (Симпозиум, Уран илтгэлийн тэмцээн, Монголын япон хэлний сургалт, судалгааны ээлжит хурал)

2025 онд хамтран зохион байгуулсан үйл ажиллагааны хувьд, 3 сард “16 дахь удаагийн япон хэлний боловсролын симпозиум”-ыг Япон сантай хамтран зохион байгуулж, 11 сард “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 31 дахь удаагийн тэмцээн”-ийг Япон улсын элчин сайдын яам, Монголын япон хэлний багш нарын холбоо, ШУТИС-ийн Гадаад хэлний институт, Япон сантай тус тус хамтран зохион байгууллаа. Түүнээс гадна “Монголын япон хэлний сургалт, судалгааны холбооны ээлжит хурал” зэрэг олон төрлийн үйл ажиллагааг хамаарал бүхий байгууллагуудтай хамтран амжилттай зохион байгууллаа.

3. “16 дахь удаагийн япон хэлний боловсролын симпозиум”

2025 оны 3 сарын 16-ны Ням гарагт “16 дахь удаагийн япон хэлний боловсролын симпозиум” зохион байгуулагдсан ба ерөнхий зохион байгуулагчаар Монголын япон хэлний багш нарын холбоо, хамтран зохион байгуулагчаар Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв болон Япон сан, дэмжигч байгууллагаар Монгол улс дахь Япон Улсын Элчин Сайдын Яам ажиллалаа. Симпозиумын үндсэн лекцийг Хитоцүбаши их сургуулийн дэд профессор Хаяакава Кёоко “Япон хэлний сургалтад ханз үсэг заах арга-сүүлийн үеийн чиг хандлага” сэдвээр уншиж, үргэлжлүүлэн “Танихуйн үүднээс шинэ ханз сурах аргыг эрэлхийлэх нь-бүтээлч байдлаар ханз заах сургалтын хэрэглэгдэхүүн зохиоцгооё” сэдвийн хүрээнд воркшоп зохион байгуулав. Монголын япон хэлний багш



нарт шинэ мэдлэг мэдээлэл, шинэ санаа өгөхүйц сонирхолтой симпозиум болж өнгөрлөө. Түүнчлэн орон нутгаас ирж оролцох багш нарын замын зардлыг Монголын япон хэлний багш нарын холбоо гаргаж дэмжлэг үзүүллээ.

4. “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 31 дахь удаагийн тэмцээн”

2025 оны 11 сарын 15-ны Ням гарагт “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 31 дэх удаагийн тэмцээн”-ийг амжилттай зохион байгууллаа. Тус тэмцээний ерөнхий зохион байгуулагчаар Монгол дахь Япон Улсын Элчин Сайдын Яам, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Монголын япон хэлний багш нарын холбоо, ШУТИС Гадаад хэлний сургууль болон Япон сан ажилласан ба хамтран зохион байгуулагчаар “Монгол дахь Япончуудын холбоо” ТББ, “Монгол-Японы худалдааны танхим” ТББ тус тус оролцлоо.

2 удаагийн урьдчилсан шатны шалгаруулалтаас эцсийн шалгаруулалтад “Ахлах ангийн сурагч” ангилалд 10 сургуулийн 10 сурагч, “Их, дээд сургуулийн оюутан” ангилалд 7 сургуулийн 7 оюутан шалгарав. “Ахлах ангийн сурагч” ангиллын сурагчид “モンゴル人のいいところ” буюу “Монгол хүний сайхан чанар” гэсэн сэдвээр, “Их, дээд сургуулийн оюутан” ангиллын оролцогчид “日本語を学ぶとは” буюу “Япон хэл сурснаар...” гэсэн сэдвийн дагуу тус бүр илтгэлээ тавилаа. Ахлах болон их сургуулийн ангиллын шилдэг 4 оролцогч тус бүрт Монгол дахь Япон Улсын Элчин Сайдын Яамнаас хэрэгжүүлдэг “JENESYS” буюу Япон орны талаарх ойлголтыг нэмэгдүүлэх солилцооны хөтөлбөрт хамрагдах эрхээр шагнагдлаа.

Анкет судалгаанаас үзэхэд, оролцогчдын зүгээс “Монгол хүний хувиар япон хүмүүст “монгол хүн бол ийм хүмүүс” гэдгийг хүргэж чадсандаа баяртай байна”, “Маш баяртай байна. Япон хэл сурсандаа баярлаж, өөрөөрөө бахархлаа” зэрэг сэтгэгдлүүд бичсэн байв. Мөн хамтран зохион байгуулагчдын зүгээс “Монгол хүний сайн талыг япон хүмүүст таниулах сайхан боломж болж чадлаа”, “Япон хэлийг сурахын давуу тал болон илтгэгчдийн яруу тод илтгэж буй байдлаас япон хэл сурах утга учрыг илүү сайн ойлгосон мэт санагдав” гэх мэт сэтгэгдлүүдийг үлдээсэн байлаа.



5. “Монголын япон хэлний сургалт судалгааны уялдаа холбоо”

Япон хэлний боловсролын судалгааны тайлан хурлыг /зуны урт амралтыг эс тооцвол/ сар бүрийн 3 дахь бямба гарагт 10:30–12:30 цагт Монголын япон хэлний багш нарын холбоотой хамтран зохион байгуулсан. Энэ жил 8 удаа зохион байгуулж, Монголын япон хэлний багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд хувь нэмэр болох илтгэл, япон хэлний боловсролтой холбоотой мэдээ мэдээллийг хуваалцах зэргээр багш нар хоорондоо харилцан суралцах, холбоо харилцаа тогтоох талбар болж чадлаа.



2025 онд япон хэлний сургалтын тасгаас зохион байгуулсан үйл ажиллагаа
Хүснэгт-3: Хавар, зун, намрын сургалтууд

Эх сурвалж: Монгол-Японы төв, Япон хэлний сургалтын сар бүрийн тайлан

| № | Сургалтын нэр | Удаа, цаг | Агуулга | Багш | Сурал цагчдын тоо |
|---|--|---|---|--|-------------------|
| 1 | 8-10 насны хүүхдэд зориулсан япон хэлний анхан шатны сургалт | 20 удаа 30 цагийн сургалт 1 удаа зохион байгуулсан | Япон хэлийг хөгжилтэй аргаар сурах хүсэлтэй 8-10 насны хүүхдүүдэд зориулсан сургалт. Мэндчилгээний үг хэллэг, өөрийгөө болон гэр бүлээ танилцуулах, дуртай идэх уух зүйл, өөрийн биеийн бүтэц, төрсөн өдөр, хобби, амралтын өдөр зэргийн талаар ярьж сурах. Мөн хирагана, катакана үсгийг уншиж, бичиж сурах, Катакана үсгээр өөрийн нэр болон улсын нэрийг уншиж, бичиж сургах сургалт | П.Марал, Б.Буманцэцэг, Икома Каорү | 12 |
| 2 | 11-13 насны хүүхдэд зориулсан марүгото япон хэлний анхан шатны сургалт /А1 түвшин/ | 26 удаа 52,5 цагийн сургалт 2 удаа зохион байгуулсан | Япон хэлийг анхлан суралцаж буй 11-13 насны хүүхдүүдэд зориулсан, JF стандартын дагуу бэлтгэн гаргасан “Марүгото нюүмон-А1, кацүдоо” сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт | П.Марал, Э.Болорсүвд, Күрияма, Томоюки | 23 |
| 3 | Япон хэлний анхан шатны түргэвчилсэн сургалт /А1 түвшин/ | 30 удаа 67,5 цагийн сургалт 4 удаа зохион байгуулсан | Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сургалт бөгөөд JF стандартын дагуу бэлтгэн гаргасан “Марүгото нюүмон А1 рикаи” сурах бичгийг ашиглан сонсох, ярих, унших, бичих чадваруудыг олгох сургалт | Д.Золзаяа, Д.Цацрал, Д.Мөнхтуяа, О.Булган, Б.Буманцэцэг, Икома Каорү, Күрияма Томоюки | 68 |
| 4 | Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-1 /А1 түвшин/ | 42 удаа 84 цагийн сургалт 5 удаа зохион байгуулсан | Япон хэлийг анхлан суралцаж буй хүмүүст зориулсан сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх сургалт бөгөөд JF стандартын дагуу бэлтгэн гаргасан “Марүгото нюүмон-А1 кацүдоо, рикаи” хэмээх 2 сурах бичиг дээр тулгуурласан сургалт | Д.Золзаяа, Д.Цацрал, С.Амарбаясгалан, О.Булган, Б.Буманцэцэг, Икома Каорү, Күрияма Томоюки | 110 |



| | | | | | |
|---|--|--|--|--|----|
| 5 | Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-2 /A2 түвшний эхний шат/ | 42 удаа 84 цагийн сургалт 4 удаа зохион байгуулсан | A1 түвшний япон хэлийг эзэмшсэн суралцагчдад зориулсан дараагийн A2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. JF стандартын дагуу бэлтгэн гаргасан “Марүгото шокюү-1 A2 кацүдоо, рикаи” хэмээх 2 сурах бичиг дээр тулгуурласан сургалт | Д.Мөнхтуяа, О.Булган, Б.Буманцэцэг, Ц.Онон, Күрияма Томоюки | 77 |
| 6 | Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-3 /A2 түвшний дунд шат/ | 42 удаа 84 цагийн сургалт 3 удаа зохион байгуулсан | A2 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, дараагийн шатны A2 түвшний дунд шатны мэдлэгийг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. JF стандартын дагуу бэлтгэн гаргасан “Марүгото шокюү-2 A2 кацүдоо, рикаи” хэмээх 2 сурах бичиг дээр тулгуурласан сургалт | Д.Золзаяа, П.Алтанбулаг, О.Булган, П.Марал, Күрияма Томоюки | 44 |
| 7 | Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-4 /A2 түвшний төгсгөлийн шат-B1 түвшний эхний шат/ | 31 удаа 62 цагийн сургалт 2 удаа зохион байгуулсан | A2 түвшний дунд шатыг эзэмшсэн суралцагчдад зориулсан, A2 түвшний төгсгөлийн шат болон B1 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. JF стандартын дагуу бэлтгэн гаргасан “Марүгото шочюүкюү A2/B1” сурах бичиг тулгуурласан сургалт | П.Марал, П.Алтанбулаг, Цүрүта Ясүюки, Томиока Фүмиока, Икома Каору | 37 |
| 8 | Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5 /B1 түвшин/ | 30 удаа 60 цагийн сургалт 2 удаа зохион байгуулсан | B1 түвшний эхний шатыг эзэмшсэн суралцагчдад зориулан B1 түвшний дунд шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. JF стандартын дагуу бэлтгэн гаргасан “Марүгото чюүкюү-1 B1” сурах бичиг дээр тулгуурласан сургалт | Ц.Онон, П.Марал, Күрияма Томоюки | 23 |
| 9 | Япон хэлний яриа, дүрэм хосолсон цогц сургалт-6 /B1 түвшин/ | 29 удаа 58 цагийн сургалт 1 удаа зохион байгуулсан | B1 түвшний төгсгөлийн шатны суралцагчдад B2 түвшний эхний шатыг эзэмшүүлэх зорилго бүхий сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь олгох сургалт юм. JF стандартын | Ц.Онон, Томиока Фүмиока | 13 |



| | | | | | |
|----|--|---|---|---|----|
| | | | дагуу бэлтгэн гаргасан “Марүгото чюүкюү-2 В1” сурах бичиг дээр тулгуурласан сургалт | | |
| 10 | Бизнесийн япон хэлний сургалт-2025 | 11 удаа 22 цагийн сургалт 1 удаа зохион байгуулсан | Дунд дээд түвшний япон хэл суралцагчдын бодит хэрэглээ, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн боловсруулсан сургалт юм. Япон хүмүүстэй ажил хэргээ саадгүй явуулахад нь тус дөхөм болох үүднээс бизнесийн харилцаанд утсаар хэрхэн ярих, бичиг баримт хэрхэн боловсруулах, и-мэйл хэрхэн бичих талаар ойлголт өгөх зорилго бүхий ярих, бичих, илтгэх гэсэн 3 хэсэг бүхий сургалтын агуулгатай сургалт | Э.Эрдэнэцэцэг, Икома Каорү | 15 |
| 11 | Япон хэлтэй аяллын хөтөч-тайлбарлагч бэлтгэх сургалт 2025 | 15 удаа 38 цагийн сургалт 1 удаа зохион байгуулсан | Япон жуулчдын хөтөч-тайлбарлагчаар ажиллах хүсэлтэй хүмүүст зориулан аяллын хөтчийн ноу-хау, ёс зүй, гадаад төрх байдал, хувцаслалт, мэдвэл зохих үг хэллэгийн талаарх ойлголтыг өгч, бодитоор хэрэглэхэд нь туслах зорилго бүхий сургалт бөгөөд лекц, бодит туршлага дээр үндэслэсэн яриа, хосоор болон багаар ажиллах дасгал даалгавар зэрэг онол, практик хослуулсан сургалт | Үндсэн багш: О.Булган, Э.Эрдэнэцэцэг, Б.Буманцэцэг Зочин багш: Б.Батмөнх, Б.Дуламсүрэн /Монголын мэргэжлийн хөтөч тайлбарлагчдын холбоо/, Б.Гантулга /Монголын улаан загалмай нийгэмлэг/ | 28 |
| 12 | Япон хэлний заах аргын сургалт /В2-С1 түвшин/ | 1) 8 удаа 16 цагийн сургалтыг 1 удаа 2) 13 удаа 26 цагийн сургалтыг 1 удаа зохион байгуулсан | - Хоёр дахь хэл эзэмшихүйн онол болон Япон сангийн япон хэлний боловсролын стандартыг ашигласан япон хэлний заах арга зүйн суурь ойлголтод суралцах - Анхан шатны япон хэлний нэгж хичээлийн хөтөлбөрийг боловсруулахад суралцаж, өөрийн боловсруулсан хөтөлбөрт үндэслэн жишиг хичээлийг заах дадлага бүхий сургалт | Томиока Фүмиока, С.Амарбаясгалан | 23 |
| 13 | Япон хэлний хичээлд зориулсан РРТ хэрэглэгдэхүүн бэлтгэх дадлага сургалт | 6 удаа 18 цагийн сургалт 1 удаа зохион байгуулсан | - Япон хэлний хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэхэд шаардагдах РРТ-ийн үндсэн функц, техникийг суралцах - Яриа, дүрэм, үсэг, үгийн сан голлосон хичээл тус бүрийн онцлогт тохирсон РРТ хэрэглэгдэхүүн бэлтгэх, хичээл заах дадлага бүхий сургалт | Күрияма Томоюки | 6 |



Хүснэгт-4: Тусгай сургалт, семинарууд

| № | Үйл ажиллагааны нэр | Удаа, цаг | Агуулга | Илтгэгч болон хариуцсан ажилтан | Оролцогчдын тоо |
|---|--|--|--|--|-----------------|
| 1 | ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулсан заах аргын сургалт-2025 *МЯХБХолбооноос ЕБС-ийн багш нарт төлбөрийн дэмжлэг үзүүлэв. | 3 удаа 10,5 цагийн сургалт 1 удаа зохион байгуулсан | ЕБС-ийн япон хэлний багш нарт зориулан заах аргазүйн сургалтыг зохион байгуулж, Монгол орон даяар япон хэлний боловсролыг түгээн дэлгэрүүлэх, чанаржуулахад хувь нэмэр оруулах, ЕБС-ийн багш нарын хоорондын харилцаа холбоог бэхжүүлэх зорилго бүхий сургалт. Сургалтын сэдэв: “Анхан шатны уншиж ойлгох хичээлийн заах арга ба үнэлгээ” | Багш: Цүрүта Ясүюки Сургалт хариуцсан ажилтан: П.Марал, Д.Цацрал | 40 |
| 2 | Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт *Гэрээт сургалт | 32 удаа 65 цагийн сургалт 1 удаа зохион байгуулсан | Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөрт тэнцсэн, япон хэл огт үзэж байгаагүй хүмүүст зориулсан сургалт. Япон сангийн япон хэлний боловсролын стандартын дагуу бэлтгэн гаргасан "Иродори хэрэглээний япон хэл" /A1 түвшний суурь шат/ сурах бичгийг ашиглан япон хэлний анхан шатны сонсох, ярих, унших, бичих 4 чадварыг цогцоор нь эзэмшүүлэх зорилго бүхий сургалт | Д.Мөнхтуяа, Д.Золзаяа, Күрияма Томоюки | 13 |
| 3 | ЖАЙКА-ийн зуны дадлага хөтөлбөрт хамрагдах оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалт *Гэрээт сургалт | 48 удаа 150 цагийн сургалт 1 удаа зохион байгуулсан | Япон улсад дадлага хөтөлбөрт хамрагдахад шаардлагатай япон хэлний харилцааны чадвар суулгахыг сацуу сургалт төгсөх үед JLPT-N3 түвшин болон түүнтэй дүйцэхүйц хэмжээний япон хэлний мэдлэг эзэмшүүлэх зорилго бүхий сургалт | С.Амарбаясгалан, Д.Мөнхтуяа, П.Марал, Күрияма Томоюки | 28 |
| 4 | ЖАЙКА-ийн өвлийн дадлага хөтөлбөрт хамрагдах оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалт *Гэрээт сургалт | 47 удаа 164 цагийн сургалт 1 удаа зохион байгуулсан | Япон улсад дадлага хөтөлбөрт хамрагдахад шаардлагатай япон хэлний харилцааны чадвар суулгахыг сацуу сургалт төгсөх үед JLPT-N3 түвшин болон түүнтэй дүйцэхүйц хэмжээний япон хэлний мэдлэг эзэмшүүлэх зорилго бүхий сургалт | С.Амарбаясгалан, П.Марал, Ц.Онон, Күрияма Томоюки | 18 |
| 5 | ЖАЙКА-ийн дадлага хөтөлбөрт хамрагдах оюутнуудад зориулсан сургалт эхлэхийн өмнөх япон хэлний түвшинг нягтлах яриа болон бичгийн шалгалт | тус бүр 6 цагийн шалгалт 2 удаа зохион байгуулсан | Оюутны сурах идэвх эрмэлзлийг нягтлах ярилцлага хавсарсан JLPT-N4 түвшний бичиг болон ярианы шалгалт | Э.Эрдэнэцэцэг, С.Амарбаясгалан, Д.Мөнхтуяа, П.Марал, Д.Цацрал | 68 |



| | | | | | |
|----|--|---|--|---|-----|
| 6 | ЖАЙКА-ийн дадлага хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудад зориулсан зориулсан япон хэл дээрх ярилцлагын бэлтгэл | тус бүр 2 цагийн үйл ажиллагаа 2 удаа зохион байгуулсан | Хүлээн авагч байгууллагуудын ярилцлагад бэлдэх зорилгоор товч намтрын мэдээлэл дээр тулгуурлан япон хүнтэй хийх туршилт ярилцлагыг зохион байгуулж, ярилцлагын дараа зөвлөмж өгсөн. | Сато Мүцүми, Мацүи Юкиэ, Томиока Фүмико, Ишибаши Кацүюки | 49 |
| 7 | ЖАЙКА-ийн дадлага хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудыг хүлээн авах байгууллагуудад зориулсан нээлттэй хичээл болон МЯТөвийн танилцуулга | 1 удаа 2,5 цагийн үйл ажиллагаа 2 удаа зохион байгуулсан | Оюутнуудыг дадлагаар хүлээн авах Японы засаг захиргааны нэгж болон компаниудын холбогдох хүмүүст зориулан нээлттэй хичээлийг зохион байгуулж, ярианы чадварыг хөгжүүлэх сургалтын онцлог, сургалтын үр дүнг таниулах, оюутнуудын хичээлд оролцож буй байдлыг харуулахыг зорив. Мөн төвийн үйл ажиллагаа болон япон хэлний сургалтын талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг хийв. | Нээлттэй хичээл: С.Амарбаясгалан МЯТ-ийн танилцуулга: Х.Гармаабазар, Э.Эрдэнэцэцэг | 90 |
| 8 | ЖАЙКА-ийн дадлага хөтөлбөрт хамрагдах оюутнуудын Монгол-Японы төв дахь 1 өдрийн ажлын дадлага | 1 оюутан 8 цагийн дадлага 2 удаа зохион байгуулсан | Дадлага хөтөлбөрт хамрагдах оюутнуудыг тасгуудад хуваарилан ажлын 1 өдрийн дадлага хийлгэв. | Э.Эрдэнэцэцэг, С.Амарбаясгалан, Б.Буманцэцэг | 39 |
| 9 | Япон соёлын танилцуулах хичээл – “Шёдоо” буюу бийрэн бичлэг | 1 удаа 2 цагийн хичээл 1 удаа зохион байгуулсан | Бийрэн бичлэгийн гарал үүсэл, түүх, үндсэн аргуудтай танилцаж, зөв бичих аргачлалыг сурахын зэрэгцээ, бийрэн бичлэгээр өөрийн гэсэн бүтээлийг бичсэнээр, анхаарал төвлөрөх чадвар, өөрийгөө илэрхийлэх чадвараа дээшлүүлэн, бийрэн бичлэгийн уран тансгийг мэдрүүлэх зорилго бүхий танилцуулах хичээл | П.Марал, Б.Буманцэцэг | 13 |
| 10 | Япон соёлын танилцуулах хичээл - Гелэн лаа | 1 удаа 2 цагийн хичээл 1 удаа зохион байгуулсан | Японы дахин боловсруулж ашиглах соёл буюу юмхнаар юм хийх соёлын талаар танилцуулж, өөрийн гараар гелэн лаа хийж сурах сургалт. | П.Марал, Б.Буманцэцэг | 17 |
| 11 | Япон соёлын танилцуулах хичээл - “Омамори” буюу хамгаалагч сахиус *Мобиком корпораци ХХК-ийн хүсэлтээр | 2 удаа 3 цагийн хичээл 1 удаа зохион байгуулсан | “Япон фестиваль Монголд-2025” өдөрлөгийн хүрээнд Мобиком корпорацийн хүсэлтээр зохион байгуулсан сургалт бөгөөд Японы “омамори” буюу хамгаалагч сахиусны утга учир, урлах аргыг зааж танилцуулав. | П.Марал, Б.Буманцэцэг, С.Амарбаясгалан | 140 |
| 12 | Монгол соёлын танилцуулах хичээл - Монгол уран бичлэг | 1 удаа 2,5 цагийн хичээл | Их эзэн Чингис хааны мэндэлсэн Монгол бахархлын өдөрт зориулан зохион байгуулсан бөгөөд оролцогчид Монгол уран | Зочин багш: “Бичиг соёл төв”-ийн багш Э.Мөнхбаяр | 11 |



| | | | | | |
|----|--|---|---|--|-----|
| | | 1 удаа зохион байгуулсан | бичлэгийн гарал үүсэл, түүх, бичих арга барилтай танилцан өөрийн дуртай үгийг монгол бичгээр уран сайхнаар бичиж, бичвэрээ авч харив. | Орчуулагч болон хариуцсан ажилтан: П.Алтанбулаг, Т.Болормаа | |
| 13 | Японы Сүгинами дунд, ахлах сургуулийн сурагчдад зориулсан МЯТ-ийн танилцуулга *“Lets Travel” ХХК-ийн хүсэлтээр | 1 удаа 1 цагийн үйл ажиллагаа 1 удаа зохион байгуулсан | “Гадаад оронд ажиллаж амьдарч буй япон иргэдийн амьдралын хэв маяг, бодит байдал” сэдвээр ярилцаж, санал бодлоо солилцов. | Томиока Фүмико, Күрияма Томоюки, Саго Мүцүми, Икома Каорү, Мацүо Фүми, Б.Буманцэцэг, Э.Тэнгис, Д.Мөнхтуяа | 61 |
| 14 | “Хаврын мэдээллийн яармаг-2025” арга хэмжээний үеэрх сургалт, үйл ажиллагааны танилцуулах булан | 1 өдөр 7 цагийн үйл ажиллагаа | Япон хэлний зун, намрын сургалтын сурталчилгаа, JFT-Basic шалгалтын тайлбар, Монголд авч буй япон хэлний албан ёсны шалгалтуудын тайлбарыг хийв. | Э.Эрдэнэцэцэг, П.Алтанбулаг | 51 |
| 15 | “Япон будааны баяр-2025” арга хэмжээний үеэрх МЯТ-ийн сургалт, үйл ажиллагааны танилцуулах булан *“MJ Partners” ХХК-ийн хүсэлтээр | 2 өдөр 16 цагийн үйл ажиллагаа | Төвийн үйл ажиллагааны танилцуулга, япон хэлний намрын сургалтын танилцуулга, сурталчилгааг хийв. | Д.Мөнхтуяа, П.Алтанбулаг, Э.Тэнгис | 365 |
| 16 | Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N1-N5 түвшин/ | 14 удаа зохион байгуулсан | Япон хэлний мэдлэг (үсэг, үгийн сан), хэлний мэдлэг (дүрэм, уншиж ойлгох чадвар), сонсож ойлгох чадварын түвшинг тогтоох JLPT шалгалтын N1-N5 түвшний жишиг шалгалт | Д.Мөнхтуяа, С.Амарбаясгалан, П.Марал, О.Булган, Б.Буманцэцэг, Э.Болорсувд | 220 |
| 17 | Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний түвшин тогтоох жишиг шалгалт /N3- N5 түвшин/ *Их засаг ОУИС, АШУҮИС, Логарифм сургууль, JLA боловсролын төв, JAL инженеринг ХК-ийн хүсэлтээр | 8 удаа зохион байгуулсан | Япон хэлний мэдлэг (үсэг, үгийн сан), хэлний мэдлэг (дүрэм, уншиж ойлгох чадвар), сонсож ойлгох чадварын түвшинг тогтоох JLPT шалгалтын N3-N5 түвшний жишиг шалгалт | Э.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтуяа, С.Амарбаясгалан, П.Марал, П.Алтанбулаг, О.Булган, Б.Буманцэцэг | 213 |
| 18 | Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт /JFT-Basic/-ын удирдамж семинар | 1 удаа 2 цагийн семинар 1 удаа зохион байгуулсан | JFT-Basic шалгалтын талаарх ерөнхий тайлбар, тестийн зорилго, зорилтот хүмүүс, тестийн хэлбэр, компьютерын дэлгэц дээрх зураглал, түүний бүтэц, түвшний үзүүлэлт, тестийн дүнг хэрхэн харах тухай тайлбар, тестийн ерөнхий загварыг танилцуулах, "Иродори онлайн сургалт"-ын талаарх товч танилцуулга, асуулт | П.Алтанбулаг | 23 |



| | | | | | |
|----|--|--|--|---|-----|
| | | | хариултын цаг гэсэн агуулгатайгаар зохион байгуулагдав. | | |
| 19 | Япон улсад “Тусгай ур чадвартай” ажиллах хүч илгээх тогтолцооны талаарх мэдээлэл солилцох семинар Зохион байгуулагч: Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв Хамтрагч: Япон сан, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газар, ШУТИС Англи хэлний академи, Монгол Коосэн технологийн коллеж, GTN MONGOLIA XXX | 1 удаа 2 цагийн семинар 1 удаа зохион байгуулсан | - “Тусгай ур чадвартай” ажиллах хүч илгээх тогтолцооны хүрээн дэх албан ёсны мэдээллийг эрх бүхий байгууллагуудын төлөөллөөр дамжуулан хүргэснээр тус тогтолцооны талаарх нэгдсэн ойлголтод хүрч, цаашид хамтран ажиллах боломжийг бий болгох. - Япон улсад ажиллах хүний нөөцийг бэлтгэж буй ажиллах хүч илгээгч байгууллагууд, япон хэлний сургалтын төвүүдэд нэгдсэн нэг ойлголттойгоор үйл ажиллагаагаа явуулах, үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэх боломжийг олгох зорилго бүхий семинар | Зохион байгуулсан: П.Алтанбулаг, Э.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтуяа | 74 |
| 20 | “Иродори хэрэглээний япон хэл” сурах бичгийг ашигласан заах аргын семинар | 5 удаа 15 цагийн семинар 2 удаа зохион байгуулсан | “Иродори хэрэглээний япон хэл” сурах бичгийн агуулга, онцлог, заах аргын талаарх үндсэн ойлголтыг өгөх сургалт юм. Сургалтын явцад загвар хичээлд оролцон, хичээлийн талаарх санал сэтгэгдлээ хуваалцах, суралцагчид өөрсдөө сурах бичгийг ашиглан хичээл зааж үзэх, заасан хичээлийнхээ талаар харилцан санал бодлоо солилцох, сургалтын талаарх ерөнхий дүгнэлт хийв. | Томиока Фүмиока, Күрияма Томоюки, П.Алтанбулаг | 34 |
| 21 | "Иродори япон хэлний онлайн сургалт"-ын танилцуулах хичээл | 1 удаа 2 цагийн хичээл 4 удаа зохион байгуулсан | “Иродори хэрэглээний япон хэл” сурах бичгийг түгээн дэлгэрүүлэх, Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн /JFT-Basic/ шалгалтад тэнцэх монгол суралцагчдын тоог нэмэгдүүлэхэд туслах зорилгоор “Иродори япон хэлний онлайн сургалт”-ын талаарх ерөнхий ойлголт өгснөөр анхан шатны сурах бичгийн 3-р хичээлийн дасгал даалгавар дээр ажиллаж үзэн сурах бичгийн хэрэглэх аргад сургах зорилго бүхий хичээл | П.Алтанбулаг | 83 |
| 22 | “Тусгай ур чадвар”-ын гэрээт ажлын хүрээнд хэрэгжүүлсэн Дархан хот дахь япон хэлний боловсролыг дэмжих үйл ажиллагаа | 2 өдөр 16 цагийн үйл ажиллагаа | - Дархан хотын япон хэлний боловсролын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцаж япон хэлний багш нартай санал солилцох - “Иродори хэрэглээний япон хэл” сурах бичгийг ашигласан | Томиока Фүмиока, Э.Эрдэнэцэцэг, П.Алтанбулаг, Т.Болормаа, Б.Ууганбаяр | 163 |



| | | | | | |
|----|--|---|---|--|----|
| | | | заах аргын сургалтыг зохион байгуулах - “Japan Discovery Day” арга хэмжээг зохион байгуулах үе шаттайгаар зохион байгуулав. | | |
| 23 | Япон сангийн төсөл хөтөлбөрийн танилцуулах семинар *Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан, Япон улсын элчин сайдын яам, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн хамтарсан үйл ажиллагаа | 1 удаа 2,5 цагийн семинар 1 удаа зохион байгуулсан | “Тусгай ур чадварын тогтолцоо”-ны хүрээнд тус төвөөс хэрэгжүүлж буй япон хэлний боловсролын үйл ажиллагаа, Япон улсад ажиллаж амьдрах хүмүүст зориулсан япон хэлний сургалтын байгууллагад үзүүлэх дэмжлэг, япон хэлний багш нарын Япон улс дахь сургалт семинар, Япон сангийн төсөл хөтөлбөрт бүртгүүлэхэд шаардагдах материал бүрдүүлэлтийн талаар мөн Япон сангийн төсөл хөтөлбөрт хамрагдсан байгууллагын туршлагаас танилцуулав. | ЯЭСЯамны атташе Морияма Масами, Япон сангийн япон хэлний 2-р хэлтсийн төлөвлөлт хөгжлийн багийн ахлах Катаяма Кацүхито, “Жи энд Ди Девелопмент” ХХК дэргэдэх “Мика Монгол” сургалтын төвийн захирал М.Дэлгэрмаа, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн мэргэжилтэн П.Алтанбулаг | 80 |
| 24 | Япон хэлний заах аргын ганцаарчилсан зөвлөгөө *“GTN” Япон хэлний сургалтын төв, Архангай аймгийн “Цагаан-Уул” сургалтын төв, Дархан-Уул аймгийн Дархан-Японы төв, “Дархан Ироха” япон хэлний сургалтын төв | 1 удаа 1 цагийн зөвлөгөө 4 удаа зохион байгуулсан | Сурах бичгийн сонголт, сургалтын материал боловсруулалт, үсэг заах аргачлал, шалгалтын материал боловсруулах болон үнэлэх аргачлал, хүүхдэд зориулсан сургалтын заах аргын талаар тус тус зөвлөгөө өгөв. | Цүрүта Ясүюки, Томиока Фүмико, П.Алтанбулаг, Э.Эрдэнэцэцэг | 4 |
| 25 | Монгол-Япон хоёр орны найрамдалт харилцаа, эрхэм түншлэлийг билэгдэн зохион байгуулсан “Япон хэлээр бяцхан ном бүтээцгээе-2025” уралдааны шалгаруулалт | 1 удаа 3 цагийн үйл ажиллагаа | Монгол улс дахь япон хэлний боловсролын хөгжилд хувь нэмэр оруулах, мөн Монголын нөхцөлд тохирсон япон хэлний сурах бичиг, сургалтын материалын хүрэлцээг нэмэгдүүлэх зорилгоор уралдааныг зарлан ирүүлсэн бүтээлүүдийг багийн болон хувь хүний ангиллаар шалгаруулав. | Шүүгчдийн бүрэлдэхүүн: Э.Батжаргал, Ц.Онон, Мари.М, Томиока Фүмико, Күрияма Томоюки | 24 |
| 26 | “Япон хэлээр бяцхан ном бүтээцгээе-2025” уралдааны шагнал гардуулах ёслолын арга хэмжээ | 1 удаа 1 цагийн үйл ажиллагаа | Уралдааны багийн болон хувь хүний ангиллын шилдэг бүтээлүүдийн эздэд шагнал гардуулах ёслолын арга хэмжээг зохион байгуулав. | Хариуцсан ажилтан: Томиока Фүмико, Күрияма Томоюки, О.Булган, С.Амарбаясгалан | 43 |
| 27 | Япон хэлний сургалтын тайлангийн хурал | 1 удаа 2 цагийн хурал 3 удаа зохион байгуулсан | 2024 оны намар, 2025 оны хавар, зуны сургалтын үр дүнгийн тайланг хэлэлцэж санал сэтгэгдлээ хуваалцаж, дараагийн сургалтын | Хурал хөтлөгч: П.Марал , Э.Эрдэнэцэцэг, Б.Буманцэцэг Хурлын тэмдэглэл хөтлөгч: | 31 |



| | | | | | |
|----|---|---|---|---|-------------|
| | | | төлөвлөгөө, хуваарийг нягтлав. | Д.Мөнхтуяа, Күрияма Томоюки, О.Булган, П.Марал Хуралд оролцогчид: Сургалт хариуцсан багш нар | |
| 28 | 2025 оны хавар, намрын сургалтын өмнөх анги хуваарилах шалгалт | 1 удаа 1,5 цагийн шалгалт 8 удаа зохион байгуулсан | Яриа, дүрэм хосолсон цогц сургалт 2-6 түвшний ангийн элсэлтийн өмнөх анги хуваарилах шалгалт | Э.Эрдэнэцэцэг, Д.Мөнхтуяа, П.Алтанбулаг, О.Булган, Д.Цацрал, Э.Болорсүвд | 112 |
| 29 | Япон хэлний сургалтын тасгийн багш нарт зориулсан заах аргын сургалт, семинар | 1 удаа 1,5 цагийн семинар 8 удаа зохион байгуулсан | Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төвийн япон хэлний багш нарт зориулан япон хэлний боловсрол, заах аргын талаарх мэдлэгээ өргөжүүлэх, харилцан мэдээллээ хуваалцах, сурч мэдсэн зүйлээ өөрийн хичээл сургалтад хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт. | Томиока Фүмико, Б.Буманцэцэг | 79 |
| | | | | | 2186 |

Хүснэгт-5: Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан үйл ажиллагаа

| № | Үйл ажиллагааны нэр | Удаа, цаг | Агуулга | Илтгэгч болон хариуцсан ажилтан | Оролцогчдын тоо |
|---|---|--------------|--|---|-----------------|
| 1 | 16 дахь удаагийн япон хэлний боловсролын симпозиум /Зохион байгуулагч: Монголын япон хэлний багш нарын холбоо Хамтран зохион байгуулагч: Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Япон улсын засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Япон сан Дэмжигч: Япон улсын Элчин Сайдын Яам/ | 1 удаа 6 цаг | Илтгэлийн сэдэв: “Япон хэлний сургалтад ханз үсэг заах арга - Сүүлийн үеийн чиг хандлага” Воркшопийн сэдэв: “Танихуйн үүднээс шинэ ханз сурах аргыг эрэлхийлэх нь - Бүтээлч байдлаар ханз заах сургалтын хэрэглэгдэхүүн зохиоцгооё” | Зочин багш Хаякава Кёоко /Хитоцүбаши их сургуулийн олон улсын боловсролын төвийн профессор/ | 84 |
| 2 | “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 31 дэх удаагийн тэмцээн”-ий 1-р шатны шалгаруулалт /Зохион бичлэг/ | 1 удаа 4 цаг | Тэмцээнд оролцохоор зохион бичлэгээ ирүүлсэн ахлах ангийн 27 сурагчаас 18 сурагч, их дээд сургуулийн 16 оюутнаас 11 оюутан зохион бичлэгийн сонгон шалгаруулалтад тэнцсэн. Зохион бичлэгийн сэдэв: Ахлах ангийн ангилал | Тэмцээний зохион байгуулах комисс | 45 |



| | | | | | |
|---|---|----------------|---|---|-----|
| | | | “Монгол хүний сайхан чанар”, оюутны ангилал “Япон хэл сурснаар...” | | |
| 3 | “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 31 дэх удаагийн тэмцээн”-ий 2-р шатны шалгаруулалт /Ярилцлага/ | 1 удаа 3 цаг | Зохион бичлэгийн сонгон шалгаруулалтаас тунаж үлдсэн ахлах ангийн 18 сурагч, их дээд сургуулийн 16 оюутнаас ярилцлагын шалгалт авч, ахлах ангийн 10 сурагч, их дээд сургуулийн 7 оюутан төгсгөлийн шалгаруулалт болох илтгэлийн тэмцээнд оролцохоор шалгарав. | Тэмцээний зохион байгуулах комисс | 29 |
| 4 | “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 31 дэх удаагийн тэмцээн”-ий өмнөх бэлтгэл | 1 удаа 2 цаг | Тэмцээний өмнөх бэлтгэлийг зохион байгуулав. | Тэмцээний зохион байгуулах комисс | 17 |
| 5 | “Сургууль хоорондын япон хэлний уран илтгэлийн 31 дэх удаагийн тэмцээн” /Хамтран зохион байгуулагч: Япон улсын Элчин Сайдын Яам, Монголын япон хэлний багш нарын холбоо, ШУТИС-ийн Гадаад хэлний институт, Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Япон сан Дэмжигч: Монгол дахь япончуудын холбоо, Монгол-Японы худалдааны танхим/ | 1 удаа 4,5 цаг | Зохион бичлэг болон ярилцлагын шалгалтын дүнгээр тунаж үлдсэн ахлах ангийн 10 сурагч, их дээд сургуулийн 7 оюутан илтгэл тавьж ялагчийг тодруулав. Илтгэлийн сэдэв: Ахлах ангийн ангилал “Монгол хүний сайхан чанар”, оюутны ангилал “Япон хэл сурснаар...” | Тэмцээний зохион байгуулах комисс | 106 |
| 6 | Япон хэлний боловсролын 128 дахь удаагийн семинар /Хамтран зохион байгуулагч: Монголын япон хэлний багш нарын холбоо/ | 1 удаа 2 цаг | Илтгэл 1: “Мэргэд сургуулийн япон хэлний түвшин тогтоох шалгалтад зориулсан давтлага хичээл” Илтгэл 2: “Япон хэлний сурах бичиг дэх туслалцаа хүсэхэд хэрэглэгдэх үг хэллэг ба монгол оюутнуудад тулгардаг бэрхшээл” | Д.Дуламсүрэн /Өвөрхангай аймгийн Мэргэд сургууль/, Асаи Юри /Шинэ Монгол технологийн дээд сургууль, Юү Лангүэж Улаанбаатар төв/ | 23 |
| 7 | Япон хэлний боловсролын 129 дэх удаагийн семинар | 1 удаа 2 цаг | Илтгэл: “Япон сангийн япон хэлний мэргэжилтэн багшийн 2022-2025 оны ажлын тайлан” | Цүрүта Ясүюки /Монгол-Японы төв, Япон сан/ | 19 |
| 8 | Япон хэлний боловсролын 130 дахь удаагийн семинар | 1 удаа 2 цаг | Илтгэл 1: “Япон хэлний багшийн нийгмийн харилцаа ба хиймэл оюун (AI)-ы хэрэглээ” Илтгэл 2: “Ширакава Шизүкагийн нэрэмжит ханз үсгийн уралдааны шагналын тухай” | Б.Буманцэцэг /Монгол-Японы төв/, Б.Үүрийнтуяа /Хобби сургууль/ | 13 |




| | | | | | |
|----|---|--------------|---|--|-----|
| 9 | Япон хэлний боловсролын 131 дэх удаагийн семинар | 1 удаа 2 цаг | Илтгэл: “МЯХБХ-ны жилийн үйл ажиллагааны тухай” | Э.Батжаргал /МЯХБХолбоо/ | 23 |
| 10 | Япон хэлний боловсролын 132 дахь удаагийн семинар | 1 удаа 2 цаг | Илтгэл 1: “Соёлын хичээлийг хэрхэн заах вэ? Монгол-Японы төвийн соёлын танилцуулах хичээлийн туршлагаас” Илтгэл 2: “Ханз заах арга, сурах арга барил” | Б.Буманцэцэг /Монгол-Японы төв/, Жинтэй Томоко /ШУТИС-ийн хос хөтөлбөр/ | 20 |
| 11 | Япон хэлний боловсролын 133 дахь удаагийн семинар | 1 удаа 2 цаг | Илтгэл: “Япон хэлний хөтөч тайлбарлагчийн ур чадварын үнэлгээ зэрэглэлийн судалгаа” | О.Булган /Монгол-Японы төв/ | 21 |
| 12 | Япон хэлний боловсролын 134 дэх удаагийн семинар | 1 удаа 2 цаг | Илтгэл 1: “Монгол-Японы залуучуудын хамтын ажиллагааг дэмжих төвийн 1 өдөр - Япон хэлний хичээлийн танилцуулга” Илтгэл 2: “Анхан, дунд шатны унших бичих дадал хичээлд ашиглаж болох цахим хэрэгслүүд” | Рэйзэй Хироки /МЯЗХАДТөв/, Ц.Онон /МУИС/ | 10 |
| 13 | Япон хэлний боловсролын 135 дахь удаагийн семинар | 1 удаа 2 цаг | Илтгэл 1: “Ес дэх удаагийн ханзны наадам” Илтгэл 2: “Бага, дунд сургуулийн япон хэлний хичээлд тулгарч буй бэрхшээл” | Д.Дуламсүрэн /Өвөрхангай аймгийн Мэргэд сургууль/ Наканиши Рейко /ЕБ-ын Монгени сургууль/ | 17 |
| | | | | | 427 |




Хүснэгт-6: Япон хэлний сургалтад хамрагдсан суралцагчдын тоо

| | 2024 он | 2025 он |
|----------------|---------|---------|
| Хаврын сургалт | 237 | 185 |
| Зуны сургалт | 139 | 86 |
| Намрын сургалт | 228 | 208 |
| Нийт | 604 | 479 |




Хүснэгт-7: Тусгай сургалтад хамрагдсан хүний тоо

| | 2024 он | 2025 он |
|-------------------------------|---------|---------|
| Тусгай сургалт, үйл ажиллагаа | 2,691 | 2,186 |



Хүснэгт-8: Бусад байгууллагатай хамтран зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон хүний тоо

| | 2024 он | 2025 он |
|-------------------------|---------|---------|
| Хамтарсан үйл ажиллагаа | 432 | 427 |





II. ОНЦЛОХ МЭДЭЭ

1) Япон хэлний заах арга зүйн сургалтын хэрэгжилт /Япон хэлний заах арга зүйн сургалт, ЕБС-ийн багш нарт зориулсан япон хэлний заах аргын семинар, “Иродори” сурах бичгийн заах арга зүйн семинар/

Монгол-Японы төвөөс зохион байгуулдаг япон хэлний заах арга зүйн чиглэлийн дараах сургалтууд бий.

- Туршлага багатай япон хэлний багш нар болон япон хэлний багш болохыг зорьж буй хүмүүст зориулсан “Япон хэлний заах арга зүйн сургалт”
- Энэ жил 7 дахь удаагаа зохион байгуулагдаж буй “ЕБС-ийн багш нарт зориулсан заах аргын семинар”
- Япон сангаас хэрэгжүүлж буй тусгай ур чадварын тогтолцооны гэрээт ажлын хүрээнд ““Иродори: Хэрэглээний япон хэл” сурах бичгийн заах арга зүйн семинар”

Эдгээр сургалтын хэрэгжилттэй танилцана уу.

А. Япон хэлний заах арга зүйн сургалт

Тус сургалт нь жилд 2 удаа хавар болон намрын улиралд явагддаг. Сургалтын хөтөлбөрийн хувьд эхний хагаст Япон сангийн баримталдаг суралцагч төвтэй заах арга зүйн стандартыг танилцуулж, түүнд тулгуурласан “Иродори: Хэрэглээний япон хэл” сурах бичгийн аргачлалын дагуу загвар хичээлийг явуулдаг. Сүүлийн хагаст суралцагчид өөрийн биеэр загвар хичээлийг зааж, мэргэжилтэн багшаас зөвлөгөө авснаар суралцагч төвтэй заах арга зүйн талаарх ойлголтоо гүнзгийрүүлдэг.

2025 оны намрын сургалтын эхний хагаст сурах бичгийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлэхийн тулд түгээмэл хэрэглэгддэг сурах бичгийн харьцуулсан судалгаа хийх, мөн загвар хичээлд бэлтгэх 10 минутыг нэмж оруулах зэргийг шинээр туршиж хэрэгжүүллээ. Дээрх сурах бичгийн харьцуулсан судалгаа ба загвар хичээлд бэлтгэх нэмэлт цагийг оруулсан нь суралцагчдын сургалтын материалын талаарх ойлголтыг гүнзгийрүүлэх, мөн загвар хичээл бэлтгэхэд дөхөм байв. Гэвч цаашид суралцагчдын эрэлт хэрэгцээ, явц байдлыг харгалзан үзэж, нэмэлт зохицуулалт хийх шаардлагатай.

В. ЕБС-ийн багш нарт зориулсан заах аргын семинар

Энэхүү семинарыг жилд нэг удаа 1 сард зохион байгуулдаг. Энэ удаад оролцогчдын ачааллыг бууруулах зорилгоор өмнөх жилийн хөтөлбөрийг нэг өдрөөр багасгаж 3 өдөрт багтаан зохион байгуулав. “Анхан шатны уншиж ойлгох хичээлийн заах арга болон үнэлгээ” сэдвээр зохион байгуулсан ба сэдвийг сонгохдоо ЕБС-ийн япон хэлний багш нарын семинарт хамрагдсан оролцогчдын дэвшүүлсэн саналд тулгуурлав.



Энэхүү семинар нь Улаанбаатар хот болон орон нутгийн ЕБС-д ажиллаж буй япон хэлний багш нар нэгэн дор цугларч, хамтдаа суралцаж, харилцаа холбоогоо өргөтгөх чухал боломж юм. Тиймээс Япон хэлний боловсролын симпозиумтай эн зэрэгцэхүйц Монгол дахь япон хэлний боловсролын салшгүй нэгэн хэсэг болж байна. Сүүлийн жилүүдэд Монголын Япон хэлний багш нарын холбооноос орон нутгийн багш нарын оролцоог хангахад дэмжлэг үзүүлэх болсноор Монгол-Японы төв хамтын ажиллагааны цар хүрээгээ улам тэлж байна.

С. “Иродори: Хэрэглээний япон хэл” сурах бичгийн заах арга зүйн семинар

Энэхүү семинар нь Япон улсад ажиллаж амьдрахад шаардлагатай япон хэл сурахад зориулагдсан сурах бичиг болох "Иродори: Хэрэглээний япон хэл" сурах бичгийн заах арга зүйг заахын зэрэгцээ JFT-Basic шалгалтыг таниулах зэргээр Япон улсад ажиллаж амьдрах боломжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах зорилготой юм. Семинарыг олон жилийн турш сайжруулсны үр дүнд шаардлагатай мэдээллийг үр ашигтай хүргэхийн тулд 5 өдрийн хөтөлбөр боловсруулан зохион байгуулж байна. Тус семинарыг 2024 он хүртэл жилд 3 удаа зохион байгуулж байсан ч 2025 онд 2 удаа буюу 1 ба 9 сард зохион байгуулав. 9 сарын семинарт Монгол-Японы төвийн багшийн заадаг загвар хичээлийн агуулгыг хялбаршуулж, суралцагч төвтэй заах арга барилд тулгуурлан явуулснаар хичээлийн үйл явцыг ойлгоход хялбар болгов. Түүнчлэн загвар хичээл заах явцыг ажиглахад ашиглах “Заах арга зүйн дараалал шалгах хуудас”-ыг нэвтрүүлснээр анх удаа тус сурах бичгийн онцлогийг суралцагчдад сайн ойлгуулж чадлаа.

Монгол улсад япон хэлний заах арга зүйн сургалт ховор бөгөөд дээрх 3 сургалтад сонирхсон хүн бүр хамрагдах боломжтой гэдгээрээ онцлог юм. Эдгээр япон хэлний заах арга зүйн сургалт, семинаруудаар дамжуулан Монголын япон хэлний багш нарыг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьж байна.



Зураг 32. “Иродори: Хэрэглээний сурах бичгийн заах арга зүй”-н семинар сургалт



Зураг 33. “Япон хэлний заах арга зүйн сургалт”



Зураг 34. “ЕБС-ийн багш нарт зориулсан заах аргын семинар” хэлний сургалт”

2) Монгол-Япон хоёр орны найрамдалт харилцаа, эрхэм түншлэлийг билэгдэн зохион байгуулсан “Япон хэлээр бяцхан ном бүтээцгээе-2025” уралдаан

2025 он бол Япон Улсын Цог Жавхланта Эзэн Хаан, Эрхэм дээд Хатан нар Монгол улсад төрийн айлчлал хийхийн зэрэгцээ, Монгол улсад япон хэлний боловсрол үүсэж хөгжсөний 50 жилийн ой тохиосон онцгой жил байлаа. Энэхүү түүхэн ойг тохиолдуулан Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв, Монголын япон хэлний багш нарын холбоо, Япон сан хамтран “Япон хэлээр бяцхан ном бүтээцгээе-2025” уралдааныг анх удаа амжилттай зохион байгууллаа. Тус уралдаан нь Монгол дахь япон хэл сонирхон суралцагчдын хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх, шилдэг бүтээлүүдийг олон нийтэд түгээн сурталчлах замаар Монголын япон хэлний боловсролын хөгжилд хувь нэмэр оруулах, Монголын нөхцөлд тохирсон япон хэлний сурах бичиг, сургалтын материалын хүрэлцээг нэмэгдүүлэх зорилготой байлаа. Мөн япон хэл суралцагчдыг хэлний мэдлэгээ бүтээлчээр ашиглаж, япон хэлээр өөрийн бодол санаа, өв соёл, үнэт зүйлсийг илэрхийлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэж байв.

Уралдаанд ЕБС-ийн сурагчид, их дээд сургуулийн оюутнууд, япон хэлний багш нар зэрэг өргөн хүрээний оролцогчид идэвхтэй хамрагдаж, Монголын ахуй амьдрал, байгаль орчин, гэр бүл, суралцахуйн үнэ цэнийг тусгасан олон гайхалтай бүтээлийг ирүүлснээс доорх бүтээлүүд шалгарсан юм. Үүнд:

Хувь хүний ангилал:



Зураг 35. Монгол-Японы төвийн номын сангийн ном танилцуулах булан



1-р байр: 「私の好きな科目」 Өвөрхангай аймгийн Мэргэд сургуулийн сурагч Д.Марал

2-р байр: 「モンゴルのゲル」 Өвөрхангай аймгийн Мэргэд сургуулийн сурагч

3.Энхдэлгэр

3-р байр: 「子どものころの思い出」 Дөл Констракшн ХХК-ийн япон хэлний багш

М.Чандалдулам

Тусгай байр: 「どうぶつえん」 Монголын Үндэсний Их Сургуулийн япон хэлний багш

Б.Халиунаа



Зураг 36. Хувь хүний ангиллын шагналт байранд шалгарсан оролцогчид



Зураг 37. Хувь хүний ангиллын 1-р байранд шалгарсан бүтээл

Багийн ангилал:

1-р байр: 「フェルトのキツネ」 МУИС-ийн Хууль зүйн сургууль, Нагоягийн их сургуулийн Японы эрх зүйн боловсрол, судалгааны төвийн оюутнуудын “星” баг

2-р байр: 「夜に赤ちゃんを出かけるとき」 Өвөрхангай аймгийн Мэргэд сургуулийн сурагчдын “メルゲド学校-5” баг

3-р байр: 「みんなが探している物」 Тояма Их Сургуулийн оюутнуудын “めぐみ” баг

Тусгай байр: 「遊牧民の一日」 Өвөрхангай аймгийн Мэргэд сургуулийн сурагчдын “メルゲド学校-1” баг



Зураг 38. Багийн ангиллын шагналт байранд шалгарсан оролцогчид



Зураг 39. Багийн ангиллын 1-р байранд шалгарсан бүтээл



Уралдааны шилдэг бүтээлүүдийг эмхэтгэн хэвлэж, дотоод гадаадын япон хэлний боловсролын байгууллагуудад бэлэглэхийн зэрэгцээ цахим орчинд хэн бүхэнд нээлттэйгээр байршуулсан болно.

Тус төв нь цаашид ч япон хэлний боловсрол, соёлоор дамжуулан хоёр орны найрамдалт харилцааг бэхжүүлж, харилцан ойлголцлыг гүнзгийрүүлэх үйл ажиллагааг тууштай үргэлжлүүлэх болно.

Оролцогч нэг бүрийн оюун ухаан, сэтгэл зүрхээ шингээн бүтээсэн эдгээр гайхамшигт бүтээлүүд нь Монголын төдийгүй дэлхийн япон хэл суралцагчдын гарт хүрч, япон хэлээр унших урам зоригийг төрүүлэн, улам бүр шамдан суралцах хүсэл тэмүүллийг бадраана хэмээн итгэж байна.

Уралдааны шилдэг бүтээлүүдийг цахимаар унших линк:

<https://padlet.com/mongoljapancenter/2025-8e2o0hm1m8svrfuh>

3) Монгол–Японы төвд хэрэгжиж буй Япон улсад ажиллаж, сурахын өмнөх хэлний бэлтгэл сургалтын хэрэгжилт ба үр дүн

~JICA-ийн дадлага хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалтын жишээгээр ~

Япон хэлний сургалтын тасаг нь өнөөг хүртэл гадны байгууллагын захиалгаар Япон улсад ажиллаж, сурахын өмнөх хэлний бэлтгэл сургалтуудыг төлөвлөн, амжилттай хэрэгжүүлж ирсэн билээ. Энэхүү нийтлэлээр 2025 онд явуулсан “JICA-ийн дадлага хөтөлбөрт хамрагдах оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалт”-ыг жишээ болгон хэрэгжилт ба үр дүнг танилцуулъя.

Манай төв нь 2025 онд JICA-ийн “Монгол улсад практик сургалтаар инженер, технологийн боловсон хүчнийг бэлтгэхтэй холбоотой мэдээлэл цуглуулах, баталгаажуулах судалгаа”-ны хүрээнд Япон улсад дадлага хийх хүсэлтэй оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалтыг Asia Seed байгууллагаас гэрээлэн авч, зун, өвлийн хоёр ээлжийн сургалтыг зохион байгууллаа.

- Зуны ээлж: 2024 оны 11 сарын 9-нөөс 2025 оны 5 сарын 31 хүртэл, нийт 48 удаагийн 150 цагийн сургалтыг явуулж, 28 оюутан хамрагдсан.
- Өвлийн ээлж: 2025 оны 6 сарын 17-ноос 11 сарын 16 хүртэл, нийт 47 удаагийн 164 цагийн сургалтыг явуулж, 18 оюутан хамрагдсан.



Энэхүү 6 сар үргэлжилсэн урт хугацааны сургалт нь оюутнууд хичээл, сургуулийнхаа хажуугаар хамрагдаж болохуйц танхим болон цахим хэлбэрийг хослуулан явуулсан гэдгээрээ онцлог юм.

Сургалтын гол зорилго нь Япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT)-ийн N3 түвшний мэдлэгийг эзэмшүүлэхийн зэрэгцээ Японд дадлага хийхэд шаардлагатай практик япон хэлний чадварыг хөгжүүлэх байв. Иймд үндсэн сурах бичиг болох “Марүгото япон хэл ба соёл” (анхан дунд шат A2/B1, дунд шат-B1)-ыг ашиглан хэлний олон талт чадварыг хөгжүүлэхийн хамт, N3 түвшний шалгалтад бэлтгэсэн юм. Мөн ажлын ур чадварыг хөгжүүлэх зорилгоор багийн илтгэл тайлан, дадлага хөтөлбөрийн анкет бөглөх зааварчилгаа, компанийн ярилцлагад бэлтгэх заавар зөвлөгөө ба практик дасгал ажил, МОЈС дээрх нэг өдрийн ажлын байрны дадлага зэрэг практик үйл ажиллагааг сургалтын хөтөлбөрт багтаасан.



Зураг 40. Япон улсад ажиллаж, сурахын өмнөх хэлний бэлтгэл сургалт



Зураг 41. Япон улсад ажиллаж, сурахын өмнөх хэлний бэлтгэл сургалт

Урт хугацааны сургалт зохион байгуулахад тулгардаг гол асуудлуудын нэг нь суралцагчдын сурах идэвхийг бууруулахгүй байх явдал юм. Тиймээс энэхүү сургалтад суралцагчдын идэвхийг нэмэгдүүлэх арга аргачлалд онцгой анхаарсан ба сургалтын эхэн үед суралцагчдын япон хэлний түвшин ялгаатай байсан тул нийтээр нь N3 түвшинд хүргэх нь амаргүй байв. Энэ асуудлыг тус төвийн япон хэлний сургалтын онцлог давуу тал болох ганцаарчилсан зөвлөгөө, суралцагч бүрийн онцлогт тохирсон уян хатан дэмжлэг, тогтвортой сургалтын зохион байгуулалтын тусламжтайгаар амжилттай давсан юм.

Тухайлбал, зуны ээлжийн төгсөгчид бүгд N3 түвшинд хүрч, японы компаниудтай хийсэн ярилцлагад бүгд амжилттай тэнцэн, Япон улсад дадлага хийх боломжтой болсон. Тус хөтөлбөрт хамрагдсан суралцагчдын япон хэлний мэдлэг, ажилд хандах идэвх, хандлага нь компаниудаас өндөр үнэлгээ авсан билээ. Харин өвлийн ээлжийн оюутнууд



зуны ээлжийн оюутнуудтай харьцуулахад япон хэлний түвшин бага байсан хэдий ч сургалт төгсөх үеэр япон хэлээр төвөггүй харилцах чадвартай болж төгссөн юм. Суралцагчдын идэвхийг нэмэгдүүлэх ажлууд болон суралцагч бүрд тулгарч буй асуудал, нөхцөл байдалд тохирсон заах арга, дэмжлэгийн үр дүнд бүгд N3-тай дүйх хэлний чадвартай болж, бараг бүгд дадлагад хамрагдах эрхээ авсан юм.

Хоёр ээлжийн сургалтын сэтгэл ханамжийн хувь 96% хүрсэн бөгөөд 40 суралцагч Япон дахь дадлага хөтөлбөрт хамрагдаж, сурсан япон хэлний мэдлэгээ идэвхтэйгээр ашигласан нь сайшаалтай байлаа.

Дээрх сургалтаас гадна япон хэлний сургалтын тасаг нь:

- “Асаргаа сувилгааны дадлагажигчид зориулсан япон хэлний сургалт /6 удаа, нийт 97 хүн/”
- “Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт /5 удаа, нийт 70 хүн/”
- “Киото их сургуульд элсэн орохын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт /5 удаа, нийт 5 хүн/”

гэх мэт зорилго, түвшний ялгаатай олон сургалтуудыг амжилттай зохион байгуулж ирлээ.

Эдгээр сургалтуудыг хэрэгжүүлэх явцад хуримтлуулсан тогтвортой удирдлагын тогтолцоо, туршлагатай багш нарын заах арга нь суралцагчид болон захиалагч байгууллагуудын аль алинаас өндөр үнэлгээ авч ирсэн. Бид цаашид ч захиалагч байгууллагуудын хэрэгцээнд нийцсэн сургалтын төлөвлөгөө, найдвартай зохион байгуулалт, баталгаатай үр дүнд хүргэхийн төлөө ажиллах болно.



Зураг 42. Япон улсад ажиллаж, сурахын өмнөх хэлний бэлтгэл сургалт

Дашрамд дурдахад Японд ажиллаж, сурахын өмнөх япон хэлний бэлтгэл сургалт зохион байгуулахаар төлөвлөж буй байгууллага, хувь хүний хүсэлтийг хүлээн авахад бэлэн байна.



4) Биечлэн танилцаж суралцах япон соёлын танилцуулах хичээл

Монгол-Японы төв нь япон хэлний сургалтын хүрээнд япон соёлтой танилцах хичээлүүдийг тогтмол зохион байгуулсаар ирсэн. Харин 2024 оноос эхлэн зөвхөн төвийн суралцагчдаар хязгаарлалгүй, япон хэл, соёлыг сонирхож буй хэн бүхэнд нээлттэй хичээлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн билээ.

2025 онд 4 төрлийн соёлын танилцуулах хичээлийг зохион байгуулж, 180 орчим хүн хамрагдсан байна. Үүнд: 3 сард Японы “Бийрэн бичлэг”-ийн танилцуулах хичээл, 5 сард Японы чимхлүүр гар урлалаас сэдэвлэсэн “Гелэн лаа урлацгаая” танилцуулах хичээл, 8 сард “Омамори” буюу “хамгаалагч сахиус” сэдэвт соёлын танилцуулах хичээл, 11 сард “Монгол уран бичлэг” тусгай сургалтыг тус тус амжилттай зохион байгууллаа.

“Бийрэн бичлэг”-ийн хичээлийн үеэр бид японы бичиг үсгийн түүх, соёлын талаар танилцуулахын сацуу хамтдаа бийр бэх ашиглаж бичихийн ач тусын талаар чөлөөтэй ярилцах цагийг мөн гаргав. Тус өдөр хүрэлцэн ирсэн оролцогчдын “Япон үсгээр бичиж мэдэхгүй ч хүссэн үгээ ханз үсгээр бичиж чадсандаа баяртай байна” гэх талархлын үгсээс бид маш их урам зориг, эрч хүчийг авч ээлжит “Гелэн лаа урлацгаая” сэдэвт тусгай хичээлийг явуулав.

Энэ өдрийн хичээлд бага дунд ангийн бяцхан дүү нар маань аав, ээж, ах эгч нарын хамт хүрэлцэн ирж идэвхтэй оролцов. Жаахан гэлтгүй японы юмхнаар юм хийх соёлын талаар танилцуулах үед анхааралтай сонсож, аюулгүйн зааварчилгаагаа маш сайн анхааран лаагаа урлаж байсан нь үнэхээр бахархууштай.

Бид байгальд ээлтэй байдлыг чухалчлан тараг, жимсний шүүс зэрэг хэрэглээний зүйлээс өдөр тутамд гардаг шилэн хог хаягдлыг лаа хийх гол материалаа болгон дахин ашигласан юм.



Зураг 43. “Омамори хамгаалагч сахиус хийцгээ” соёлын хичээл



Зураг 44. “Гелэн лаа урлацгаая” өдөрлөг



Түүнчлэн 8 сард “Япон Фестиваль Монголд-2025” өдөрлөгийн ивээн тэтгэгч байгууллага болох Мобиком корпорацийн хүсэлтээр японы “Омамори” буюу “хамгаалагч сахиус” сэдэвт соёлын хичээлийг зохион байгуулсан юм. Өдөрлөгийн үеэр Мобиком компани асраар зочилсон оролцогчдод хамгаалагч сахиус хийх арга барилаас эхлэн түүний утга учир, бэлгэдлийн талаар танилцуулж, хамтдаа хүсэл мөрөөдөл биелүүлэгч “омамори” урласан билээ.

Мөн түүнчлэн 11 сард Их эзэн Чингис хааны мэндэлсэн “Монгол бахархлын өдөр”-т зориулан “Монгол уран бичлэг” тусгай сургалтыг зохион байгуулав.

Өнөөдрийг хүртэл бид япон хэл соёлоос танилцуулах сургалт, хичээлүүдийг түлхүү зохион байгуулж ирсэн. Энэ удаа энэхүү тэмдэглэлт өдрийг тохиолдуулан босоо монгол бичгийн өв соёлоо сурталчлан таниулах хичээлийг зохион байгуулсан нь бас нэгэн онцлох үйл явдал боллоо.

Тус хичээлийг “Бичиг соёл” төвийн багш, каллиграфич Э.Анхбаяр урилгаар хүрэлцэн ирж удирдан явуулсан бөгөөд Монгол уран бичлэгийн үүсэл гарал болоод бичих арга барилыг тайлбарлаж, бичихийг хүссэн үгээ уран сайхан бичихэд чиглүүлэн ажилласан юм.

Дашрамд дурдахад, энэ жил ч бас бидний үйл ажиллагааг дэмжиж хамтран ажилласан байгууллага, хувь хүн, хүрэлцэн ирсэн оролцогч та бүхэндээ гүн талархал илэрхийлье. Дээрх өдөрлөгүүдээр дамжуулан Монгол, Япон хоёр орны иргэд харилцан сонирхолтой яриа өрнүүлж, өөр өөр соёл, орчинтой танилцангаа, найз нөхөд, гэр бүлийн хамтаар дурсамж дүүрэн, мартагдашгүй нандин мөчийг өнгөрүүлж чадсан болов уу хэмээн найдаж байна.



Зураг 45. Японы уламжлалт соёл “Бийрэн бичиг” танилцуулах хичээл

Зураг 46. “Монгол уран бичлэг” тусгай сургалт



Монгол-Японы төв нь соёлоор дамжуулан нэгнээ харилцан хүндэтгэх арга ухаанд суралцах “Харилцан ойлголцлын төлөөх” сургалт үйл ажиллагааг явуулж ирсэн билээ. Цаашид ч мөн энэ зорилгынхоо хүрээнд япон, монгол соёлыг сурталчлан таниулах тусгай хичээлүүдийг нээлттэйгээр зохион байгуулахаар төлөвлөж байгаа тул та бүхнийг хүрэлцэн ирэхийг урьж байна.

5) Гэрээт сургалт, үйл ажиллагааны талаар

~ “Тусгай ур чадварын тогтолцоо” гэрээт ажлын хүрээнд ~

Тус төв нь Япон сантай байгуулсан гэрээний дагуу 2019 оноос эхлэн “Тусгай ур чадвартай ажилтан бэлтгэх тогтолцоо”-той холбоотой Монгол дахь япон хэлний боловсролыг дэмжин ажиллаж ирлээ. Гэрээт ажлын хэрэгжилтийн хүрээнд дараах 3 гол чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

1. Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (JFT-Basic)-тай хамаарах ажил
2. Япон хэлний багш нарыг дэмжих үйл ажиллагаа
3. Япон хэлний сургалтын төв болон Япон улс руу ажилтан илгээгч байгууллагад хандсан судалгаа, зөвлөгөө

Япон сангийн япон хэлний суурь мэдлэгийн шалгалт (JFT-Basic)-тай хамаарах ажил

Нэн тэргүүнд JFT-Basic шалгалтыг олон нийтэд таниулж, шалгалтад хамрагдах болон улмаар тэнцсэн хүмүүсийн тоог нэмэгдүүлэхийн тулд JFT-Basic шалгалтын хуваарийг тогтмол зарлах зэргээр тус шалгалттай холбоотой мэдээллийг цаг тухайд нь хүргэж ажиллалаа. Мөн JFT-Basic шалгалтын удирдамж семинарыг 1 удаа зохион байгуулж 24 хүнд шалгалтын талаарх ерөнхий ойлголтыг өгч, шалгалтад бүртгүүлэх болон бэлдэх аргачлалаас танилцуулсан юм. Түүнчлэн үйл ажиллагааны хүрээнд “Иродори япон хэлний онлайн курс”-ын танилцуулах хичээлийг 4 удаа зохион байгуулж, 83 оролцогчид онлайн сургалтын платформд бүртгэл үүсгэн, компьютер ашиглан бодитоор даалгавар гүйцэтгэх дасгал ажил туршиж хийх сургалтад хамрагдав.

Япон хэлний багш нарыг дэмжих үйл ажиллагаа

Япон хэлний багш нарыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд “Иродори” сурах бичиг болон япон соёл, зан заншилтай холбоотой заах арга зүйг дэлгэрүүлэх, заах аргын туршлага хуваалцах зорилготой семинарыг зохион байгуулж байна. Үүнд:



1) “Иродори сурах бичгийн заах арга зүйн семинар”-ыг 01 сар болон 09 сард 2 удаа зохион байгуулж, нийт 34 хүнийг “Иродори” сурах бичгийн заах арга зүйн үндсэн ойлголтыг өгч, оролцогчдод загвар хичээлээр дамжуулан сургалтад хамрууллаа.

2) Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар (GOLWS)-тай хамтран ШУТИС-ийн Англи хэлний академи, Монгол Коосэн технологийн коллеж, GTN MONGOLIA ХХК-тай хамтран "Тодорхой ур чадвартай ажилтан тогтолцооны талаарх мэдээлэл солилцох уулзалт"-ыг 03 сард зохион байгуулж, 74 хүнд тусгай ур чадвартай ажилтны хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал, шалгалт, журмын талаарх мэдээлэл хүргэв.

3) Япон сан болон Монгол дахь Японы Элчин сайдын яамтай хамтран япон хэлний сургуулиуд болон илгээгч байгууллагуудад зориулсан "Япон сангийн төсөл хөтөлбөрийг танилцуулах семинар"-ыг 11 сард зохион байгуулж, 80 оролцогчдод бүртгэлийн талаарх мэдээлэл, анхаарах зүйлсийн талаар танилцуулав.

3. Япон хэлний сургалтын төв болон Япон улс руу ажилтан илгээгч байгууллагад хандсан судалгаа, зөвлөгөө

Мөн япон хэлний боловсролын байгууллагуудын бүртгэл жагсаалтыг шинэчлэхийн сацуу бүртгэлтэй байгууллагууддаа хандан “тусгай ур чадварын тогтолцоо”-той холбоо хамаарал бүхий үйл ажиллагаа болон япон хэлний боловсролын чиглэлийн үйл ажиллагаа, Япон сангийн төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг тасралтгүй хүргэж ажиллалаа. Улмаар 2 байгууллагад хандан ганцаарчилсан зөвлөгөөг хүргэлээ.

Түүнчлэн, 10 сард Дархан хотын япон хэлний сургалтын байгууллагуудын үйл ажиллагаатай танилцах, хамтран ажиллах, япон хэлний боловсролыг дэмжих зорилгоор тус төвийн багш нар томилолтоор ажилласан ба Дархан хотын япон хэлний сургалтын 3 байгууллагатай танилцаж, мэдээлэл зөвлөгөө хүргэж ажиллав. Мөн Дархан хот болон ойролцоох хотуудын япон хэлний 15 багшид зориулан “Иродори сурах бичгийн заах арга зүйн семинар”-ыг зохион байгууллаа. Мөн, япон хэл соёлыг танилцуулах, мэдээлэл хүргэх зорилгоор зохион байгуулсан “Japan Discovery Day” арга хэмжээний хүрээнд тус арга хэмжээнд оролцсон 150 орчим хүнд JFT-Basic шалгалт болон “Иродори япон хэлний онлайн курс”-ын талаар мэдээллийн хүргэж танилцууллаа.



“Монгол дахь JDS хөтөлбөрийн оюутнуудад зориулсан япон хэлний анхан шатны бэлтгэл сургалт”

Тус сургалтыг 2021 оноос эхлэн жил бүр гэрээгээр хүлээн авч зохион байгуулж байгаа бөгөөд 2025 онд 5 дахь удаагаа амжилттай зохион байгууллаа. Энэ удаад 04 сарын 14-ны өдрөөс 06 сарын 27-ны өдөр хүртэлх 2 сар хагасын хугацаанд нийт 32 удаагийн 65 цагийн эрчимжүүлсэн хөтөлбөрөөр зохион байгуулав. Суралцагчдын хувьд “Хүний нөөцийг хөгжүүлэх JDS тэтгэлэгт хөтөлбөр”-т тэнцэж, Япон улсын их сургуульд магистрын зэрэг горилохоор суралцах 13 хүн байв. Энэ жил ч өмнөх жилийн нэгэн адил “Иродори хэрэглээний япон хэл” /суурь шат А1 түвшин/ сурах бичгийг ашиглан зохион байгуулсан бөгөөд сурах бичгийн хэрэгцээт сэдвийг сонгон авч, хөтөлбөрийг боловсрууллаа.

Сургалтын сургалтын төгсгөлд “Япон хэлээр ярилцацгаая” арга хэмжээг сайн дурын япон хүмүүстэй хамтран зохион байгуулсан юм.

Суралцагчид бүгд сургалтаа амжилттай төгсөж, 2025 оны зун Япон улс руу эрдмийн аянд мордсон билээ.

“JICA-ийн дадлага хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалт”

Энэхүү сургалт нь Японы засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг JICA олон улсын байгууллагын “Монгол улсад практик сургалтаар инженер, технологийн боловсон хүчнийг бэлтгэхтэй холбоотой мэдээлэл цуглуулах, баталгаажуулах судалгаа”-ны хүрээнд Asia Seed байгууллагын хүсэлтээр хэрэгжиж буй төсөл бөгөөд 2025 оны өвлийн ээлжийн сургалт нь 2 дахь ээлжийн сургалт болсон юм.

Энэхүү сургалт нь Япон улсад инженерийн чиглэлээр дадлагад хамрагдах хүсэлтэй их сургууль болон техникийн коллежийн оюутнуудад зориулсан урьдчилсан япон хэлний бэлтгэл сургалт юм.

Дэлгэрэнгүй мэдээллийг онцлох мэдээний булангаас үзнэ үү.



III. СУРАЛЦАГЧДЫН ДУУ ХООЛОЙ

2025 оны намрын “11-13 насны хүүхдэд зориулсан марүгото япон хэлний сургалт” суралцагчийн сэтгэгдэл

Сайн байна уу? Намайг Энхдөлгөөн гэдэг. Япон хэлний сургалт маш гоё, үр дүнтэй байсан. Мэдэхгүй үсэг, үг, дүрэм, харилцан яриа гэх мэт зүйлсийг сурч чадсан нь багш нар болоод хичээж сурсных байх. Сургалтын эхний өдөр найзтай болсон. Зарим нэг зүйлээр адилхан сонирхолтой байсан болоод ч тэр үү их сайн найзууд болсон. Соёлын хичээлийн өдөр ширээ дүүрэн хоол хийхэд зориулсан эд зүйлс байсан. Юу юм бол гэж бодоод сууж байтал багш заавар өгч “Таияки” гэдэг амттан хийж сурсан. Найзууд болоод багш нартаа маш их баярлалаа.



Зураг 47. суралцагч П.Энхдөлгөөн

ありがとうございます。

“11-13 насны хүүхдэд зориулсан марүгото япон хэлний сургалт” Суралцагч П.Энхдөлгөөн

Сайн байцгаана уу.

Би намрын хүүхдийн сургалтад хамрагдсан Энхдөлгөөний ээж байна. Манай хүү хэдэн жилийн өмнөөс япон хэл өөрөө их сонирхож сурч эхэлсэн юм.Тэгээд хүүгийнхээ энэ сонирхлыг нь дэмжээд сургалтын орчин болон хөтөлбөр сайтай сургалтад суулгах юмсан гэж нөхөр бид 2 ярилцдаг байсан юм. Япон хэлний сургалт судалж үзээд Монгол-Японы төвийн япон хэлний сургалтын талаар олж мэдсэн. Ингээд 2025 оны Монгол-Японы төвийн намрын хүүхдийн сургалтад амжиж бүртгүүлэн суралцаж эхэлсэн юмаа. Энэ сургалт надад болон хүүд маань ч их таалагдсан. Хүүхдийг өөрөө бие даан суралцах хөтөлбөр болон номтой. Мөн хичээл орох цаг нь боломжийн бөгөөд багш нар ч маш сонирхолтой заадаг нь хичээлийн группээс харагдсан юм. Маш их талархалтай байна. Бүх мэдээллийг цаг тухайд нь оруулж байсан нь их таатай байсан. Бид цаашид улам илүү хамтдаа хичээж, дараа дараагийн сургалтад суралцахыг зорьж байгаа.Танай хамт олонд улам их амжилтыг хүсье ээ. Баярлалаа.

Суралцагч П.Энхдөлгөөний ээж



“Яриа, дүрэм хосолсон цогц-3 сургалтын талаарх сэтгэгдэл

Намайг Б.Үлэмж гэдэг. Би Япон улсын Хоккайдо арлын Обихиро хотод төрсөн. Гэр бүл маань намайг 10 сартай байхад Монголдоо буцаж ирсэн тул төрсөн газрынхаа талаар илүү ихийг мэдэх хүсэл надад багаасаа байсан.

Энэхүү сонирхол маань улмаар Япон улсад суралцаж, мэргэжил эзэмших мөрөөдөл болон төлөвшиж, түүнийгээ биелүүлэх эхний алхмаа Япон-Монголын төвийн Япон хэлний сургалтыг сонгосноор эхлүүлсэн юм.



Зураг 48. “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт -3 сургалт” Суралцагч Б.Үлэмж

Одоогоор би сургалтын 3-р шатыг амжилттай дүүргээд, 4-р шатанд суралцахаар бэлдэж байна. Япон хэл суралцах явцад би зөвхөн шинэ хэл эзэмшээд зогсохгүй, өөрийгөө илүү нээж, өөртөө итгэх итгэлээ алхам алхмаар нэмэгдүүлж байна.

Анхандаа гадаад хэлээр ярихдаа алдаа гаргахаас айж, өөрийгөө бүрэн илэрхийлж чаддаггүй байсан бол одоо илүү зоригтой болж, сурах хүсэл тэмүүлэл маань улам нэмэгдсэн. Япон хэл сурах нь надад зөвхөн хэлний мэдлэг олгохоос гадна хувь хүний хөгжлийг минь давхар дэмжсэн гэж боддог.

Сургалтын эхнээс суурийг маш зөв, бат бөх тавьж өгсөн нь цаашид сурахад ихээхэн дэм болсон. Суурь ойлголтууд тодорхой, ойлгомжтой байсан учраас дараагийн шатанд ахихад япон хэл сурах улам сонирхолтой болсоор байна. Энэ нь сургалтын чанар болон багш нарын заах арга барилтай шууд холбоотой гэж бодож байна.

Мөн сургалтын шилдэг сурагчдад олгодог тэтгэлэг нь миний япон хэл сурах замыг улам гэрэлтүүлж, илүү зорилготой, тууштай суралцах урам зориг өгсөн. Багш нар маань бүгд найрсаг, хариуцлагатай бөгөөд заах арга барил нь маш сонирхолтой. Сургалтын явц, хичээлийн систем нь маш сайн зохион байгуулалттай, цэгцтэй бөгөөд сурагчийн мэдлэгийг удаан хугацаанд бататган тогтоохоор бүтээгдсэн нь энэ сургалтын хамгийн том давуу тал гэж боддог.

Эдгээр 3 шатны сургалтад суралцаж байх хугацаандаа би Хоккайдо арлын Саппоро хотод очиж үзэж мөрөөдлийн минь эхний хэсэг биелсэн. Тус хот надад маш их таалагдсан бөгөөд ирээдүйд яг энэ л хотод өөрийн дуртай мэргэжлийг эзэмшинэ гэдэгтээ



улам бүр итгэл төгс болсон. Эцэст нь, надад мэдлэг, урам зориг, өөртөө итгэх итгэлийг бэлэглэж, тууштай дэмжиж ирсэн Япон–Монголын төвийн нийт багш, хамт олон, хамт сурсан найз нартаа чин сэтгэлийн талархал илэрхийлье. Та бүхний хичээл зүтгэл, заах арга барил, хамтдаа байсан мөч бүхэн миний ирээдүйн зорилгод хүрэх замд үнэтэй хувь нэмэр оруулж байна.

“Яриа, дүрэм хосолсон цогц-3 сургалт” Суралцагч Б.Үлэмж

Өөрт хялбараар хэлийг сур

Сайн байцгаана уу? Намайг Дөл гэдэг. Би нийслэлийн тэргүүний 53-р сургуулийн 12-р ангид сурдаг. Өдийг хүртэл би япон хэлийг сурч чадах, эсвэл эхэлж чадах эсэхдээ маш их эргэлзэж байлаа. Удалгүй миний эргэлзээ тайлагдаж Монгол-Японы төвийг зорин суралцаж эхэлсэн. Анх догдлол дүүрэн бас бага зэргийн түгшүүртэй, яг л 1-р ангид орж байгаа хүүхэд мэт байж билээ. Өдрөөс өдөрт миний япон хэлний чадвар сайжирч буйг мэдэрч бас энэ газар уусч байгаага мэдэрч байлаа. Энэ төвөөс би хэзээ ч сэтгэгдэл дундуур гарч үзээгүй. Учир нь төвийн үүднээс эхлээд анги хүртэл цэвэр цэмцгэр, орчин халуун дулаан уур амьсгалтай угтдаг болохоор байх. Сургалт ахих тусам бид анги хамт олноороо дээш тэмүүлж бүдэрч унах болгонд багш нарынхаа чадвараас зээлж өөрийн болгон урагш тэмүүлсээр л байсан. Одоо бидний өөрсдийн замаа хөөн урагш алхах ээлж. Япон хэл гэдэг энэ том далайг бид сэлж дуусгаагүй байгаа ч яаж гатлах арга зам, ухааныг сурсан болохоор би одоо алзахгүй мэт санагдаж байна. Эцэст нь хэлэхэд би энэ төвийг хэзээ ч мартахгүй. Үүрд санаж явах болно. Учир нь би халуун дулаан анги хамт олон, үргэлжид тайван инээж явдаг багш нарыгаа санахын тулд байх. Энэ хүртэл би өөрт хамгийн амар хялбар, бас хамгийн жаргалтайгаар япон хэлээ сурч байгаадаа үнэхээр сэтгэл хангалуун байгаа. Миний сэтгэгдлийг уншиж буй Та ч мөн адил хамгийн амар хялбар, хамгийн хөгжилтэй, хамгийн дурсамжтай байдлаар япон хэлийг сурахыг хүсвэл япон төвийг зориорой хэмээн санал болгож байна.



*Зураг 49. “Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5”
Суралцагч Б.Дөл*

“Яриа, дүрэм хосолсон цогц сургалт-5анги” Суралцагч Б.Дөл



ЛИСА-ийн зуны дадлага хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалтын төгсөгч М.Үжин

Анх япон хэл сурахаар шийдсэн минь японы уран зохиолоос эхлэлтэй. Рюүносүкэ Акүтагава, Эдогава Рампо гэх мэтчилэн өөр бусад японы зохиолчид болон тэдний бүтээлүүдэд өөрийн эрхгүй сэтгэл татагдан унших болсон үеэс тухайн улсын соёлыг ч мөн ялгаагүй сонирхох болсноор япон хэл сурах хүсэл эрмэлзэл төрсөн юм.

Монгол-Японы төвийн сургалт зөвхөн хичээл, шалгалт гэх мэтээр нэгэн хэвийн давтамж, хэв маягаар бус соёлын хичээл гэх мэтчилэн суралцагчдадаа аль болох хүсэл тэмүүлэл нэмэгдүүлэх, тухайн орон болон соёлд нь илүү дурлан суралцах боломжийг олгодог нь сэтгэлийн гүнд хүрдэг.

“Марүгото” сургалтын хөтөлбөр ч мөн бүх талаараа тэнцвэртэй мэдлэг олгодог бөгөөд сонирхол татахуйц байж чаддаг. Өмнө нь аливаа зүйлийг сурч мэдэхээр шийдэн эхэлдэг ч тэр бүрд замын голоос цуцаж, хийх хүсэл эрмэлзэл алга болоход өөрөө өөрийгөө хүчлэн хичээдэг байсан үе олон бий. Гэхдээ Монгол-Японы төвийн сургалт нь цуцах, хүсэл эрмэлзэлгүй болох гэх мэт мэдрэмж төрөх төдийд яагаад эхэлснийг минь сануулж, анхаарлыг минь буцаагаад төвлөрүүлж өгдөг “Амьдрал ба соёл”, “Соёлын хичээл” гэх мэт сонирхолтой хичээлүүд байсан учир энэ удаад хийж буй зүйл, олж авч буй мэдлэгээ зөвхөн хоосон цээжлэх биш цаад утга учир, үндэс сууриас нь эхлэн илүү өргөн утгаар ойлгон, бодож сэтгэн, шимтэн суралцаж байна.

Миний хувьд зөвхөн япон хэлийг сураад эсвэл сонирхоод өнгөрөх бус цаашид өөрийн дуртай зохиолчдын бүтээлийг эх хэлээр нь уншиж ойлгох цаашлаад, япон амьдралын хэмнэл, нарийн нандин ойлголтуудыг зөвхөн харж сонсох биш, өөрийн оюун ухаандаа ч мөн амьдруулахын тулд энэ хэлийг сонгон суралцаж буй. Энэ алхамд минь Монгол-Японы төв маш том гүүр, луужин, түлхэц болж өгч буйд талархал илэрхийлье.



Зураг 50. Япон хэлний бэлтгэл сургалтын төгсөгч М.Үжин

ЛИСА-ийн зуны дадлага хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй оюутнуудад зориулсан япон хэлний бэлтгэл сургалтын төгсөгч М.Үжин



IV. НОМЫН САН, ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТАСАГ





I. 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТАЙЛАН

Монгол-Японы төвийн номын сан, хамтын ажиллагааны тасаг нь хоёр орны хамтын ажиллагаа, харилцан ойлголцлыг бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд нээлттэй семинар, япон киноны өдөр, Японд суралцахыг хүссэн оюутан сурагчдад зориулсан “Мэдээллийн яармаг, семинар”, Японд тэмдэглэдэг уламжлалт баяр наадмаар дамжуулан япон соёлыг мэдэж авах “Япон хэл, соёлын танилцуулга хичээл”, ЕБС-иудын япон хэлний багш, сурагчдын хамрагддаг Хакүходо боловсролын сангийн япон хэл сурч буй хүүхдийн боловсролыг дэмжих “Япон хэл, солилцооны хөтөлбөр” зэрэг ажлуудыг тогтмол зохион байгуулахын зэрэгцээ нийтийн номын сангийн үйл ажиллагаа явуулдаг.

Дээр дурдсан үйл ажиллагаануудын талаар та онцлох мэдээ хэсгээс дэлгэрүүлэн уншина уу. Энэ жил арван хурууны бичээчийн сургалт нийт 9 удаа хичээллэлээ.

1) Номын сангийн үйл ажиллагаа

Номын сангийн бүртгэлтэй уншигчдын тоо 2025 оны 12-р сарын байдлаар 30,000 болсон ба 4926 уншигч номын сангийн танхимаар үйлчлүүлжээ.

Номын сангийн фондод япон хэл суралцагчдад зориулсан ном, толь бичиг, Японд суралцах шалгалт, япон хэлний түвшин тогтоох шалгалтад бэлтгэх ном, товхимол, япон, монгол зохиолчдын бүтээл, дэлхийн сонгодог зохиол, комик зэрэг 10,000 гаруй ном материал байна. Түүнээс гадна Японы 100 гаруй их, дээд сургуулийн танилцуулга, холбогдох материалууд номын санд бий. Энэ жил номын сангийн фондоо 158 номоор баяжуулжээ. Монгол, япон хэлээрх ном хандивласан монгол, япон хувь хүн, албан байгууллага, хэвлэлийн газарт гүнээ талархаж байна.

Ном хэвлэлээр үйлчлэхээс гадна бид японы соёлыг түгээн дэлгэрүүлэх үүднээс Японы үндэсний хувцас юката, япон эд хэрэглэлийн зүйлсийн үйлчилгээг мөн үзүүлдэг билээ. Энэ жил 40 орчим хувь хүн, байгууллагуудад 80-аад хувцас, эд хэрэглэлийн үйлчилгээ үзүүлжээ.

Номын сангийн мэдээллийн буланд Японы ЭСЯ-аас хариуцан явуулдаг тэтгэлэгт шалгалт, Япон хэлний багш нарын холбоо, ЖАССО /Японы оюутныг дэмжих байгууллага/-оос явуулдаг хувийн зардлаар Японд суралцах шалгалт, мөн Япон сангийн япон хэлний түвшин тогтоох шалгалттай холбоотой мэдээллийг түгээдэг.



2) Орчуулагч уншигчдын уулзалт

Номд дуртай хүүхэд залуус, хэн бүхэнд зориулан зохион явуулдаг шинээр хэвлэгдсэн японы уран зохиолын номын орчуулагч нартай хийдэг уулзалтыг 4-р сард зохион байгуулав. Энэ удаа бид Итгэл Марал павлишингийн үүсгэн байгуулагч, орчуулагч Д.Маралгоотой тус уулзалтыг хийлээ. Тэднийхээс эрхлэн гаргасан Мори Этогийн "ӨНГӨЛӨГ", Хасэ Сэйшюүгийн "ХҮҮ, НОХОЙ ХОЁР" гэсэн хоёр ч орчуулгын номны талаар ярилцав. Хоёр зохиолчийн намтар, уран бүтээлийн талаар яриа өрнүүлэхээс гадна залууст зориулсан орчуулагчийн сонирхолтой яриаг оролцогчид тун таатай хүлээн авч байлаа. “Өнгөлөг” ном нь өсвөр насны уншигчид болон эцэг эхчүүдэд зориулсан ном гэхэд болно. Тус бүтээл нь Японд төдийгүй олон улсад ч өндрөөр үнэлэгдсэн бүтээл бөгөөд хэвлэгдсэнээсээ хойш нэг сая гаруй хувь борлогджээ. Англи, тайланд, солонгос, вьетнам зэрэг хэлээр орчуулагдан хэвлэгдэж, Япон, Тайландад уг зохиолоор кино хийн олны хүртээл болгожээ. “Хүү, нохой хоёр” зохиолын хувьд Японд 300 гаруй мянган хувь борлуулагдсан 2011 оны 3-р сарын 11-нд болсон аймшигт цунамигийн дараах цаг үеэс сэдэвлэсэн нэгэн нохой өөрийн эзнээ хайх явцдаа олон олон хүмүүсийн амьдралд нөмөр нөөлөг, хань бараа болж буй тухай сонирхолтой роман юм.

3) Нээлттэй семинар

Төв нээгдсэн цагаасаа хойш нээлттэй семинарыг тогтмол зохион байгуулж ирсэн билээ. 2025 онд 85 дахь удаагаа зохиогдсон нээлттэй семинарт энэ удаа “Монгол эсгий эрт, эдүгээ” номын зохиогч, МУ-ын зөвлөх инженер Б.Эрдэнэцэцэг оролцож эсгий, эсгий эдлэлийн технологийн танилцуулга хийлээ. Тус семинарын агуулга, хэрхэн явагдсан талаар сонирхолтой мэдээллийн дэлгэрэнгүйг та “Онцлох мэдээ”-ээс хүлээн авна уу.

4) 16 дахь удаагийн Японд суралцах тухай мэдээллийн яармаг – 2025

Жил бүр тогтмол зохиогддог уламжлалт нэгэн арга хэмжээ бол Японд суралцахыг хүссэн хүмүүст зориулсан “Японд суралцах мэдээллийн яармаг” байдаг. Ноднин жилээс эхлэн жилд хоёр удаа буюу хавар, намар зохион байгуулдаг болсон билээ. Хаврын мэдээллийн яармагийн оролцогч их сургуулиудыг цахимаар хамруулж 1 өдрийн үйл ажиллагаа болсон бол харин намрын мэдээллийн яармагт оролцогч их сургуулиудын бие төлөөлөгч нар Японоос ирж 2 өдрийн турш хэрэгцээт мэдээллээр ханган оролцлоо. Монголд хараахан хүрэлцэн ирж амжаагүй их сургуулиуд холбогдох материалаа ирүүлж оролцдог уламжлал тогтож байна. Тухайн их сургуулиудын танилцуулга брошюр, тараах материалыг яармагийн хоёр өдөр оролцогчдод тараахаас гадна, сургуулийн мэдээлэл нь манай www.edujapan.mn тусгай веб сайтад байршиж байгаа юм. Ийнхүү нийт 13 их



сургуулийн мэдээ мэдээлэл нийтэд хүрлээ. Оролцогч их сургуулиудын явуулсан танилцуулга материалуудыг хүлээн авах танхимд тусгай булан гарган байршуулж, мөн номын сан дахь тараах материалын булангаар дамжуулан тараахын зэрэгцээ үйлчлүүлэгчийг тухайн сургуультай холбож өгөх үйлчилгээг үзүүлдэг. 2026 онд ч мөн адил “Японд суралцах мэдээллийн яармаг” үйл ажиллагаагаа хоёр удаа: хаврынхыг 2026 оны 4-р сард, намрынхыг мөн оны 10-р сард зохион байгуулахаар төлөвлөж байна. Дэлгэрэнгүйг онцлох мэдээнээс хүлээн авна уу.

5) Гэрээгээр гүйцэтгэх ажил

Жил бүр хэрэгждэг Хакүходо боловсролыг дэмжих сангийн “Япон хэл, солилцооны хөтөлбөр” энэ жил ч мөн амжилттай явагдлаа. Энэ удаагийн хөтөлбөрт Шинэ Монгол сургуулийн япон хэлний багш В. Түвшинжаргал шалгаран багшийн дадлага сургалтад хамрагдсанаас гадна, шавь нарын хамт Япон улстай танилцах хөтөлбөрт амжилттай яваад ирлээ. Ийнхүү 15 дахь хөтөлбөр дуусаж, мөн үүнтэй зэрэгцэн 16 дахь удаагийн хөтөлбөр эхэлж энэ удаад Өвөрхангай аймгийн Мэргэд дунд сургуулийн япон хэлний багш Д. Дуламсүрэн шалгаран 2025 оны 11-р сард багшийн дадлага сургалтдаа амжилттай оролцоод ирлээ. 2026 оны 5-р сард сурагчдын хамт танилцах хөтөлбөрт явахаар бэлтгэл ажлаа хангаж байна.

Энэ жил дээрх үндсэн гэрээт ажлаас гадна Киотогийн дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль, Нийгата мужийн захиргаа, Нийгата Эм зүй, Анагаах ухаан, Хэрэглээний шинжлэх ухааны их сургууль, NSG group, Удирдлагын ухааны институт зэрэг хэд хэдэн их сургуультай хамтарсан гэрээт ажлыг амжилттай зохион байгуулав. Түүнчлэн, Японы оюутныг дэмжих байгууллага JASSO болон Франшир компанийн орчуулгын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Шинээр урт хугацааны нэгэн гэрээт ажил хэрэгжихээр эхэлж байгаа нь АСЕАН-ы орнууд болон бусад Азийн орнуудын дунд боловсролын байгууллагууд руу япон хүмүүсийг япон хэлний туслах багшаар илгээн, Япон болон Азийн орнуудын харилцан ойлголцлыг гүнзгийрүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилго бүхий 2024 оноос эхлэн 10 жил үргэлжлэх урт хугацааны төсөл болох “Нихонго партнерс илгээх хөтөлбөр”-ийг Япон сантай хамтран зохион байгуулах ажлыг хийхээр тус тасаг энэ оноос эхлэн бэлтгэл ажилдаа ороод явж байна. Хөтөлбөрийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг онцлох мэдээнээс хүлээн авна уу.



б) Арван хурууны бичээчийн сургалт

2002 оноос тасралтгүй явагдаж ирсэн нэгэн сургалт бол кириллээр арван хуруугаар хурдан бичиж сурдаг сургалт билээ. 7, 12-р сараас бусад бүх сард тогтмол хичээллэдэг, жилд 10 удаа явагддаг сургалт юм. Энэ жил 9 удаа хичээллэлээ. 2025 оноос төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлт кирилл, монгол бичгээр давхар явж эхлэхтэй холбогдуулан бид хичээлийн агуулгадаа монгол бичгээр хэрхэн шивэх талаар нэмэлт цаг оруулан зааж эхэлсэн нь энэ жилийн сургалтын онцлог байлаа.

Хүснэгт-9: Нээлттэй семинар

| № | Сэдэв | Илтгэгч | Он сар өдөр | Хаана | Оролцогчдын тоо |
|-------------|----------------------------|--|-------------|-----------|-----------------|
| 1 | №85. “Эсгийгээр урлацгаая” | МУ-ын зөвлөх инженер, “Монгол эсгий эрт эдүгээ” хэмээх япон хэлээрх номын зохиогч Б. Эрдэнэцэцэг | 2025.11.08 | Их танхим | 11 |
| Нийт | | | | | 11 |

Хүснэгт-10: Гэрээгээр гүйцэтгэх ажил

| № | Үйл ажиллагааны нэр | Он сар өдөр | Оролцогчид | Хаана | Хүний тоо |
|---|--|------------------|--|--------------------|-----------|
| 1 | Хакүходо боловсролын сангийн "Япон хэл, солилцооны хөтөлбөр" гэрээт ажил | 2025.5, 11 | ЕБС-ийн япон хэлний багш | Япон, Токио | 6 |
| 2 | Нийгата мужийн сургууль хоорондын хамтын ажиллагаа | 2025.05.22-11.28 | NSG group, Удирдлагын ухааны институт, Нийгата Эм зүй, Анагаах ухаан, Хэрэглээний шинжлэх ухааны их сургууль, МУИС, ХААИС, Хүмүүнлэгийн ухааны их сургууль, Их Засаг их сургууль, ЕБС 23-р сургууль, Номт Наран сургууль, Хобби сургууль | Улаанбаатар | 22 |
| 3 | Японы оюутныг дэмжих байгууллага ЖАССО-н гарын авлагын орчуулга, хэвлэлт | 2025.9-10 | ЖАССО | Impress Colour LLC | 1 |




| | | | | | |
|-------------|--|---------|--|---------------------------------------|------------|
| 4 | Киотогийн дэвшилтэт шинжлэх ухааны их сургуулийн гэрээт ажил | 2025.10 | Киотогийн дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль | Улаанбаатар дахь сургуулиудаар зочлох | 354 |
| 5 | Нихонго Партнерс илгээх хөтөлбөр | 2025.10 | Япон сан, МЯТ, Боловсролын яам, ЕБС-иуд | Улаанбаатар | 28 |
| Нийт | | | | | 411 |

Хүснэгт-11: Япон сангийн Япон хэл, соёлын танилцуулга хичээл

| № | Үйл ажиллагааны нэр | Он сар өдөр | Оролцогчид | Хаана | Оролцогчдын тоо |
|-------------|---------------------|--------------------------|------------|---------------------|-----------------|
| 1 | Охидын баяр | 2025.03.15 2025.03.22 | Сурагчид | Их танхим, 204, 205 | 48 |
| 2 | Хүүхдийн баяр | 2025.05.10 | Сурагчид | Их танхим | 27 |
| Нийт | | | | | 75 |

Хүснэгт-12: Номын сангийн үйлчлүүлэгчдийн тоо

| Сараар | 2025 | | | | | | | | | | | | Нийт |
|---------------------|------|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-----|-------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | |
| Үйлчлүүлэгчдийн тоо | 128 | 373 | 429 | 600 | 384 | 308 | 225 | 268 | 687 | 693 | 501 | 330 | 4926 |





Хүснэгт-13: Орчуулагч уншигчдын уулзалт

| № | Сэдэв | Илтгэгч | Он сар өдөр | Хаана | Оролцогчдын тоо |
|-------------|---|--|-------------|-----------|-----------------|
| 1 | Мори Это "Өнгөлөг", Хасэ Сэйшюү "Хүү, нохой хоёр" | "Итгэл Марал паблишин"-ийн үүсгэн байгуулагч, орчуулагч Д.Маралгоо | 2025.4.2 | Их танхим | 14 |
| Нийт | | | | | 14 |

Хүснэгт-14: Япон соёлын танилцуулга

| № | Үйл ажиллагааны нэр | Он сар өдөр | Хаана | Оролцогчдын тоо |
|-------------|--|-------------|-----------|-----------------|
| 1 | Японы соёлын танилцуулга үйл ажиллагаа "Цайны ёслол", "Япон орныг хэн сайн мэдэх вэ?" асуулт хариултын тэмцээн | 2025.09.06 | Их танхим | 23 |
| Нийт | | | | 23 |

Хүснэгт-15: Соёлын арга хэмжээ

/Япон хэл, соёлын хамтын ажиллагааны хэлтсийн хамтарсан үйл ажиллагаа/

| No | Үйл ажиллагааны нэр | Илтгэгч | Он сар өдөр | Хаана | Оролцогчдын тоо |
|-------------|-----------------------------------|---------------------------------------|-------------|-----------|-----------------|
| 1 | Монгол уран бичлэг тусгай сургалт | "Бичиг соёл" төвийн багш, каллиграфич | 2025.11.25 | Их танхим | 11 |
| Нийт | | | | | 11 |

Хүснэгт-16: Компьютерын сургалт

| № | Сургалтын нэр | Хугацаа | Давтамж | Агуулга | Багшийн нэр | Оролцогчдын тоо |
|-------------|--|-----------------|---------|--|-------------|-----------------|
| 1 | Арван хурууны бичээчийн сургалт /танхим болон цахим/ | 2025.01-2025.12 | 9 удаа | Компьютерын гарын үндсэн байрлалыг эзэмшиж, програм ашиглан арван хуруугаар зөв, хурдан бичиж сурна. | Т.Болормаа | 67 |
| Нийт | | | | | | 67 |



II. ОНЦЛОХ МЭДЭЭ

1) “Японд суралцах тухай мэдээллийн яармаг-2025” үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдлаа.

Монголынхоо ирээдүй хойч болсон оюутан залуустаа дэлхийн жишигт нийцсэн боловсрол эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор жил бүрийн 4-р сард “Хаврын мэдээллийн яармаг”, 10-р сард “Японд суралцах тухай мэдээллийн яармаг” зэрэг үйл ажиллагаануудаа тус тус амжилттай зохион байгууллаа. Дээрх 2 үйл ажиллагаанд Японд суралцах хүсэлтэй 1,500 гаруй хүүхэд залуус хүрэлцэн ирж өөрт хэрэгтэй мэдээллээ авлаа.

Хаврын мэдээллийн яармаг-2025

Байршил: Монгол-Японы төв

Хугацаа: 2025 оны 4-р сарын 19-ний (Бя) /Танхим, цахим хосолсон хэлбэрээр/

Оролцогч их сургуулиуд: Каназава их сургууль, Киото дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль, Фүкүи их сургууль, Риккёо их сургууль

Энэ жилийн хаврын мэдээллийн яармаг нь ЕБС-ийн ахлах ангийн сурагч, оюутнуудад



Зураг 51. “Монголын анимейшний холбоо”- ТББ-ын гүйцэтгэх захирал Э.Тамир

Японд суралцахад нь чиглэл өгөх, хувийн бэлтгэлээ хангахад нь дэмжлэг үзүүлэх зорилгоор зохион байгуулагдсан бөгөөд хөтөлбөртөө Японд суралцах талаар ерөнхий танилцуулга, Япон улсын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр, Япон улсад анимейшн чиглэлээр хэрхэн суралцах

талаарх илтгэл яриа зэрэг үйл ажиллагаанууд багтааснаараа онцлогтой байв. Мөн танхимын үйл ажиллагаагаа цахимаар шууд дамжуулж орон нутгийн хүүхэд залууст мэдээлэл авах тэгш боломжоор хангахыг зорьсон.



Хүснэгт-17: “Хаврын мэдээллийн яармаг”-ийн оролцогч их сургуулиуд

| | | | |
|---|---|---|---|
|  <p>Каназава их сургууль</p> |  <p>Киото дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль</p> |  <p>Фүкүи их сургууль</p> |  <p>Риккёо их сургууль</p> |
|---|---|---|---|

Японд суралцах тухай мэдээллийн яармаг-2025

Байршил: Монгол-Японы төв

Хугацаа: 2025 оны 10-р сарын 4 (Бя), 5 (Ня)-ний өдрүүдэд /Танхим/

Оролцогч их сургуулиуд: Кэйо их сургууль, Киото дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль, Олон улсын их сургууль, Токио олон улсын их сургууль, Хёго мужийн их сургууль, Чюю гакүин их сургууль

Материалаар оролцогч сургуулиуд: Мүсашино их сургууль, Нагоя худалдаа, бизнесийн их сургууль, Ямагата их сургууль

2025 оны намрын мэдээллийн яармагийн хөтөлбөртөө Япон улсын засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөрийн танилцуулга, Японд суралцах талаар ерөнхий танилцуулга (JASSO), Япон хэлний түвшин тогтоох шалгалт (JLPT) болон Япон улсад хувийн зардлаар суралцах шалгалт (EJU)-ын танилцуулга, EJU-ын математикийн шалгалтад хэрхэн бэлдэх вэ семинар хичээл (Жото Эдүкэшин Центр), Япон



Зураг 52. Асами Ёшинари Жото Эдүкэшин Центр

улсад тэтгэлгээр суралцаж ирсэн оюутны яриа, мэдээллийн яармагт оролцож буй сургуулиудын танилцуулга болон сургууль тус бүрийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх булан зэргийг багтааж зорьж ирсэн оюутан залуустаа цогц мэдээлэл авах боломжийг хангаж өгснөөрөө онцлогтой байлаа. Оюутан залуус маань өөрсдийн суралцах чиглэлээр элсэлт авч буй сургуулийн ганцаарчилсан зөвлөгөө өгөх буланд очиж тэтгэлэгт



хөтөлбөрөөс гадна өөрт хэрэгтэй мэдээллүүдээ олж авч чадсан гэж найдаж байна. Ирэх жил ч гэсэн оюутан залуусын суралцахыг хүсдэг мэргэжлээр элсэлт авдаг их дээд сургууль, байгууллагын төлөөлөгчид “Японд суралцах мэдээллийн яармаг”-т оролцож оюутан залууст хэрэгцээтэй мэдээлэл өгнө гэдэгт итгэж байна.

Ерөнхий зохион байгуулагч: Монгол-Японы хүний нөөцийн хөгжлийн төв

Хамтран зохион байгуулагч: Монгол Улсын Их Сургууль

Японд сургууль төгсөгчдийн “JUGAMO” нийгэмлэг

Дэмжигч байгууллага: Монгол дахь Япон улсын элчин сайдын яам

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага (JICA)

Японы оюутныг дэмжих байгууллага (JASSO)

Монголын Япон хэлний багш нарын холбоо

Хүснэгт-18: “Японд суралцах тухай мэдээллийн яармаг-2025”-ын оролцогч их сургуулиуд

| | | | | |
|---|---|---|--|--|
|  <p>慶應義塾大学 Keio University Tokyo, Japan</p> <p><i>Кэйо их сургууль</i></p> |  <p>KUAS KYOTO UNIVERSITY of ADVANCED SCIENCE</p> <p><i>Киото дэвшилтэт шинжлэх ухааны их сургууль</i></p> | <p>世界の幸せをカタチにする。 世界の幸せをカタチにする。</p>  <p>Musashino University 武蔵野大学</p> <p><i>Мүсашино их сургууль</i></p> |  <p>NUCB Undergraduate School</p> <p><i>Нагоя худалдаа, бизнесийн их сургууль</i></p> |  <p>IUJ INTERNATIONAL UNIVERSITY OF JAPAN Where the World Cooperates</p> <p><i>Олон улсын их сургууль</i></p> |
|  <p>Токио олон улсын их сургууль</p> |  <p><i>Хёого мужийн их сургууль</i></p> |  <p><i>Чюүо Гакүин их сургууль</i></p> |  <p>Yamagata University</p> <p><i>Ямагата их сургууль</i></p> | |

2) Монголд анх удаа “Японы ахлах сургуулиудын мэдээллийн яармаг” зохион байгуулагдлаа

Монгол-Японы төв Мэйкэй ахлах сургуультай хамтран, Монгол дахь Япон улсын элчин сайдын яам болон ЖАЙКА-ийн дэмжлэгтэйгээр Монголд анх удаа “Японы ахлах сургуулиудын мэдээллийн яармаг”-ийг 2025 оны тавдугаар сарын 17, 18 болон аравдугаар сарын 25, 26-нд хоёр удаа зохион байгууллаа.



Японы ахлах сургуульд суралцах сонирхолтой хүүхэд залуучуудад чиглэсэн анхны



Зураг 53. Ганцаарчилсан зөвлөгөөний булан

мэдээллийн яармаг байсан ч 5-р сард 469, 10-р сард 255, жилийн дүнгээр нийт 724 хүн оролцлоо. Энэхүү үр дүн нь Монгол улсад Японы ахлах сургуульд суралцах хүсэл эрмэлзэлтэй хүүхэд залуус их байгааг харуулж байна. Ялангуяа бага насны хүүхдээ дагуулсан эцэг эхчүүдийн оролцоо их байсан бөгөөд энэ нь

ахлах сургуульд хүүхдээ сургах нэг сонголт байгаа гэдгийг мэдэж эртнээс бэлдэж байгаа нь тодорхой харагдлаа.

Монголын боловсролын салбарын мэдээллээс харахад, сургуулийн шатанд ойролцоогоор 9000 хүн япон хэл сурч байгаа нь Японы ахлах сургуульд суралцах далд эрэлт маш өндөр байгааг харуулж байна. Иймээс тус мэдээллийн яармагийг цаашид тогтмол зохион байгуулах нь нийгэмд үзүүлэх хувь нэмрийн хувьд ихээхэн ач холбогдолтой билээ.

Бодит гарсан үр дүнг хуваалцахад, тус мэдээллийн яармагаар дамжуулан хоёр монгол сурагч Японы ахлах сургуульд элсэн суралцаж байгаа бөгөөд, 2026 оны дөрөвдүгээр сараас дахин хоёр сурагч ахлах сургуульд суралцахаар албан ёсоор шийдвэрлэгдээд байна.

Ахлах сургуульд суралцах нь, зөвхөн хэлний мэдлэг болон сурлагын ахиц дэвшлээр хэмжигдэхгүй. Сурагчийн бие даах чадвар болон ирээдүйн карьер хөгжил, улмаар хоёр улсын найрамдлыг бэхжүүлэх “ГҮҮР” болох боловсон хүчнийг бэлтгэхэд шууд хамааралтай билээ.



Зураг 54. Бийрэн бичлэг

Мөн, энэхүү мэдээллийн яармагаар зөвхөн мэдээлэл түгээгээд зогсохгүй, япон бийрэн бичлэг болон анимэ зурах зэрэг япон соёлыг танилцуулах хөтөлбөрүүдийг хамтатган зохион байгуулснаар оролцогчдод “Япон соёлыг өөрийн биеэр мэдэрч ойлгох”



боломжийг олгосон билээ. Ийм олон талт арга хэмжээ зохион байгуулснаар, олон оролцогчдод Япон орныг илүү ойр дотноор мэдрэх нөхцөлийг бүрдүүлж, гадаадад суралцах сэтгэлзүйн бэрхшээлийг бага ч болов бууруулсан гэж үзэж байна.

Цаашид илүү олон сургуулийг хамруулж, Японы ахлах сургуульд суралцах боломжийг илүү бодит сонголт болгох ажлыг улам эрчимжүүлэн ажиллана. Тус мэдээллийн яармагийг тогтмол зохион байгуулж, илүү олон сурагчид Японд суралцахад нь дэмжлэг үзүүлж, хоёр улсын найрамдалт харилцааг улам хөгжүүлэхэд хувь нэмэр оруулахыг зорьж байна.

| № | Сургуулийн нэр | Оролцсон сар | Гол онцлог |
|---|--|--------------|--|
| 1 | Мэйкэй гакүэн ахлах сургууль | 2025.5,10 | IB (DP) хөтөлбөрт нийцсэн, хичээлийг япон болон англиар явуулдаг, олон төрлийн их сургуульд элсэх боломжийг олгодог. |
| 2 | Сэндай икүэй гакүэн ахлах сургууль | 2025.5,10 | IB (DP) хөтөлбөрт нийцсэн, улсын хэмжээнд өрсөлдөхүйц спортын идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. |
| 3 | Бүндай Сүгинами ахлах сургууль | 2025.5 | Япон болон Канадын төгсөлтийн гэрчилгээг авах боломжтой давхар дипломын курстэй. |
| 4 | Ойска Хамамацү олон улсын ахлах сургууль | 2025.10 | Гадаад оюутнууд их тул өдөр тутамдаа олон улсын хүүхдүүдтэй харилцдаг. Олон орны соёлын хичээл болон гадаадад дадлага хийх хөтөлбөртэй. |
| 5 | Мито Кирё ахлах сургууль | 2025.10 | Шүд болон эм судлал, i тусгай ахисан түвшин, их дээд сургуульд элсэн суралцах V сургалт зэрэг олон төрлийн курсээр их дээд сургуульд элсэхэд дэмжлэг үзүүлдэг. |
| 6 | Янагава ахлах сургууль | 2025.10 | Гадаад оюутан (ойролцоогоор 80 хүн) хүлээн авдаг. Япон хэлний курс, их дээд сургуульд элсэхэд дэмжлэг үзүүлдэг. |

3) Япон сангийн “Нихонго партнерс илгээх хөтөлбөр” хэрэгжиж эхэллээ

➤ “Нихонго партнерс”-ийн түүхэн замнал

“Нихонго партнерс” илгээх хөтөлбөр нь 2013 оны 12-р сард болсон АСЕАН-ы тусгай дээд хэмжээний уулзалтын үеэр зарлагдсан Азийн соёлын солилцооны бодлого “Соёлын WA төсөл ~Азийг танин мэдэх~”-ийн гол үйл ажиллагааны нэг болж, 2014 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2023 он хүртэлх нэгдүгээр үе шатанд нийт 3,000 гаруй “Нихонго партнерс”-ийг илгээсэн байдаг. Хоёрдугаар үе шатанд, 2023 оны 12-р сард болсон Япон-АСЕАН найрамдал, хамтын ажиллагааны 50 жилийн ойд зориулсан тусгай дээд хэмжээний уулзалтын үеэр зарлагдсан “Дараагийн үеийн хамтын бүтээлийн түншлэл: Соёлын WA 2.0” хэмээх хүмүүс хоорондын цогц солилцооны хөтөлбөрийн нэг



болгож, 2024 оноос эхлэн 10 жилийн хугацаанд “Нихонго партнерс илгээх хөтөлбөр”-ийг өргөжүүлэн үргэлжлүүлэхээр болсон билээ. Үүний дагуу 2024 оны 9-р

сард болсон Япон-Монголын дээд хэмжээний уулзалтын үеэр, хоёр улсын цаашдын хамтын ажиллагааны гол чиглэлүүдийн нэг болгон, Монгол улсад “Нихонго партнерс” илгээх ажлыг албан ёсоор баталгаажуулсан юм.

➤ “Нихонго партнерс”-ийн түүхэн зам

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь, гол төлөв АСЕАН-ы орнууд болон бусад Азийн орнуудын дунд боловсролын байгууллагууд руу Япон хүмүүсийг япон хэлний туслах

багшаар илгээн, Япон болон Азийн орнуудын харилцан ойлголцлыг гүнзгийрүүлж, хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оршдог. “Нихонго партнерс”-ийн эрхэм зорилго нь тухайн орны япон хэлний сургалтын үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ, танхим болон



Зураг 55 . Богино хугацааны нихонго партнерсуудын япон тоглоом наадгай хамтдаа хөгжилдөж буй нь

танхимаас гадуурх сургалтад дэмжлэг үзүүлэх, соёлын үйл ажиллагаагаар дамжуулан япон хэл, япон соёлын давуу тал, онцлог шинжийг түгээн дэлгэрүүлэх явдал юм. Мөн “Нихонго партнерс”-ын хувьд тухайн орны сурагчид, багш нар болон уугуул иргэдтэй ойртон нөхөрлөснөөр, тус орныхоо талаар илүү ихийг сурч мэдэх ховор бөгөөд үнэ цэнтэй боломжийг олж авна гэдэгт итгэлтэй байна.



Зураг 56. Богино хугацааны нихонго партнерсуудын япон тоглоом наадгай хамтдаа хөгжилдөж буй нь

“Нихонго партнерс” хөтөлбөр нь “Урт хугацаагаар илгээх”, “Богино хугацаагаар илгээх” болон “Их сургуулийн дадлагажигчаар илгээх” гэсэн гурван төрөлтэй байдаг. Хугацааны хувьд, “Урт хугацаагаар илгээх” хөтөлбөрийн хувьд зургаан сараас нэг жил хүртэл байдаг бол,

“Богино хугацаагаар илгээх” хөтөлбөр нэг долоо хоног орчим байдаг. “Их сургуулийн дадлагажигчаар илгээх” хөтөлбөр нь япон хэлний боловсролын байгууллагуудын япон



хэлний сургалтыг дэмжих, тухайн орны иргэдтэй харилцах замаар харилцан ойлголцлыг нэмэгдүүлэх, гүнзгийрүүлэх зорилгоор гол төлөв АСЕАН-ы орнуудын дунд боловсролын байгууллагуудад Японы их дээд сургуулиудад “япон хэлний боловсрол”-оор мэргэжил сонголтоо хийсэн оюутнуудыг илгээдэг.

➤ *Монгол дахь “Нихонго партнерс” хөтөлбөрийн тухай*

Монгол улсад 2025 оны аравдугаар сард “Нихонго партнерс”-ын богино хугацааны хөтөлбөрөөр 8 хүн илгээсэн бөгөөд, 2026 оны аравдугаар сард “Нихонго партнерс”-ын урт хугацааны хөтөлбөрөөр 5 хүн илгээхээр зохицуулалт хийж байна.

4) *Олон нийтэд зориулсан монгол, япон соёлын танилцуулга тусгай сургалт, нээлттэй семинар*

Төв нээгдсэн цагаасаа монголчуудад япон соёлыг, Монголд суугаа япон хүмүүст монгол соёл ахуйг танилцуулах соёлын ажил, семинарыг жил бүр зохион явуулсаар ирсэн билээ. 2025 онд Японы цог жавхлантай эзэн хаан Монгол улсад айлчилсан түүхэн цаг хугацааг тохиолдуулан Япон улсын соёл, уламжлалаас монголчууддаа танилцуулах нь бидний нэгэн хүлээсэн үүрэг хэмээн үзэж цайны ёслолын дэг жаягийн талаар танилцуулсан нэгэн семинарыг хийлээ. Бид соёлын арга хэмжээг зохиохдоо тус салбарын мэргэшсэн багш нарыг урьж оролцуулдаг билээ. Цайны ёслолын багш Б.Түвшинзаяа энэ удаа цайны ёслолын түүх гарал, ёслолын үед ашиглах хэрэгсэл зэргийг биечлэн танилцуулж, дараа нь оролцогчид бие биеэ цайгаар дайлан цайны урлагийн талаар суралцав.



Зураг 57. “Цайны ёслол” багшаар заалгаж буй байдал



Зураг 58. “Япон орныг хэн сайн мэдэх вэ?”
Асуулт, харилулын тэмцээний үеэр

Зөвхөн цайны ёслолын талаар мэдэж авахаас гадна “Япон орныг хэн сайн мэдэх вэ?” Асуулт хариултын тэмцээн явуулж, ялагчийг тодруулан шагнал гардууллаа. Оролцогчид нэгэн амралтын өдрийг сурсан мэдсэн зүйлтэй өнгөрүүлсэндээ тун сэтгэл хангалуун байгаагаа санал асуулгын хуудсанд бичсэн байсан нь бидэнд цаашид ч соёлын талаарх танилцуулга, сургалтыг

үргэлжлүүлэн хийх урам зоригийг өгсөн юм.

Энэ жил бид 11-р сард зохион явуулсан 85 дахь удаагийн нээлттэй семинарт монголчуудын өдөр тутмын энгийн боловч нэгэн чухал хэрэглээ болсон эсгий, эсгий эдлэлийн талаар яриулахаар Монгол Улсын зөвлөх инженер, дэд профессор Б.Эрдэнэцэцэг багшийг зочноор урин оролцууллаа. Багшийн япон хэлээр хэвлүүлэн гаргасан “Монгол эсгий эрт, эдүгээ” номыг танилцуулахын хамт эсгий хийх технологийн талаар ойлголттой болж, гол нь ирсэн оролцогчид өөрийн биеэр эсгий урлал хийж үзэн сонирхсон нь тун онцлог сайхан семинар болж өнгөрлөө.



Зураг 59. 85-р нээлттэй семинар “Эсгийгээр урлахуй”

Мөн бид 11-р сард хэлтсээрээ хамтран нэгэн соёлын ажил зохион байгуулсан нь “Монгол уран бичлэг” тусгай сургалт байлаа. Монгол бичгийн хэрэглээ нэг үеэ бодоход сэргэн төрийн бичиг хэрэг хөтлөлтийн хэмжээнд ирж, олон нийт ч ач холбогдол өгөн



Зураг 60. “Монгол уран бичлэг”
тусгай сургалтын явцаас

сурах, бичиж үзэх хүсэлтэй байгаа нь бидний зохиосон ажлаас харагдаж байв. Бид тус тусгай сургалтыг 11-р сарын 25-ны өдрийг сонгон зохион байгуулсан нь улс тунхагласны өдөр буюу Монгол бахархлын өдөрт зориулсан юм. “Бичиг соёл төв”-ийн монгол бичгийн багш, уран бичээч Э.Анхбаярыг урин монгол бичгийн үүсэл



гарал, уран бичлэгийн талаарх сонирхолтой мэдээлэл авч, бийрээ хэрхэн барих, бэх нянтайгаа хэрхэн нийлэх зэргийг заалгалаа. Хүрэлцэн ирсэн хүмүүс бүгд өөр өөрсдийн дуртай үгсээ бийр бэх нийлүүлэн бичин авч өөртөө дурсгал болгон хадгалж авцгаалаа. Мэдээж ганцхан удаагийн бичилтээр шууд бичих хэцүү байсан ч бүгд хичээнгүйлэн хэдэнтээ оролдсоор өөрсдийн хүссэн бичвэрээ бүтээн энэ өдрийн үйл ажиллагаа амжилттай өндөрлөлөө. Бид цаашид ч аливаа соёлын арга хэмжээг зохион байгуулахдаа зөвхөн сонсоод, хараад өнгөрөх биш өөрийн биеэр хийж үзэн, оролцоог нэмэгдүүлсэн байдлаар хийхээр төлөвлөж байна.



V. ЕРӨНХИЙ УДИРДЛАГЫН ТАСАГ



I. 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ ТАЙЛАН

Ерөнхий удирдлагын тасаг нь төвийн санхүү хөрөнгийн удирдлага, хүний нөөц, мэдээлэл технологи, аж ахуй, албан бичиг хөтлөлт, цэвэрлэгээ үйлчилгээ, харуул хамгаалалтын зохицуулалт гэсэн үндсэн ажлуудыг 2025 онд 91%-ийн гүйцэтгэлтэйгээр амжилттай зохион байгуулж ажиллалаа.

Бид дотоод нөөц бололцоогоороо төвийн барилга байгууламжийн засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж, төвийн ажилтнууд болон төвөөр үйлчлүүлэгчдийн аюулгүй, тайван орчинд ажиллаж үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллалаа. Энэхүү ажлын бүтээмж өндөр гүйцэтгэлтэй гарсан нь төвийн хамт олны хичээл зүтгэл, хамтын ажиллагааны үр дүнтэй салшгүй холбоотой.

2025 онд гүйцэтгэсэн засварын болон бусад ажлууд

| Хийгдсэн ажлууд | 2025 оны төлөвлөгөө | 2025 оны ХБГ |
|---|--|--|
| Японы их сургуулийн оюутны дадлага | Кансэй гакуин их сургууль- 1 хүн Тоохокү бунка их сургууль- 4 хүн | Кансэй гакуин их сургууль- 1 хүн Тоохокү бунка их сургууль- 2 хүн Тоёо их сургууль-4 |
| Монгол улсын их сургуулийн оюутны дадлага | Ази судлалын тэнхим – 4 оюутан | Ази судлалын тэнхим – 4 оюутан ШУТИС-1 |
| Японд суралцах талаарх зөвлөгөө | 68 хүн | 83 хүн |
| Япончуудад зориулсан анхан шатны монгол хэлний сургалт | 7 хүн хамрагдсан | 3 хүн |
| Power Bi сургалт | 15 хүн хамрагдсан | 23 хүн |
| Вакаяма мэргэжлийн сургууль Монголтой танилцах аялал Ямагата мужийн айлчлал | - | 6 хүн 30 хүн |
| Сургалтын хөгжлийн хөтөлбөрийг бий болгох /Карьер хөгжлийн төлөвлөгөө батлуулах/ | - | Хөтөлбөрийн хороо байгуулахаар ажлын хэсгийн уулзалтаар хэлэлцэж байна |
| Хөтөлбөрийн чанар, баталгаажуулалтын хорооны журам батлуулах | - | |
| Сургалтын төлбөрийг тодорхойлох аргазүйг оновчлох | - | |



Танхим ашиглуулсан байдал

Хүснэгт-19: Байгууллагаар

| № | Зохион байгуулагч | Үйл ажиллагааны тоо (удаа) |
|-------------|---|----------------------------|
| 1 | Япон Улсын Элчин Сайдын Яам | 4 |
| 2 | Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны байгууллага ЖАЙКА | 13 |
| 3 | Монгол Улсын Их Сургууль | 9 |
| 4 | Монголын Япон хэлний багш нарын холбоо | 2 |
| 5 | Бусад байгууллага | 54 |
| Нийт | | 82 |

Эх сурвалж: Монгол-Японы Төв, Ерөнхий удирдлагын тасаг

Сүүлийн 7-н жилийн гаднаас зохион байгуулсан үйл ажиллагааны тоо




График-4. Сүүлийн 3 жилийн гаднаас зохион байгуулсан үйл ажиллагааны чанарын үзүүлэлт





График-5. Байнгын үйлчлүүлэгч жилд 2-оос дээш удаа үйлчлүүлэгч



Дээрх ажлуудыг ЖАЙКА, Япон сан болон МУИС-ийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн удирдлага заавар, бүх талын дэмжлэгээр хийж гүйцэтгэсэн. Доорх үзүүлэлтээс харахад үйл ажиллагаа зохион байгуулсан тоо буурсан ч сургалтын болон , бусад үйл ажиллагааны оролцогчдын тоо улам нэмэгдэх хандлагатай байна.

График-6. Сүүлийн Сүүлийн 5 жилийн төвийн үйлчлүүлэгчийн тоо 2025 оны 12-р сарын 31 хүртэл нийт: 2,809,350 хүн (давхардсан тоо)





II. ОНЦЛОХ МЭДЭЭ

1) Ажлын хэсэг

МУИС-ийн журмуудад гарсан өөрчлөлтийн дагуу, захирлын 2025.01.15-ны №02 тушаалаар “Монгол-Японы төвийн журмуудыг шинэчлэн боловсруулах ажлын хэсэг”-ийг байгуулж, ажлын хэсгийн уулзалтыг ажилтнуудынхаа саналын дагуу 2 долоо хоногт 1 удаа хийж, журмуудыг шинэчлээд явж байна.

- Батлуулсан журмууд:

“Хөдөлмөрийн дотоод журам”

“Ажилтны ажлын үнэлгээ, урамшуулал, шагналын журам”

“Баталгаат орчуулгын журам”

“Кайзэн үнэлгээний журам”

2) Монголтой холбогдсон 50 жил семинар

Япон улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд асан Шимизү Такэноригийн Монгол улстай холбогдож ажиллаж эхэлснээс хойшхи 50 жилийн ойг тэмдэглэн энэхүү арга хэмжээг зохион байгууллаа. Семинарын үеэр Шимизү сан Монгол Улстай холбогдсон өөрийн намтар, үйл ажиллагааны талаар танилцуулж, сонирхолтой илтгэл тавив.



Зураг 61. Япон улсаас Монгол Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд асан Шимизү Такэнори

Семинарын төгсгөлийн хэсэгт оролцогчид мөн Шимизү гуайн талаар өөрсдийн дурсамжийг хуваалцаж, хоёр улсын харилцаанд оруулсан түүний үнэтэй хувь нэмэр болон гүйцэтгэсэн олон ажил үйлсийг онцлон тэмдэглэв.



Зураг 62. Семинарын оролцогч МУАЖ Д.Сосорбарам



VI. БАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Япон хэлний сургалтын хэрэглэгдэхүүн

Сургалтын хэрэглэгдэхүүнийг хичээл тус бүрээр өнгөөр ялган байрлуулсан

- Ягаан өнгө: Цогц сургалт-1
- Улбар шар өнгө: Цогц сургалт-2
- Ногоон өнгө: Цогц сургалт-3 гэх мэт


ТАЙЛАН
МОНГОЛ-ЯПОНЫ ХҮНИЙ НӨӨЦМИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ

АРХАНГАЙ АЖАЛГАА
2023.08

Монгол-Японь хүний нөөцийн хөгжлийн төв

СПОРТ ОЛОНДОО 2025

Z Flip5



2025 ОНЫ БАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Монгол-Японы төвийн нийт ажилтнууд өөрийн хариуцсан ажлаас гадна төвийн нийт үйл ажиллагааны сайжруулалт болон ажилтан хоорондын харилцааг сайжруулах, өөрийгөө хөгжүүлэх зорилгоор хэд хэдэн багт хуваагдан ажиллаж байна. 2024 онд тасаг бүрийн ажилтны төлөөлөөс бүрдсэн “Маркетинг баг”, “5S Кайзэн баг”, “Эрүүл мэнд, спортын баг”, “Үйл ажиллагаа зохион байгуулах баг”, “Харилцан туслалцах баг” гэсэн 5 баг тус тусын үйл ажиллагааг амжилттай зохион байгууллаа.

Ингэснээр ажилтан хоорондын багийн ажиллагаа, уялдаа холбоо сайжрахаас гадна шинийг санаачлах, өөрийгөө шинээр нээх боломжтой болж байна.

1. МАРКЕТИНГИЙН БАГ

Тус баг нь Монгол-Японы төвийг олон нийтэд таниулахын зэрэгцээ төвөөс явуулж байгаа сургалт, үйл ажиллагаанд хамрагдах суралцагч, оролцогчдын тоог өсгөх, тогтоон барих зорилготойгоор 2016 онд анх тасаг бүрийн төлөөлөгч 4 гишүүнтэйгээр байгуулагдаж, 2025 байдлаар 6 гишүүнтэйгээр амжилттай үйл ажиллагаа явуулж байна.

2025 оны үйл ажиллагааны тойм:

| № | Огноо | Үйл ажиллагаа | Тайлбар |
|---|---------|---|--|
| 1 | 2025.04 | Төвийн арван долоодугаар тайлан | Тухайн жилийн үйл ажиллагааг тайлан болгон гаргадаг бөгөөд 2025 оны 17 дахь удаагийн тайланг гаргалаа. |
| 2 | 2025 | Төвийн бүхий л үйл ажиллагааны постер танилцуулга | Тухайн жилийн төвийн бүхий л үйл ажиллагааны постер танилцуулга нийт 200+ баннер болон станд 20 гаруйг өөрсдийн дотоод нөөц бололцоонд тулгуурлан хийж гүйцэтгэжээ. Ингэснээр бид 4.000.000₮-н хэмнэлт хийж 7-н сая гаруй төгрөгийн орлого олж чаджээ. |
| 3 | 2025 | Сошиал маркетинг | Фейсбүүк дагагчийн тоо 15%-р өсөж 73000-д хүрсэн бол инстаграмм ивэхтэйгээр хөтлөн дагагчдын тоо 1500д хүргэлээ. 4200 гаруй чатад хариу мэдээлэл өгч, нүүр хуудас болон г рүпд ирсэн 10 гаруй халдлагаас сэргийлж чадлаа. |



| | | | |
|---|------|---------------|--|
| 4 | 2025 | Багийн гишүүд | Багт шинээр орсон гишүүд багийн үйл ажиллагааг гүйцэд ойлгож чадалгүй гарах тохиолдол байсан тул багийн хуучин гишүүд зөвлөхөөр ажиллаж өөрсдийн хийсэн болон хийхээр төлөвлөсөн ажлыг амжилттайгаар үргэлжлүүлж чадлаа. |
|---|------|---------------|--|

2. 5S КАЙЗЭН БАГ

Монгол-Японы төв 2016 оноос эхлэн 5S Кайзэн хөдөлгөөнийг тасралтгүй хэвшил болгон хэрэгжүүлсээр ирсэн билээ. Ажилтнуудын сайн дурын санаачилгаар байгуулагдсан “5S Кайзэн” баг нь эрэмбэ, эмх цэгц, цэвэрлэгээ, цэвэр цэмцгэр зэрэг 5S-ийн үндсэн зарчмуудыг хэвшүүлэхээс эхлээд, төвийн хэмжээнд төрөл бүрийн сайжруулалтын санал, санаачилгыг бодитоор хэрэгжүүлэх хүртэл өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Энэ жилийн хувьд 4 тасгийн 7 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр “Суралцъя, сайжруулъя, түгээе” уриан дор үйл ажиллагаа явууллаа.

Онцлох ажил

1. Кайзэн саналын үнэлгээний шалгуурыг тогтоох

Өдийг хүртэл ажилтнуудын санаачилсан кайзэн саналыг жил бүр харилцан адилгүй шалгуураар үнэлж ирсэн тул 2025 онд үнэлгээний стандартыг тодорхой болгохыг чухалчлав. Өнөөг хүртэл хуримтлуулсан туршлагадаа үндэслэн үнэлгээний стандартыг боловсруулж, мэргэжилтний зөвлөгөөг нэмж тусгасны дараа бүх ажилтнуудын хурлаар хэлэлцүүлэн “Кайзэн үнэлгээний журам”-ыг батлав. 2026 оноос эхлэн ажилтнуудын санаачилсан кайзэн саналыг жилд 2 удаа үнэлж, жилийн эцэст нэгдсэн үнэлгээнд тулгуурлан урамшуулал олгох байдлаар энэхүү журмыг хэрэгжүүлэхийг зорьж байна.

✓ Кайзэн саналыг дараах 5 шалгуурын дагуу 1–5 оноогоор дүгнэнэ.

| Шалгах үзүүлэлт | Үнэлгээ |
|---|-------------------|
| 1. Төвийн стратегийн зорилгод чиглэсэн эсэх | 1 • 2 • 3 |
| 2. Төвийн үйл ажиллагаанд хэр ач холбогдолтой эсэх | 1 • 2 • 3 • 4 • 5 |
| 3. Асуудлыг оновчтой, бүтээлч байдлаар шийдсэн эсэх | 1 • 2 • 3 • 4 • 5 |
| 4. Хэрэгжүүлэхийн тулд зүтгэл гаргасан байдал | 1 • 2 • 3 • 4 • 5 |
| 5. Өдөр тутмын үйл ажиллагаанд нэвтэрсэн эсэх | 1 • 2 • 3 • 4 • 5 |
| Нийт оноо | /25 |



Тайлбар: Кайзэн гэдэг нь шинэ бүтээл, оновчтой санааг амьдралд хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулах үйл явц

Зураг 63. Кайзэн үнэлгээний журмын хэсгээс



| D. Хэрэгжүүлсэн Кайзэн /実施改善 | | | | | | | |
|------------------------------|---------------|--|----------------------------|----------------------------|-------------------|------------------|---------------------------------|
| № | Ажлын нэр/業務名 | Хэрэгжүүлсэн Кайзэнгийн үр ашгийг 効果 /時間数及び金額 など/ | Эхэлсэн огноо/開始年 月日 | Дууссан огноо/終了年 月日 | Төлөвлөгөө /計画 | Гүйцэтгэл/ 実績 | Тайлбар/備考 (研修受注者お よび研修の満足度) |
| 1 | | | | | | | |
| 2 | | Цаг хэмнэсэн 時間節約 | | | | | |
| 3 | | Зардал хэмнэсэн コスト削減 | | | | | |
| 4 | | Орлого нэмсэн 収入増加 | | | | | |
| 5 | | Бусад その他 | | | | | |
| 6 | | | | | | | |
| 7 | | | | | | | |
| 8 | Нийлбэр | | | | 0 | 0 | |

Зураг 64. Хэрэгжүүлсэн Кайзэнгийн үр ашгийг тэмдэглэж оруулах формат

2. “Эерэг хандлага-Өндөр бүтээмж” аяны хэрэгжилт

Хамт олны дунд талархлын аян өрнүүлэх “Талархлын захидал” буланг шинэчилж, ажлын байранд таатай уур амьсгал, эерэг орчин бүрдүүлэхийг зорин ажиллалаа.



Зураг 65. Талархлын захидлын шинэ загвар

3. Ажилтнуудын санал санаачилгыг идэвхжүүлэх хэлэлцүүлэг

Ажилтнуудын санал санаачилгыг идэвхжүүлэх зорилгоор хэлэлцүүлэг, семинарыг 2 удаа зохион байгуулав. Түүнчлэн санал ирүүлэх үйл явцыг хялбаршуулахын тулд санал авах QR код байрлуулах зэрэг санаачилга гаргасны үр дүнд 2025 онд ажилтнуудаас 31 сайжруулах санал цуглуулж, тус төвийн эмх цэгц ба үйл ажиллагаа сайжруулалтад хувь нэмэр оруулан ажиллав.

4. Олон нийтэд чиглэсэн үйл ажиллагаа

Кайзэн үйл ажиллагааны хэрэгжилттэй холбоотой хуримтлуулсан туршлагаа ашиглан ирээдүйд эрэлтэд нийцсэн сургалт, семинар төлөвлөн зохион байгуулах зорилго тавьж, 2025 онд эхний алхмаа хийлээ.

5S кайзэн багийн 2 гишүүн дотоод нөөц бололцоогоо ашиглан тус төвийн бизнесийн сургалтад оролцож, “Кайзэн, 5S хөдөлгөөн”-ий талаарх мэдлэг тэлэхийн хамт сурсан



зүйлээ шинэ ажилтнуудад дамжуулав. Түүнчлэн бизнесийн сургалтын тасгаас явуулсан семинарын зохион байгуулалтад туслах үүргээр оролцов. Улмаар, тус төвд хэрэгжиж буй кайзэн хөдөлгөөний тухай төвийн цахим хуудас болон фэйсбүүк хуудсаар дамжуулан олон нийтэд чиглэсэн мэдээлэл хүргэн ажиллалаа.



Зураг 66. Ажилтнуудад зориулсан семинар



Зураг 67. Семинарын үр дүн

3. ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН БАГ

Зорилго:

Нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх замаар ажилчдын харилцаа холбоог сайжруулах, эрүүл амьдралын хэмнэлийг хэвшүүлэхэд оршино.

2025 онд хийгдсэн ажил:

| No | Хэзээ | Үйл ажиллагааны нэр | Хаана | Бусад |
|----|-----------------------|---------------------------------|----------------------------------|---|
| 1 | 1 сар-12 сар 8:55~ | Өглөөний дасгал | Хүлээлгийн танхим | Тогтмол явуулах, ажлын байрны дасгал нэмэгдэн мягмар болон пүрэв гарагуудад хийж хэвшив |
| 2 | 5 сар | Төгсөгчдийн спортын арга хэмжээ | Монгол Япон төв, МУИС спорт заал | Төвийн ажилтнууд болон бизнесийн сургалтын төгсөгчдийн дунд 3 төрөлт тэмцээн зохион байгуулав |



| | | | | |
|---|---------------|--|----------------------------|--|
| 3 | 2 сар, 12 сар | Эм болон бусад хэрэгтэй зүйлсийн худалдан авалт | | Эмийн санд дууссан эмийг болон бусад хэрэгцээт зүйлсийг худалдан авч эмийн шинэчлэлт хийв. |
| 4 | 1 сар-12 сар | Сургалт семинар болон төвийн ажилтнуудын дундах тэмцээнүүд | Их танхим, 205 тоот танхим | Өөртөө орц нэмье, Японы уламжлалт аарцаг нурууны бариа сэдэвт сургалтыг багш урин зохион байгуулав |
| 5 | 1 сар | Багш ажилтны спортын их наадам | МУИС спорт заал | МУИС багш ажилтны спортын их наадамд амжилттай оролцож багийн дүнгээр хоёрдугаар байранд оров. |